



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

УРЬДЧИЛСАН
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар
2020

ННА 67
ДАА 340
Э-739



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ГҮЙЦЭТГЭГЧ: ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО СУДАЛГААНЫ ТӨВ ТББ

ЗӨВЛӨХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Багийн ахлагч: Хуульч, судлаач Д.Тэгшбаяр

Судлаачид: Эдийн засагч, судлаач С.Боргил

Хуульч, өмгөөлөгч, судлаач А.Дэлгэрмаа

Мэргэжилтэн О.Одонтуяа

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг шууд илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9574-5-2

АГУУЛИГА

1. УДИРТГАЛ	5
1.1. Судалгааны зорилго.....	6
1.2. Судалгааны арга зүй	7
1.3. Судалгааны баг, тайлангийн бүтэц.....	8
2. МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	9
2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ.....	9
2.2. Өнөөгийн нөхцөл байдал.....	11
2.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл.....	14
2.3.1. Салбарын эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд учирч буй эрсдэл.....	14
2.3.2. Авлига болон бусад гэмт хэргийн эрсдэл.....	17
2.3.3. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага.....	20
2.4. Хүчин төгөлдөр хууль тогтоомж, олон улсын стандартын хүрээнд хүрсэн үр дүн, үүсэж буй хүндрэл.....	24
2.4.1. ОУИТБС-ын хэрэгжилт, үүсэж буй хүндрэл.....	31
2.4.2. Шүүхийн практикт үүсэж буй хүндрэл	38
2.4.3. Татварын байгууллага, улсын бүртгэл дээр үүсэж буй хүндрэл	39
2.5. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд	41
2.6. Салбарын мэргэжилтнүүдийн дунд хийсэн хэлэлцүүлэг болон тухайн асуудалд хамаарах этгээдүүдээс авсан судалгааны тойм.....	44
3. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫН ТОМЬЁОЛОЛ	46
3.1. Хуулийн төслийн хүрээнд тавих зорилго	46
3.2. Хуулийн төслийн хүрээнд тавих зорилт.....	46
3.3. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт.....	47
4. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНОВЧТОЙ ХУВИЛВАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ.....	53
4.1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай анхдагч хууль.....	53
4.2. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.....	54

4.3. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал.....	55
5. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	61
6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	62
6.1. Дүгнэлт.....	62
6.2. Зөвлөмж.....	66
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	77
7. ХАВСРАЛТУУД.....	79
7.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	79
7.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө.....	82
7.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө.....	90
7.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.....	96
7.5. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа.....	100
7.5.1. Ерөнхий мэдээлэл.....	100
7.5.2. Олон улсын олборлох салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж.....	102
7.5.2.1. Канад Улсын Олборлох салбарын ил тод байдлыг хангах хууль.....	102
7.5.2.2. Европын холбооны ил тод байдлын тухай хууль.....	105
7.5.2.3. Украины Олборлох салбарын ил тод байдлыг хангах тухай хууль.....	108
7.5.3. Дүгнэлт.....	112
7.5.4. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулиар ОҮИТБС-ын дагуу ил тод болгох мэдээлэл, баримтлах зарчим.....	114
7.6. ОҮИТБС-ын стандартын шаардлага Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл (2014 он) болон Уул уурхайн тухай хуулийн төсөл (2017 он)-д тусгагдсан байдал.....	124

1. УДИРТГАЛ

Эрдэс баялгийн нөөц ихтэй хэдий ч сул засаглалтай улс орон “Баялгийн хараал”¹-д өртөх магадлал өндөр, байгалийн баялаг багатай улс орнуудтай харьцуулахад дотоодын зөрчилтэй, авлига, хээл хахуульд өртөмтгий, эдийн засгийн өсөлт удаан бөгөөд хөгжил тогтворгүй байх нь түгээмэл байдгийг олон улсын хэд хэдэн байгууллагын судалгаа, дүн шинжилгээ харуулжээ.²

Баялгийн хараал хэмээх энэхүү үзэгдлийг тойрон гарах зорилгоор дэлхийн цөөнгүй улс орон болон олон улсын байгууллагуудын зүгээс удаан хугацаанд төр, хувийн хэвшлийн ил тод байдлыг нэмэгдүүлж, хариуцлага, засаглалын механизмыг боловсронгуй болгон бэхжүүлж, туршиж, сайжруулсаар ирсэн байдаг. Энэ бүх үр дүнгээс харахад тогтолцоог сайжруулах хамгийн өгөөжтэй арга хэмжээ нь ил тод байдлыг хангах, хяналт ба тэнцвэржүүлэлт (“check & balance”)-ийг хэрэгжүүлэх, улмаар тухайн улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах гэдгийг зарим улсын жишээ нотолж байна.³

Дээрх бодлогын гол зорилго нь эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжлийг хангах буюу “салбарын хөгжлийг дэмжих - эдийн засагт орох үр өгөөжийг бодитоор хуримтлуулж, нийгмийн хэрэгцээнд зөв, зохистой зарцуулах - байгаль орчны тэнцвэрийг хадгалах” зорилтуудыг нэгэн зэрэг хангах явдал юм. Олборлох салбарын үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж, улсын төсөвт татварыг зохистой түвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг

¹ “Баялаг элбэг байхын парадокс” гэх нь бий

² The Resource Curse: The political and Economic Challenges of Natural Resource Wealth, NRG1 2015; Extractive sector and illicit financial flows: What role for revenue governance initiatives? Philippe Le Billion, Anti-Corruption Resource Center, 2011;

³ Government and Citizen Oversight of Mining: Enforcing the Rules, Erin Smith, Revenue Watch 2011;

бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон хариуцан тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага манай улсад төдийгүй бусад улсад тулгарч байна.

Төрийн байгууллагууд, тус салбарын компаниудын үйл ажиллагааг иргэд, олон нийт, хөрөнгө оруулагчид, эрдэмтэд, судлаачдад ойлгомжтой, нээлттэй, ил тод болгосноор салбарын хариуцлага болон засаглал сайжирч, төрийн бодлого судалгаа, дүн шинжилгээ, бодит тооцоололд суурилж, улмаар үр ашиг нэмэгдэнэ гэж үздэг. Мөн иргэд өөрийн амьдарч буй орон нутагт ямар аж ахуйн нэгж, хэдий хугацаанд, ямар үйл ажиллагаа гүйцэтгэх, түүнийг зөвшөөрсөн баримт бичиг, үндэслэлийг аль албан тушаалтан баталсан зэргийг асуух, мэдэх эрхтэй. Түүнчлэн, энэхүү үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, газар, ус, эрдэс баялгийг хэдий хэмжээгээр ашиглаж, улсын төсөвт ямар хэмжээний татвар төвлөрүүлэх, тухайн орон нутагт бий болох бодит үр өгөөж, хувь нэмэр ямар байх, уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийг хийх хариуцлагыг хэн хүлээх, төр хяналтаа үр дүнтэй тавьж чадах эсэх зэрэг олон чухал мэдээллийг иргэд олж авснаар төр, иргэн, аж ахуйн нэгж хоорондын мэдээлэл нэмэгдэж, харилцан ойлголцол бүрдэх боломжтой.

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандаж судлах ажлын зорилго нь тус салбарын ил тод байдлыг дээд зэргээр хангаж, улмаар ил тод байдлын үндэсний стандарт, практикийг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) зэрэг олон улсын сайн туршлагад нийцүүлэн нэвтрүүлэх зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлох явдал юм. Тэрчлэн, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг санал болгоход судалгааны зорилго мөн чиглэнэ.

1.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасан хуулийн шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан ажилласан болно. Түүнчлэн “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын үе шатуудыг тусгайлан анхаарч хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Асуудалд дүн шинжилгээ хийх;
- Асуудал шийдвэрлэх зорилгыг томъёолох;
- Асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, харьцуулан судлах;
- Хуулийн зохицуулалтын үр нөлөөг ерөнхийд нь тандан судлах;
- Зөвлөмж боловсруулах зэрэг орно.

Судалгааг гүйцэтгэхдээ олборлох салбарын ил тод байдлыг хангах талаар Монгол Улсад хэрэгжиж ирсэн төрийн бодлого болон сайн туршлага, олон улсад өрнөж буй санал санаачилгууд, бусад улс орны хууль тогтоомж зэргийг судлахын сацуу тус салбарын бодлогыг боловсруулахад оролцогч мэргэжилтнүүдээс тусгайлан мэдээлэл авлаа. Ялангуяа ОҮИТБС-ыг олон улсад болон Монгол Улсад хэрэгжүүлэх явцад бэлтгэгдсэн баримт бичгүүд, шийдвэр гаргахад оролцож ирсэн төр засаг, компани, иргэний нийгмийн төлөөллийн туршлага, саналыг уг тайланд тусгахыг зорилоо.

1.3. СУДАЛГААНЫ БАГ, ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Нээлттэй Нийгэм Форум нь олборлох салбарын ил тод байдлыг дэмжих, тухайлбал ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон бусад талтай хамтран ажилладаг бөгөөд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажилд ч дэмжлэг үзүүлж ирлээ. Хууль тогтоомж, бодлого судалгааны төв ТББ хуульчид, эдийн засгийн зөвлөх мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх баг бүрдүүлэн Нээлттэй Нийгэм Форумтай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, энэхүү тандалт судалгааны ажлыг хэрэгжүүллээ.

Энэхүү ажлын хүрээнд Зөвлөх баг Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, улмаар бие даасан хууль болгож батлуулахын хэрэгцээ, шаардлагыг судлан үр дүнг боловсруулан энэхүү тайлангаар уншигч Та бүхэнд хүргэж байна. Тайлангийн хоёрдугаар хэсэгт олборлох салбарын ил тод байдлыг хангах асуудлын мөн чанар, хамрах хүрээ зэргийг тодорхойлж, өнөөдөр тулгамдаад буй асуудлыг шинжилсэн бол гуравдугаар хэсэгт ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд юу хийж болох тухай санал дэвшүүлж, улмаар дөрөвдүгээр хэсэгт ил тод байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн хүрээнд хийж болох өөрчлөлтүүдийн талаар тайлбарлан үр нөлөө ямар байх талаар судалсан дүнгээ танилцуулав. Түүнчлэн тайлангийн тавдугаар хэсэгт бусад улс оронд олборлох салбарын ил тод байдлыг хангах чиглэлээр хийгдэж ирсэн хууль эрх зүйн шинэтгэлийг дүгнэж, улмаар Монгол Улсын хувьд юу хийж болох талаарх дүгнэлт, зөвлөмжүүдийг зургадугаар хэсэгт танилцууллаа. Тус судалгааны тайлан бэлтгэхэд ашигласан зарим мэдээллийг хавсралтуудаар буюу долдугаар хэсэгт оруулав.

2. МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭ

Эрдэс баялгийн компаниуд нь тусгай зөвшөөрлийн хүрээнд орон нутгийн удирдлага, төрийн эрх бүхий байгууллагатай олон тооны гэрээ байгуулж, Монгол Улсын Үндсэн хуулиар “ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад” байхаар заасан, “төрийн нийтийн өмч”⁴-д тооцогдох газрын хэвлийн баялгийг эрж, хайж, олборлож, боловсруулж, борлуулах үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой. Төрийн байгууллагын шийдвэр, үйлчилгээ олон нийтэд тэр бүр ил тод, нээлттэй байж чадаагүй явж ирснээр тус салбарт авлигын болон ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл бодитой оршиж, салбарын үр өгөөж иргэдэд мэдэгдэхуйц хүрэхгүй байгаа нь нийгэмд шүүмжлэл болон эсэргүүцэл дагуулж ирсэн билээ. Ялангуяа эрдэс баялгийн салбарыг иргэд онцлох болсон нь эдийн засагт оруулах өгөөж өндөр байх боломжтой, мөн орон нутаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь иргэдийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, амьдрах нөхцөл зэрэгт өндөр эрсдэл үүсгэж байгаатай холбоотой. Түүнчлэн эрдэс баялгийн салбарын бодлого, түүний хэрэгжилт олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг тул намууд болон улс төрчид улс төрийн өрсөлдөөндөө популист амлалт өгч, улмаар нийгэмд тэр бүр өгөөж өгөхгүй бодлого хэрэгжүүлэхэд хөтөлж байна.

Монгол Улс тус салбарын үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд нийгэмд үүсээд буй хэрэгцээ шаардлагыг тооцохын зэрэгцээ олон улсын шилдэг туршлагаудыг нэвтрүүлэх ажлыг ч эртнээс хийж эхэлсэн билээ. Үүний нэг жишээ нь олборлох салбарын засаглалыг сайжруулах, төр болон хувийн

⁴ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, 2019

хэвшлийг хариуцлагажуулах, улмаар уг салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой, өдгөө дэлхийн 52 улс орныг эгнээндээ элсүүлсэн ОУИТБС-д 2007 онд нэгдэн орсон явдал юм. Цаашлаад 2013 онд Нээлттэй засаглалын түншлэл (НЗТ)-д нэгдэж, төрийн үйл ажиллагааг ухаалаг, нээлттэй, ил тод болгох, төрийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх алхмуудыг хэрэгжүүлж байгаа билээ. НЗТ-ийн Үндэсний төлөвлөгөөнд олборлох салбарт гэрээ ба ашиг хүртэгч эцсийн өмчлөгчдийн мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тусган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалт аваад байна.

Ялангуяа ОУИТБС нь салбарын оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдгээрийн харилцааг тогтолцооны хувьд тэнцвэржүүлэн сайжруулах, олон улсын болон дотоодын хамтын ажиллагааг сайжруулах хамгийн үр дүнтэй стандарт болж байна. Тиймээс ч тус санаачилгын гишүүн орны тоо жилээс жилд нэмэгдэн салбарын компани, тэднийг санхүүжүүлэгчид анзаарч, идэвхтэй хэрэгжүүлэхийн сацуу төр засгийн хувьд шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх чухал стандарт болохыг хүлээн зөвшөөрч, дотоодын хууль тогтоомждоо санаачилгын зарчим, шаардлагуудыг тусгах ажлыг идэвхтэй хийж байна. Хамгийн гол нь баялаг ихтэй улс орны иргэд ОУИТБС-ын хүрээнд ил болсон мэдээллийг ашиглан төр засаг болон компаниудаас хариуцлага нэхэж, улмаар үүсэж буй хүндрэл бэрхшээлийг бодитой мэдээлэлд тулгуурлан шийдэх төрийн бодлогод нөлөөлөх боломж жилээс жилд нэмэгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Олон улсын болон дотоодын санал санаачилга, бодлого хоорондын уялдааг хангах хүрээнд ч ахиц дэвшил гарч байна. 2017 онд ОУИТБС болон НЗТ нь олон улсын түвшинд санамж бичиг байгуулж, авлигын эсрэг тууштай тэмцэхээ илэрхийлж, гишүүн орнууд нийтлэг стандартыг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь авлига, хээл хахууль, мөнгө угаах

зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд чухал алхам болно гэж үздэг⁵. Эрдэс баялгийн нөөц ихтэй улс орны хөгжлийн замд учрах эрсдэлийг бууруулах, тулгарах бэрхшээлийг тойрон гарахад ОҮИТБС зэрэг урт хугацаанд боловсронгуй болж ирсэн стандартыг авч хэрэгжүүлэх, нөгөө талаар дотооддоо хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэж ирсэн туршлагаа нэгтгэн тусгаж, тус салбарын ил тод байдлыг хангах нь байгалийн баялгийн эзэн болсон Монгол Улсын иргэдийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн алхам болно гэж үзэж буй⁶.

2.2. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”* гэж мөн зүйлийн 2 дахь хэсэгт *“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”* гэж тус тус заасан ба Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд *“төрийн нийтийн өмч”* гэж тодорхойлсон.

Дээрх хуулийн заалтын дагуу төр нь байгалийн баялгийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр бусдад ашиглуулах замаар бий болсон үр өгөөжийг татвар, хураамж болон бусад зохицуулалтын арга хэрэгслээр ард иргэдэд хүртээх зарчмаар ажилладаг. Энэхүү үйл явц нь олон шат дамжлагатай, урт удаан хугацаанд үргэлжилдгээс гадна олон байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн оролцоонд тулгуурладаг. Энэ олон хүчин зүйлийн дунд

⁵ The EITI and OGP (Open Government Partnership) recently signed a memorandum of understanding (MoU).

⁶ УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.1. Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд баримтлах чиглэлтэй нийцсэн, шаардлагатай арга хэмжээг авахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээ болохоор байна.

эрдэс баялгийн хайгуул, олборлолт, борлуулалт, үр өгөөжийн хуваарилалт ихэвчлэн нууц, ил тод бус явагдаж ирсэн байх тул байгалийн баялгийн үр шимийг иргэд хүртэж байгаа эсэхийг мэдэх бололцоо хомс байв. Ийм байдал цаашид удаан үргэлжлэх боломжгүй болохыг дотоод, гадаадад өрнөж буй үйл явдлууд, иргэдийн шаардлага илтгэн харуулж байна.

Монгол Улс зах зээлд өндөр эрэлт хэрэгцээтэй зэс, алт, төмөр, занар, уран, молибден, нүүрс, газрын тосны арвин их нөөцтэй орон юм. Улмаар тус салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах бодлогоо оновчтой хэрэгжүүлж чадвал олон улсын зах зээлд томоохон экспортлогч болох боломжтой.

Олборлох салбар Монгол Улсын ДНБ-ий 20-30 орчим хувийг дангаараа хангаж, эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болсоор ирсэн. Нөгөө талаар, олборлох салбарын эдийн засгийн бусад салбарт үзүүлэх нөлөө их. Тухайлбал, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэнээс шатахууны худалдаа өссөн, өрхийн зээл олголт нэмэгдэж хэрэглээ өссөн зэргийг дурдаж болно. Түүнчлэн тус салбарын өсөлтийг дагаад улсын татварын орлого нэмэгдсэн. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын 98.5 хувь буюу нийт экспортын 83 хувийг эзэлж байна.⁷ Мөн аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд уул уурхай, олборлох салбар 71.7 хувийг, экспортын бүтээгдэхүүний 87 хувийг тус тус бүрдүүлж байна. Тэрчлэн уул уурхайн салбар 2013-2015 онд төсвийн орлогын 21-23 хувийг бүрдүүлж байсан бол 2018 оны байдлаар 26, 2019 оны эцсээр 30 орчим хувьд хүрчээ. Олборлох салбар нь тогтвортой ажлын байраар шууд 14,000 гаруй, дам байдлаар 20,000 гаруй хүнийг хангаж байна⁸. Энэ нь дэлхийн олон оронтой харьцуулахад

⁷ Уул уурхайн салбарын 2019 оны эхний XI сарын Статистик мэдээ, УУЯ, 2019.12.17

⁸ Д.Сумъяабазар, УУХУ-ийн сайд, Coal Mongolia 2019, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн товч танилцуулга, 2019.12. file:///C:/Users/User/Downloads/2019-11.pdf

уг салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр харьцангуй өндөр байгааг илтгэнэ.⁹

2019 оны 12 дугаар сарын байдлаар уг салбарт үйл ажиллагаа явуулдаг ашиглалтын болон хайгуулын хүчин төгөлдөр 2,796 тусгай зөвшөөрөл (59.7 хувь ашиглалт, 40.3 хувь хайгуул), хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ 7.4 сая га, нийт нутаг дэвсгэрт эзлэх тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь 4.8 байна. Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 19.9 хүртэлх хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдох боломжтой. Одоогийн байдлаар энэ хэмжээ 4.8 хувьтай тэнцэж байгаа нь цаашид олборлох салбарт үйл ажиллагаа явуулах компаний тоо өсөх боломжтойг харуулж байна.

Ийнхүү тусгай зөвшөөрлийн тоо өсөн нэмэгдэж, олборлох үйлдвэрлэл өргөжин тэлэхийн хэрээр газар, түүний хэвлий, хөрс, гадаргын болон гүний усны нөөц, хэв шинжид ихээхэн өөрчлөлт орж, иргэдийн амьдрах орчин, байгаль, ан амьтан, ургамал зүйд үзүүлэх нөлөөлөл нь нэмэгдэх болно. Ашигт малтмал олборлох нь манай улсын хувьд зайлшгүй хэрэгцээ шаардлага болоод байгаа өнөө үед уг салбараас олох эдийн засгийн үр өгөөжийг өндөр байлгахын сацуу тогтвортой хөгжлийн асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлага тулгараад байна¹⁰.

Салбарын эдийн засаг болон улс орны хөгжилд оруулж буй үр өгөөжийг үнэлэх ерөнхий мэдээлэл олон нийтэд тодорхой хэмжээнд хүрдэг хэдий ч тус салбарын үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс идэвхтэй хяналт тавих, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хариуцлага нэхэхэд шаардлагатай мэдээлэл тэр бүр хүртээмжтэй байдаггүй. Олборлох салбарт

⁹ McKinsey Global Institute, 2013, Reverse the curse: Maximizing the potential of resource-driven economies;

¹⁰ Тогтвортой байдлыг хангах чиглэлээр багш нарт зориулсан гарын авлага, Монгол Улс, 2014 он

хэрэгжүүлэх бодлогыг (1) хайгуул, олборлолт явуулах нөхцөлийг тодорхойлох, (2) олборлолтын үр өгөөжийг баталгаажуулж, оновчтой хуваарилах гэсэн хоёр үндсэн үе шатанд хувааж авч үзэж болно. Тэгвэл салбарын бодлогыг илтгэх чухал мэдээллүүдэд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн олголт, эзэмшлийн үйл явц, түүнд оролцогч компаниуд болон шийдвэр гаргагчдын тухай, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй төр засгийн зүгээс байгуулж буй гэрээ хэлцэл, татварын болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, төсвийн орлогын хуваарилалт, зарцуулалтын тухай зэрэг олон тооны мэдээллийг цэгцтэй байдлаар цуглуулж, олон нийтийн сонорт хүргэж, төрийн бодлогод ашиглах зайлшгүй шаардлага тулгараад байна. Ийм нөхцөл байдал үүсэх шалтгаан, нөхцөл ямар байсан талаарх шинжилгээг дараагийн хэсэгт өгүүлнэ.

2.3. АСУУДАЛ ҮҮССЭН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

2.3.1. Салбарын эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд учирч буй эрсдэл

Хүнд суртал, авлигын эрсдэл: Олборлох салбарын бодлогын эхний тулгамдсан асуудал бол газрын хэвлийн баялгаа хайж илрүүлэх, улмаар түүнийг ашиглах тухай шийдвэр гаргах үйл явц юм. Өөрөөр хэлбэл, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох үйл явц нь мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай, хариуцлагатай компанийг сонгон шалгаруулах учиртай. Тусгай зөвшөөрөл бүхий салбарт төрийн оролцоо, хамаарал, хяналт, шалгалт өндөр бөгөөд албан тушаалтнаас хамааралтай ажиллагааг цахим, ухаалаг, ил тод, нээлттэй хэлбэрт шилжүүлэхгүй бол хүнд суртал болон авлигын эрсдэл үүсдэг. Монгол Улс хэдийгээр энэ чиглэлд тодорхой алхмууд хийж эхэлсэн ч эхлэл төдий байна гэж хэлж болно. Харин ашиг өгөөж нь өндөр байх боломжтой салбарт үйл ажиллагаа явуулах эрхийг олж авахад тусгай зөвшөөрлийн хуваарилалтыг анхнаас нь шударга бус явуулах, давуу байдал бий болгох, ингэхийн тулд төрийн албан хаагч, улс төрд нөлөө бүхий

этгээд сонирхлын зөрчил үүсгэх, авлига, хээл хахууль өгөх, авах улмаар төрөөс олгосон эрх болон хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж мөнгө угаах зэрэг нь нийгмийн давхаргын ялгааг улам нэмэгдүүлж, нийгэмд бухимдал үүсгэдэг. Тусгай зөвшөөрөл олгох явцад учирч болох авлигын эрсдэл болон бодлогын шийдлүүдийг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн “12 улаан дарцаг” болон Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргасан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын авлигын эрсдэлийн үнэлгээ” зэрэг тайлангуудад нарийвчлан үнэлсэн байдаг.

Татварын эрх зүйн орчноос үүсэх эрсдэл: Олборлох салбарын эдийн засгийн үр өгөөж олон хэлбэртэй байж болох ч улсын болон орон нутгийн төсөвт орох татварын орлого хамгийн чухал үүрэгтэй байдаг. Төсвийн орлого нь тухайн улс орны хөгжлийг хангах бодлогыг хэрэгжүүлэх боломжийг төр засагт олгодог. Тиймээс татварын тогтолцоо хүн бүрт ил тод байх нь чухал. Хэдийгээр татварын хууль тогтоомж олон нийтэд ямар нэг хэмжээгээр ил байдаг хэдий ч тэдгээрийг хэрэгжүүлэх дүрэм журам тэр бүр ойлгомжтой биш байх нь бий. Ялангуяа олборлох салбарт төрөл бүрийн гэрээ байгуулж, түүндээ татварын хууль тогтоомжид зааснаас өөр байдлаар татвар ногдуулах асуудал гардаг. Мөн татвараас зайлсхийх, хууль бусаар зугтах үзэгдэл олборлох салбарт элбэг тохиолддог. Тиймээс татварын хууль тогтоомж, дүрэм журам, татварын хувь хэмжээ, тооцооллыг хөндсөн гэрээ хэлцлүүдийг ил болгох нь эдийн засгийн үр өгөөж хүртэхэд учирч болох том эрсдэлийг бууруулах юм. Түүнчлэн татвар төлөх, хариуцах үүрэг хэнд байгааг тодорхой байлгах үүднээс оффшор бүсийн компаниудын ажиллах нөхцөлийг тодорхой болгох, компаниудын ашиг хүртэж, хариуцлага хүлээх эздийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай.

Салбарын орон нутагт үүсгэх эрсдэл: Орон нутгийн иргэд олборлох салбарын байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөг илүүтэйгээр үүрэх нь бий. Тиймээс олборлох салбарын орон нутагт үзүүлж буй эерэг нөлөөг онцгойлон анхаарах шаардлагатай.

Тухайлбал, орон нутгийн иргэд олборлох компанид ажил эрхлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ ханган нийлүүлэх, гэрээт ажил гүйцэтгэх зэрэг эдийн засгийн шууд үр нөлөө нь хүн ам цөөн орон нутагт эдийн засгийн онцгой ач холбогдолтой байх боломжтой. Түүнчлэн байгаль орчны доройтол, нийгмийн сөрөг нөлөөнд төлбөр тооцож, түүгээрээ орон нутгаа хөгжүүлэх чиглэлийн төслүүдийг компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд хийх, эсвэл орон нутгийн удирдлага зохион байгуулах боломжтой. Гэхдээ энэ бүх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн оролцоог хангахгүй бол цөөн хэдэн иргэн үр өгөөжийг нь хүртэж, олборлох компаниуд урт удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэл учрах, улмаар эдийн засгийн үр өгөөж буурах эрсдэл бий. Орон нутгийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг ба сөрөг үр нөлөөг тооцож, зохих байдлаар санхүүгийн болон бусад нөхвөрийг олгож байгаа тохиолдолд ил тод, иргэдийн оролцоотой зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Орлогын удирдлагад үүсэх эрсдэл: Олборлох салбарын эдийн засгийн үр өгөөжийг иргэдэд хүртээхэд учирдаг гол асуудал нь нэгэнт татвараар цуглуулсан орлогыг зөв зохистой удирдах явдал юм. Тодруулбал, улс төрийн зорилго бүхий харалган, популист шийдвэрүүд гаргаж улмаар эдийн засгийн үр ашиггүй төслүүдийг уул уурхайн орлогоор санхүүжүүлэх, баялаг шавхагдах үед эдийн засгаа олон тулгуурт, төрөлжсөн болгож чадаагүй байх, хуримтлал үүсгэлгүйгээр нийт хэрэглээг өсгөх, бэлэн мөнгө тараах зэрэг нийгмийн шинжтэй бодлогыг түлхүү анхаарах зэрэг нь эргээд эдийн засгийн тогтвортой байдлыг удаан хугацаанд хангаж чадахгүйд хүрдэг. Мөн Голланд өвчин үүсэх эрсдэлийг бий болгодог. Тиймээс салбарын ил тод байдлыг дээд зэргээр хангаснаар дээр дурдсан урагшгүй бодлогыг иргэд дэмжихгүй байх хөрс суурийг бий болгож, олборлолтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, үндэсний баялгийн санд төвлөрүүлэх бодит нөхцөл бүрдэх юм.

2.3.2. Авлига болон бусад гэмт хэргийн эрсдэл

Эрдэс баялгийн салбарыг авлигын эрсдэл өндөртэй гэж үздэг. Ийм байдал нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой. Тухайлбал, эрдэс баялгийн салбарт төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл олгодгоос улбаалан ашигт малтмалын нөөц баялаг ихтэй оронд цагаан захтны авлига, хээл хахууль, мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл өндөр байна гэж үздэг. Түүнчлэн уг салбарт төр засаг, компани хооронд ихээхэн дүнтэй гэрээ, хэлцэл хийгдэж, улмаар компанийн ажиллах нөхцөл, тухайлбал татвар төлөлт зэргийг тодорхойлж байдаг нь шийдвэр гаргагчдаас ур чадвар шаардаад зогсохгүй өндөр ёс суртахуун, авлигыг үл тэвчих нөхцөлийг шаардаж байдаг. Нөгөө талаас, уул уурхайн салбарт эргэлдэх хөрөнгө мөнгөний хэмжээ их дүнтэй байх тул худалдан авах үйл ажиллагаа, ханган нийлүүлэлт, бүтээгдэхүүний борлуулалт зэрэгтэй холбоотой авлигын эрсдэл болон татвараас зугтаах боломж мөн өндөр байдаг. Төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд өөрийн эрх мэдлээ ашиглан төрийн байгууллага, албан хаагчдад нөлөөлөх, өөрт эсхүл хамаарал бүхий аливаа этгээдэд давуу байдал бий болгох, ашигтай шийдвэр гаргуулах өндөр магадлалтай. Улмаар тодорхой хэсэг бүлэг этгээдийн эрх мэдэлд тусгай зөвшөөрөл болон уул уурхайн салбарын үр өгөөж төвлөрөх, өрсөлдөөний талбар хумигдах, шударга бус монопольлол бий болох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Энэ салбарт төрийн өмчит компаниуд онцгой үүрэгтэй оролцож байдаг нь байдлыг улам бүр ноцтой болгодог.

Тусгай зөвшөөрөл олгоход тавьж буй шалгуур сул, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл хангалттай бус, тухайлбал эцсийн өмчлөгч нь тодорхойгүй, үйл ажиллагаа явуулах санхүү, технологи, хүний нөөцийн чадавхтай эсэх нь эргэлзээтэй, зөвшөөрөл олгох болон түүний дараах үйл ажиллагааны талаарх мэдээлэл ил тод биш нөхцөлд тусгай зөвшөөрлийг олгох нь олон асуудал дагуулж байна. Улмаар анхнаасаа үйл ажиллагаа явуулах зорилгогүй, олноор төвлөрүүлсэн тусгай зөвшөөрлийг цааш дамлан

худалдах, улсад төлөх татвараас зугтах, зайлсхийх явдал өнгөрсөн хугацаанд гарсан ч мэдээлэл дутмаг, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй учир арга хэмжээ авах, хариуцлага тооцох боломжгүй тохиолдлууд гарч байжээ.¹¹

Монгол Улсын хэмжээнд 2015 онд 88, 2016 онд 146, 2017 онд 136, 2018 онд 172, 2019 онд 71 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь бусдад шилжүүлжээ.¹² Хэдийгээр хувьцаа эзэмшигч солигдох бүрд улсын төсөвт баталсан жишгээр¹³ татвар төлөх ч татварыг бүрэн хэмжээгээр хураахад тухайн хэлцлээс ашиг хүртэх эцсийн, жинхэнэ эздийн тухай болон хэлцлийн бодит үнийн талаар мэдээлэлтэй байх шаардлагатай болдог. Тухайлбал, эцсийн эзэд солигдохгүй байх, Монгол Улсад бүртгэлгүй толгой компанийн эзэмшил солигдох, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдээгүй гэрээ хэлцлийг хянах, эдгээртэй холбоотой татварыг нөхөн авах боломжийг бүрдүүлэхэд компанийн цаадах эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүрдүүлэх, тогтмол шинэчлэх, аж ахуйн нэгжийг үүрэгжүүлж, хариуцлагажуулах, мэдээллийг ил тод болгох зайлшгүй шаардлага тулгардаг.

Цаашлаад шинэ технологи, хяналт шалгалт сайжрахын хэрээр авлига болон татвараас зугтах арга улам нарийсаж, эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааны зардлын томоохон хувийг эзэлдэг туслан гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ, ханган нийлүүлэлт, худалдан авалтын гэрээгээр дамжуулан, өөрт нь давуу байдал олгосон төрийн эсхүл улс төрийн албан хаагчдад авлига, хээл хахууль өгөх явдал бий болсон гэж үздэг.¹⁴

¹¹ Offshore Leaks Database, Mongolia: <https://offshoreleaks.icij.org/search?c=MNG&cat=1>

¹² Эрдэс баялгийн Статистикийн мэдээ 2019 оны 12 дугаар сар, АМГТГ

¹³ Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, тусгай зөвшөөрөл шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах аргачлал, Сангийн сайдын 2017 оны 380 дугаар тушаалын хавсралт

¹⁴ Twelve Red Flags: Corruption Risks in the Award of Extractive Sector Licenses and Contracts, Endnote 2, Aaron Sayne, Alexandra Gillies and Andrew Watkins, Transparency International 2017

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагыг төрөөс томилдог болон шийдвэрт нь нөлөөлөх байдал газар авсантай холбоотойгоор төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын худалдан авалтаар дамжуулж давуу байдал олгох, авлига хээл хахуулийг ийм хэлбэрээр дамжуулах, бодит бус үнэ өртгөөр худалдан авалт хийж улсад их хэмжээний хохирол учруулсан жишээ 2012 онд Үндэсний аудитын газраас Эрдэнэт Үйлдвэр ХХК-д хийсэн аудитаар илэрчээ. Тиймд хэн, хэнтэй, ямар шалгуур болон гэрээний дагуу, ямар бараа, ажил, үйлчилгээг, хэдэн төгрөгөөр худалдан авсныг ил тод болгох нь дэлхий нийтэд хэрэгжих болсон “сайн” жишиг туршлага бөгөөд дээрх эрсдэлийг бууруулах бодит аргад тооцогдох болжээ.

Өнгөрсөн хугацаанд олон улсад шуугиан тарьсан хамгийн өндөр дүнтэй авлига хээл хахуулийн хэргийн түүхэн баримтаас харахад авлига болон мөнгө угаах асуудлын харилцан хамаарлыг ойлгох шаардлага үүссэн. Гэмт хэрэг, авлига, хээл хахуулиар олсон мөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж цэвэрхэн харагдуулах буюу “мөнгө угаах” гэмт хэргийг нарийвчлан судалж, улсын төсөвт зүй ёсоор төвлөрөх хөрөнгийн урсгалыг баталгаажуулах шаардлагатай болоод байна.

Авлига, мөнгө угаах гэмт хэргийн хамрах хүрээ улам өргөжин тэлж, ашиг хүртэгч жинхэнэ эзэд хөшигний ард нуугдан татвараас зугтах, татвараас зайлсхийх арга хайж, ашиг хүртэх арга нь нарийсаж байгаа өнөө үед олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниас ашиг хүртэгч эцсийн өмчлөгчдийн болон гэрээ хэлцлийг бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгож, энэхүү мэдээллийг олон нийтэд мэдээлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын түвшинд харилцан мэдээлэл солилцох хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлэх шаардлагатай болж байна. Нэгэнт дэлхий нийтээр мэдээллийн ил тод байдал хангагдах нөхцөл бүрдэж, Монгол Улс олон улсын жишиг хандлагыг нэвтрүүлж эхлээд байгаа өнөө үед мэдээллийг нууцлах нь олон улс, хөрөнгө оруулагчдын өмнө тодорхойгүй байдлыг үүсгэх эрсдэл дагуулна.

2.3.3. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага

Монгол Улс нь олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүний хувьд олборлох салбарын засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх үүрэг амлалтуудыг авсан билээ. Ийнхүү хүлээсэн үүрэг амлалтаа хэрхэн биелүүлэх нь манай улсын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, томоохон төслүүдийг амжилттай санхүүжүүлж, хэрэгжүүлэх урьтал нөхцөл болох юм.

Олон улсын түвшинд ийм үүрэг амлалт авах, түүнтэй холбоотой үүсэх асуудлуудын тод жишээ нь мөнгө угаахтай тэмцэх явдал юм. 2016 онд Мөнгө угаах, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын (Financial Action Task Force буюу ФАТФ)-ын Ази Номхон Далайн бүс нутгийн байгууллага (AP-G)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийсэн. Улмаар 2017 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчин, эрсдэлийн үнэлгээ, хэрэгжилт сайнгүй гэх үндэслэлээр “саарал” жагсаалтад орох сануулгыг авч, 2019 оны 10 дугаар сард албан ёсоор “саарал” жагсаалтад оров¹⁵.

2017 онд гаргасан Монгол Улсын Харилцан үнэлгээний тайланд¹⁶ хэд хэдэн эрсдэл тодорхойлсныг шийдвэрлэх зорилгоор хоёр жилийн хугацаанд төрийн байгууллагууд хамтран хууль тогтоомж гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх, тогтолцоог засаж сайжруулах арга хэмжээ авч Ази Номхон Далайн бүс нутгийн байгууллагад эргэн тайлагнасан байна. Улмаар 2019 оны 10 дугаар сард гарсан Харилцан үнэлгээний тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах явцын тайланг мөн дээрх байгууллага гаргасан.¹⁷ Явцын тайлан дахь асуудлыг шинжилж үзэхэд Монгол Улс салбарын эрсдэлийн үнэлгээг зөв хийх, эрсдэлд суурилсан

¹⁵ APG: <http://www.apgml.org/members-and-observers/members/details.aspx?m=ee2ef268-6106-40ec-806e-bec3987f9f88>;

¹⁶ Mutual Evaluation Report, Mongolia 2017, APG;

¹⁷ Follow-Up Report Mongolia, Oct 2019, APG;

арга хэмжээ авах, хэрэгжилтийн суурь орчныг сайжруулах зэрэг зөвлөмж голчлон тусгагджээ.

Харилцан үнэлгээний эхний тайлан гарсан даруйд Монгол Улс ФАТФ-ын 40 зөвлөмжийг¹⁸ удиртгал болгон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (МУТСТТХ)-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль (ҮОХЗДТТХ)-ийн төслийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлж, 2018-2019 онд УИХ-аар тус тус батлуулжээ.¹⁹

МУТСТТХ-ийн 18 дугаар зүйл, Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэгт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах зэргийг тусгажээ. Харин ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх аргачлалд²⁰ эрсдэлийн үнэлгээ хийхдээ аливаа улс өөрийн орны нөхцөл байдал, онцлогийг харгалзан эрсдэл дагуулж буй салбарыг тодорхойлох шаардлагатай гэжээ. Ингэж тодорхойлохдоо эдийн засаг, санхүүгийн секторт өндөр ач холбогдолтой нөхцөл байдал бий болгох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй бөгөөд эдгээрийг таслан зогсооход зайлшгүй харгалзаж үзэх салбарыг эрсдэлтэйд тооцохоор заасан байна.²¹

Хэдийгээр ФАТФ-аас өгсөн зөвлөмжид олборлох салбарыг шууд эрсдэлтэй гэж нэрлээгүй ч ФАТФ-ын бүс нутгийн харьяалагдах

¹⁸ The FATF 40 Recommendations, FATF 2012

¹⁹ МУТСТТХ 2013, ҮОХЗДТТХ 2019;

²⁰ Methodology for Assessing Technical Compliance with the FATF Recommendations and the Effectiveness of AML/CTF Systems, FATF 2013, Updated Oct 2019;

²¹ Risk and Context, 5, pg 6, Methodology for Assessing Technical Compliance with the FATF Recommendations and the Effectiveness of AML/CTF Systems, FATF 2013, Updated Oct 2019;

байгууллагуудын²² хийсэн улс орнуудын харилцан үнэлгээнд ашигт малтмалын нөөц баялаг ихтэй бусад улс орны уул уурхай, олборлох салбарыг эрсдэлтэйд тооцсоныг дэмжиж хүлээн авчээ. Түүнчлэн Аргачлалаас гадна ФАТФ-ын бусад гарын авлага²³ болон ОУВС, ЭЗХАХБ, Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөмж, гарын авлагад²⁴ олборлох салбарын авлига, хээл хахууль, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг өндөр гэж үзэн эрсдэлтэйд тооцох талаар заасан. ФАТФ нь олон улсын эдгээр байгууллагатай тогтмол хамтын ажиллагаатай, харилцан уялдаатай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улс орнуудыг мөн адил харилцан уялдаатайгаар эдгээр байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ёстой гэсэн зарчмаар ажилладаг байна.

Тиймээс эрдэс баялгийн салбарыг Монгол Улс эрсдэлтэй салбарт багтааж, эрсдэлийн үнэлгээг нарийвчлан гаргах шаардлага нэгэнт бий болсон нь олон улсын байгууллагуудын өгч буй зөвлөмж, хандлагаас тодорхой харагддаг. Мөн Ази Номхон Далайн бүс нутгийн байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу эрсдэлд суурилсан арга хэмжээ авах, хэрэгжилтийн суурь орчныг сайжруулахад нэгдэн орсон ОУИТБС гэх мэт олон улсын санал санаачилгын зөвлөмжийн хэрэгжилтийг давхар хэмжинэ гэдгийг тооцоолох шаардлагатай.

Дээрх үйл ажиллагаатай зэрэгцээд Европын Холбооны Зөвлөлөөс 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсыг “татварын асуудлаар хамтран ажилладаггүй улсын жагсаалт” буюу “хар жагсаалт”-д оруулах шийдвэр гаргасан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар

²² CFATF (Кариб); EAG (Төв Ази); ESAAMLG (Зүүн болон Өмнөд Африк); GABAC (Төв Африк); GAFILAT (Латин Америк); GIABA (Баруун Африк); MENAFATF (Дундад Ази ба Хойд Африк); Moneyval (Европ);

²³ FATF and APG (2015), Money laundering and terrorist financing risks and vulnerabilities associated with gold, FATF, Paris and APG, Sydney www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/ml-tf-risks-and-vulnerabilities-gold.html; National Money Laundering and Terrorist Financing Risk Assessment 2013 FATF;

²⁴ Implementing AML/CFT Measures in the Precious Minerals Sector: Preventing Crime While Increasing Revenue 2014 IMF

сарын 20-ны өдөр 350 дугаар тогтоолыг баталж, татварын асуудлаарх сайн засаглалын зарчмуудыг хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг хүлээсний үндсэн дээр уг жагсаалтаас гарч “саарал жагсаалт”-д буюу ажиглалтад байгаа юм. Ажиглалтаас бүрэн гарахыг зорьж Монгол Улс ЭЗХАХБ-ын гишүүн улс биш ч татварын мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлын дэлхийн форумын гишүүн болох, ЭЗХАХБ-аас гаргасан татварын асуудлаарх харилцан туслах олон талт конвенцод нэгдэх, улмаар хүсэлтээр мэдээлэл солилцох (ХМС буюу the EOIR Standard), автоматаар мэдээлэл солилцох (АМС буюу the AEOI Standard) зэргийг баримталж ажиллах шаардлагатай болж байна. Мөн “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг хөтөлбөр”-ийн (BEPS) гишүүнээр элссэн зэрэг нь Монгол Улс үндэстэн дамнасан корпорацын, ялангуяа уул уурхайн компаниудын санхүүгийн мэдээллийг урьдчилан тохиролцсоноор бусад гишүүн улстай автоматаар, харин шаардлагатай нөхцөлд бусад мэдээллийг солилцох, гаргаж өгөх үүрэгтэй болж байгаа юм.²⁵

Түүнчлэн ОУИТБС-д 2007 онд нэгдэн орж, тус санаачилгын стандартыг хэрэгжүүлэх үүргийг хүлээгээд байгаа билээ. Энэ стандартын дагуу олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд, тэдгээртэй холбогдох гэрээ хэлцэл, компаниудын эцсийн өмчлөгч, төлж буй татвар төлбөрүүд, бүтээгдэхүүний борлуулалт зэрэг олон төрлийн мэдээллийг тухай бүрд нь нийтлэн олон нийтэд мэдээлж байх шаардлагыг хангах юм. Түүнчлэн тус салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх замаар өрсөлдөөний талбарыг тодорхой болгох шаардлагатай. Салбарын томоохон компаниуд болон хариуцлагатай хөрөнгө оруулагчид энэ санаачилгыг хэрэгжүүлж буй улс орныг ажиллах таатай нөхцөлтэй гэж үзэх явдал нэмэгдэж байна.

²⁵ <http://www.oecd.org/tax/transparency/exchange-of-information-on-request/>, <http://www.oecd.org/tax/transparency/automatic-exchange-of-information/>

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын өөр нэг санаачилга бол Нээлттэй засаглалын түншлэл юм. Төр засаг, иргэний нийгмийн түншлэл хэлбэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулдаг уг түншлэлийн хүрээнд олборлох салбарын гэрээ хэлцэл болон компаниудын эцсийн өмчлөгчдийн мэдээллийг бүртгэж, нийтэд ил тод байлгах үүрэг амлалтыг Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө авсан. Амлалтаа биелүүлэх нь сайн засаглалыг баталгаажуулах, ардчиллыг дэмжигч дэлхийн тэргүүлэгч улс орнуудтай туршлага солилцон нэг эгнээнд байгаагаа нотлох чухал алхам болно.

Төр, хувийн хэвшлийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, мэдээллийн зөрүүг дотооддоо мөн олон улсад харилцан солилцож хянаснаар улсын төсөвт төвлөрөх орлогыг бодитоор нэмэгдүүлэх цаашлаад төрийн мэдээллийн ил тод байдал, салбарын засаглал, хариуцлага хангагдсанаар олон улсын практикт хэрэгжиж буй стандарт, зарчмын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөдөг олон улсын томоохон хөрөнгө оруулагчдыг татах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Олон улсын дээрх санал санаачилга нь дэлхийн нийтлэг чиг хандлагыг илэрхийлж буй хэдий ч олборлох салбарын ил тод байдлыг баталгаажуулах нь байгалийн баялгийн эзэн болох ард иргэдийн эрх ашигт эн тэргүүнд үйлчлэх юм.

2.4. ХУЧИН ТӨГӨЛДӨР ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ХҮРЭЭНД ХҮРСЭН ҮР ДҮН, ҮҮСЭЖ БУЙ ХҮНДРЭЛ

2019 оны байдлаар эрдэс баялгийн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувь хэмжээ гадаадын нийт хөрөнгө оруулалтын 77 хувьтай тэнцэж байна.²⁶ Уг салбарт стратегийн хөрөнгө оруулагч татах нь түүнийг дагаад олон улсын туршлага, технологи нэвтрэх, тогтвортой ажлын байр нэмэгдэх, ажилтнууд

²⁶ Шууд хөрөнгө оруулалтын судалгаа, үлдэгдэл, урсгал, эдийн засгийн салбараар /2010-2019/03 улирал/, Монголбанк

олон улсын туршлагатай болох, мэргэших, улсын төсөвт орох татвар хураамж өсөх зэрэг давуу тал болдог нь манай улсад амжилттай хэрэгжиж буй томоохон төслүүдээс харагддаг.

Хөрөнгө оруулагчид Дэлхийн Банкнаас жил бүр гаргадаг “Бизнес эрхлэхүй” тайлан, олон улсын Транспэрэнси Интернешнл байгууллагаас боловсруулдаг “Авлигын төсөөллийн индекс”, Дэлхийн эдийн засгийн форумнаас гаргадаг “Өрсөлдөх чадварын тайлан” зэрэг судалгаанаас хөрөнгө оруулах улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх нь түгээмэл. Эдгээр тайлангийн үндсэн үзүүлэлтийн хэмжүүрт мэдээллийн ил тод байдал зайлшгүй багтдаг. Түүнчлэн олон улсын хөрөнгийн бирж, банк, санхүүгийн байгууллагуудын зээл олгох, нээлттэй зах зээлд хувьцаа гаргах, бондоор санхүүжилт босгох зэрэгт тавьж буй нэг шалгуур, мөн тухайн улсын зээлжих зэрэглэлийг үнэлэхэд мэдээллийн ил тод байдлыг хангасан эсэхийг үнэлдэг болжээ. ОУИТБС зэрэг олон улсын санал, санаачилгыг хэрэгжүүлдэг байх нь үнэлгээнд үзүүлэх нэг давуу тал болоод байна.

Онол практикт суурилж, туршилтаар баталгаажсан олон улсын туршлага, “сайн” жишээнд дараах мэдээллийг ил тод болгохыг шаарддаг (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ил тод болгох мэдээлэл ба практик хэрэгжилт

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
1 Олон талт оролцогчдын бүлэг бий болгох зорилгоор	
1.1 Олборлох салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын 3 талт бүтэц бий болгох	Зохицуулалт байхгүй
2 Гэрээ байгуулах, лиценз олгох зэрэг эрх зүйн болон институцын хамрах хүрээг тодорхойлох зорилгоор	

Хүснэгт 1-ийн цргэлжлэл

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
2.1 Олборлох салбарын эрх зүйн хүрээ болон төсвийн бодлогыг нийтлэх	Татварын ерөнхий хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу мэдээлнэ.
2.2 Олборлох салбарын тусгай зөвшөөрөл олголт, холбогдох гэрээ (шинэчилсэн, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон талаарх), гэрээний төрөл, материаллаг нөхцөл ба сонгон шалгаруулалттай холбоотой бүх мэдээлэл	Гэрээ, гэрээний төрөл, нэмэлт өөрчлөлт, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр, материаллаг нөхцөлийг ил тод болгохтой холбоотой зохицуулалт, Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам 27-д заасан мэдээлэлд концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнээс бусдыг ил тод болгох шаардлагагүй. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг АМГТГ улирлын тайланд тусгадаг.
2.3 Олборлох салбарын гэрээний төрөл, гэрээ байгуулсан ААН	АМГТГ дотоодын хэрэгцээнд зориулж гаргадаг. Олон нийтэд ил тод болгох шаардлагагүй.
2.4 Олборлох салбарын тусгай зөвшөөрлийн бүртгэл мэдээлэл	АМГТГ улирлын тайланд тусгадаг.
2.5 Олборлох салбарын гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлт бүхлээрээ	АМГТГ дотоодын хэрэгцээнд зориулж гаргадаг. Олон нийтэд ил тод болгох шаардлагагүй.
2.6 Олборлох салбарын эцсийн өмчлөгчийн мэдээллийг авах, ил тод байдлыг хангах	УБ-12 маягтаар УБЕГ, ТБ-07 маягтаар ҮТЕГ мэдээллийг авдаг, ил тод болгох зохицуулалт байхгүй

²⁷ Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолын хавсралт



Хүснэгт 1-ийн үргэлжлэл

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
2.7 Олборлох салбарын ТӨК, ТӨҮГ-ын үүрэг хариуцлага, журам, төр болон ААН хоорондын гүйлгээ, хөрөнгө оруулалтыг зохицуулах зохицуулалт	Татварын тайлангаар татварын албанд тайлагнана. Олон нийтэд ил тод болгох шаардлага заагаагүй.
3 Хайгуул ба бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тооцох зорилгоор	
3.1 Хайгуулын ажиллагааны талаарх мэдээлэл, олборлох салбарын ерөнхий мэдээлэл, томоохон олборлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох	АМГТГ улирлын тайланд зарим мэдээллийг, СЯ, УУХҮЯ зарим мэдээллийг шаардлагатай үед нийтэлдэг.
3.2 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийг компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилсан мэдээллийг тухай бүр гаргаж ил тод мэдээлэх.	Төсөл, компани тус бүрээр мэдээлэл боловсруулах зохицуулалт байхгүй. АМГТГ дотоод хэрэгцээндээ зориулан гаргадаг байх магадлалтай.
3.3 Экспортын хэмжээ, нийт үнийг түүхий эд тус бүрээр гаргах, мэдээллийг бүс нутаг, компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилж мэдээлэх	Зарим мэдээллийг СЯ гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.
4 Орлогыг тооцох зорилгоор	
4.1 Татвар болон орлого үүнд ЗГ-т ногдох ашиг, үйлдвэрлэлийн эрх, АМНАТ, ашгийн татвар, ногдол ашиг, шагнал урамшуулал, тусгай зөвшөөрлийн төлбөр, түрээс, концесс гэх мэтэд хамаарах төлбөр, ЗГ-ын орлого, материаллаг үр шимийн мэдээллийг төр болон ААН-ээс авч ил тод болгон зөрүүг тодорхойлон нийтлэх	Зарим мэдээллийг СЯ гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.

Хүснэгт 1-ийн цргэлжлэл

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
4.2 Үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах, эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого, ТӨҮГ, ТӨК хүлээн авсан эсхүл борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого	Зарим мэдээллийг СЯ гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.
4.3 Дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бартерын солилцоо	Татварын тайлангаар татварын албанд тайлагнана. Олон нийтэд ил тод болгох шаардлага заагаагүй.
4.4 Тээвэрлэлтийн орлого	Татварын тайлангаар татварын албанд тайлагнана. Олон нийтэд ил тод болгох шаардлага заагаагүй.
4.5 Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ	Зарим гүйлгээг Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу ААН өөрөө мэдээлэх үүрэгтэй. Гэвч мэдээлэл бүрэн бус.
4.6 Орон нутгийн төлбөр	Татварын тайлангаар татварын албанд тайлагнана. Олон нийтэд ил тод болгох шаардлага заагаагүй.
4.7 Мэдээллийг төсөл, компани, ТӨААН, орлого тус бүрээр мэдээллийг задлах	АМГТГ дотоод хэрэгцээндээ зориулан гаргадаг байх магадлалтай.
4.8 Мэдээллийг олон нийтэд хүргэх хугацаа, хугацаанд хамаарах мэдээллийн талаарх зохицуулалт	АМГТГ дотоод хэрэгцээндээ зориулан гаргадаг байх магадлалтай.
4.9 Төлбөр ба орлогыг хөндлөнгийн аудитаар хянуулах, холбогдох мэдээлэл, тайлбарыг аудитын тайланд тусгах, мэдээллийг баталгаажуулах зохицуулалтыг бий болгосон байх	Аудитын тухай хуульд зааснаар ТӨААН тайлангаа аудитлуулна. Нийтэд мэдээлэх үүрэггүй.



Хүснэгт 1-ийн үргэлжлэл

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
5 Орлогын хуваарилалтыг тооцох зорилгоор	
<p>5.1 Орлогын хуваарилалт, бэлэн болон бэлэн бус орлогын аль аль нь улсын төсөвт бүртгэгдэж буй талаар, бүртгээгүй тохиолдолд энэхүү орлогын зарцуулалтын тухай тайлбарлах, Ирээдүйн өв сан, хөгжлийн сан, орон нутгийн засаг захиргаа, төрийн өмчит компани, төсвөөс гадуурх бусад аж ахуйн нэгж гэх мэт тэдгээрийн санхүүгийн тайлантай холбогдох замыг мэдээлэх</p>	<p>Зарим мэдээллийг СЯ гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.</p>
<p>5.2 Орсон орлогыг төв болон орон нутгийн төрийн байгууллага хоорондоо шилжүүлвэл тайланд тусгах, орлого хуваах тогтолцоо, томьёо түүнчлэн төв засгийн газар, агентлагууд болон орон нутгийн хамаарах нэгжүүд хоорондын төлбөрийн шилжүүлгийг тухайн томьёог ашиглан тооцсон орлого болон бодитоор шилжүүлсэн орлогын зөрүү, шилжүүлгийг ил тод болгосон болон боломжтой бол нэгтгэсэн эсэхийг баталгаажуулахыг дэмжих</p>	<p>Зарим мэдээллийг СЯ гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.</p>
6 Нийгэм, эдийн засгийн зарцуулалтыг тодорхойлох зорилгоор	
<p>6.1 Компаниудын нийгмийн болон байгаль орчны зарцуулалт, тайлан, мэдээлэл</p>	<p>БОАЖЯ, СЯ зарим мэдээллийг дотоодын хэрэгцээндээ зориулж гаргадаг.</p>
<p>6.2 Төрийн өмчит аж ахуйн нэгжийн төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр</p>	<p>Зарим гүйлгээг Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу ААН өөрөө мэдээлнэ.</p>
<p>6.3 Олборлох салбарын эдийн засагт оруулж буй орлогын дүгнэлт</p>	<p>Зарим мэдээллийг СЯ, УУХҮЯ болон бусад төрийн байгууллага гаргадаг, шаардлагатай үед тайлангаар мэдээлнэ.</p>

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

ОУ-ын туршлага: Хуримтлуулах, ил тод болгох мэдээлэл, үүрэг хариуцлага	Мэдээлэх, ил тод болгох практик явц
6.4 Олборлох үйл ажиллагааны байгаль орчны нөлөөлөл: байгаль орчны нөлөөллийн үйл ажиллагаа, хяналтын талаар	БОАЖЯ гаргаж, мэдээлнэ.
7 Үр дүн ба үр нөлөөллийг тодорхойлох зорилгоор	
7.1 Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сэдэвчилсэн судалгаа хийлгэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг орон даяар хийх	Салбар тус бүрийн холбогдох хуульд зарим зохицуулалтыг хийсэн.
7.2 Мэдээллийн хүртээмжийг сайжруулах ба нээлттэй өгөгдлийг ашиглахыг дэмжих үйл ажиллагаа явуулах үүрэг хариуцлага	Салбар тус бүрийн холбогдох хуульд зарим зохицуулалтыг хийсэн.
7.3 ОУ байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага	Салбар тус бүрийн холбогдох хуульд зарим зохицуулалтыг хийсэн.
7.4 ОУ-ын шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүн болон үр нөлөөг тооцох, судлах, засаглалд тайлагналын үр нөлөөг хэмжих	Байгууллага тус бүрийн дотоод журам, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээгээр зохицуулагдана.

Дээрх мэдээллийг бүрэн бүтэн авснаар төр ба хувийн хэвшлийн мэдээллийн зөрүүг гаргаж тайлбар нэхэх, иргэд салбарын нарийвчилсан дүн шинжилгээ судалгаа хийх боломжийг бүрдүүлэх, цаашлаад улсын эдийн засгийг хөгжүүлэхэд тогтвортой, жигд хүртээмжийг хангах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, суурийг бий болгох давуу талтай болно. Нөгөө талаар олон улсын, мэргэшсэн хөрөнгө оруулагчид дэлхий нийтэд хэрэгжиж буй мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагыг компанийн зүгээс хэрэгжүүлж хэвшсэн байдаг тул хөрөнгө оруулагчдынхаа эрх, ашиг сонирхлыг хамгаалах, санхүүжүүлэгчдийн шаардлагыг хангах, шударгаар өрсөлдөх, олон нийтийн төөрөгдлийг бууруулах зорилгоор сайн

дураараа мэдээллээ ил тод болгох явдлыг сайшаадаг. Түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа явуулахад санхүүжилт их шаардагддаг бөгөөд олон улсын банк, санхүүгийн байгууллагаас тавьж буй нарийн шаардлагын нэг нь аж ахуйн нэгж өөрөө мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээлгэж байгааг санхүүжилт хүлээн авагч аль ч байгууллага хангаж хэвшсэн гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Монгол Улс уул уурхай, газрын тосны салбарт ил тод байдлын стандарт шаардлагуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг авч ирсэн билээ. Тухайлбал, 2006 онд Ашигт малтмалын тухай, 2009 онд Цөмийн энергийн тухай, 2014 онд Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиудад тус тус өөрчлөлт оруулснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ил тод байдлын талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон. Мөн Засгийн газрын нийт дөрвөн удаагийн тогтоолоор ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлжээ. Сангийн сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар ил тод байдлын тайланд ашиглах маягт, тайлан гаргахад мөрдөх журмыг тогтоон хэрэгжүүлж байна. Тэрчлэн ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг нь өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагааны дүрэм журам, уг санаачилгыг орон нутагт хэрэгжүүлэх дэд зөвлөлийн үлгэрчилсэн журмыг батлан гаргажээ.

2.4.1. ОУИТБС-ын хэрэгжилт, үүсэж буй хүндрэл

ОУИТБС-ын гишүүн улс орнууд тус санаачилгын Жишиг стандартыг²⁸ хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрдөг. ОУИТБС-ын стандарт улам бүр боловсронгуй болж 2016 болон 2019 онуудад шинэчлэгдсэнээр нэмэлт олон шаардлагыг тавих болсны дотор гэрээ,

²⁸ ОУИТБС: www.eiti.org

эцсийн өмчлөгч, байгаль орчин, жендер, борлуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийг олборлох үйлдвэрлэлийн төсөл тус бүрээр задлан тайлагнах шаардлагууд нэмэгдээд байна. Түүнчлэн төрийн өмчит компаниудын тайланд тавих шаардлага улам бүр өндөрсжээ. Мөн энэ хүрээнд ил тод байдлыг төрийн байгууллагын байнгын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх буюу цахим хуудсаараа дамжуулан байнга тогтвортойгоор нийтэд мэдээлж байх шаардлагатай болсон.

ОУИТБС-д гарсан дээрх дэвшилтэт өөрчлөлтүүдийг Монгол Улсад бүрэн хэрэгжүүлэхэд өнгөрсөн хугацаанд хууль тогтоомжид оруулсан өөрчлөлт, баталсан журам, маягт зэрэг хэрэгжилтэд баримталж ирсэн өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна. Ялангуяа тусгай зөвшөөрөл эзэмшигчид, төрийн холбогдох байгууллагуудын ил тод байдлын тайлан гаргах үүргийг хуулиар баталгаажуулж, гаргаагүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ил тод байдлын тайлан гаргадаггүй боловч мэдээллээ нэгтгэж, улсын төсвийн орлого төлөвлөлтийг боловсронгуй болгоход оролцох ёстой төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлох, ил тод байдал, ухаалаг төрийн дэвшлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг хуулиар баталгаажуулах шаардлага үүсээд байна.

Энэ хүрээнд 2014 онд Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, 2017 онд Уул уурхайн тухай хуулийн төслийн Арванхоёр дугаар бүлгийг ил тод байдлыг хангахад бүхэлд нь чиглүүлж байсан боловч эхний хуулийн төслийн Үзэл баримтлалыг хэлэлцэхдээ УИХ-ын гишүүдээс Үзэл баримтлалыг давсан санал гаргаж тухайн үеийн Уул уурхайн яамны санаачилгыг дэмжээгүй бол 2017 онд Уул уурхайн яамнаас боловсруулсан хуулийн төслийг өргөн мэдүүлээгүй байна.

Нэгэнт ил тод байдлыг хангах, дэлхийн бусад улс оронтой аж ахуйн нэгжүүдийн орлого, ашиг, татварын болон эцсийн өмчлөгч зэрэг

мэдээллийг харилцан солилцох үндэс суурь тавигдсан,²⁹ дэлхийн улс орнуудын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн, мөн иргэдийн эрх ашиг, хүлээлтэд бүрэн нийцэх учраас төрөөс хариуцлагатай хандаж, ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг даруй бүрдүүлэх шаардлагатай (Хавсралт 3. ОУИТБС-ын Стандартын шаардлага Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл (2014 он) болон Уул уурхайн тухай хуулийн төсөл (2017 он)-д тусгагдсан байдал). Мөн Монгол Улс ОУИТБС болон НЗТ-ийн дагуу хүлээсэн үүргээ гишүүн орны хувьд хэрхэн хэрэгжүүлэхийг тус санаачилгуудын гишүүн дэлхийн 100 гаруй улс орон, олон улсын хөгжлийн болон санхүүжүүлэгч банк санхүүгийн томоохон байгууллагууд нэгэн зэрэг хүлээлттэй байгааг харгалзан үзэх нь зүйтэй. Иймд УУХҮЯ-аас 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр УИХ-ын даргын 177 тоот захирамжаар байгуулсан Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлж, ил тод байдлын стандартыг хуулиар тогтоон хэрэгжүүлэх нэн таатай үе тохиогоод байна гэж үзэж байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхэлснээс хойш Монгол Улс нь 13 удаа тайлан гаргасан бөгөөд дээрх ил тод болгоход шаардлагатай мэдээллийг тусгай зөвшөөрөлтэй компаниудаас хэсэгчлэн авчээ. Эхлэлийн үйл явцын дараа Хараат бус хянагч-нэгтгэгч нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн тоог цахим тайлан дээрх ЗГ-ын тайлангаар орлого төвлөрүүлсэн гэх компаниудын тоотой харьцуулж үзэх боломжтой болсон ч зөрүү гарсаар байна.

МОУИТБС-ын цахим тайлагналын систем ашиглан 2018 оны 8 сарын 4-ний өдрийг хүртэл тайлагнасан ЗГ-ын орлогод дүн шинжилгээ хийж, материаллаг төлбөр төлсөн байдлаар ангилж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна (Хүснэгт 2).

²⁹ Олон улсын чиг хандлага, хуудас 9

Хүснэгт 2. ОУИТБС-ын тайлан гаргадаг ААН, 2017³⁰

Хамрах төрөл	Компанийн тоо	
	Улсын	Орон нутгийн
Шууд хамруулах	222	56
Түүвэрлэн хамруулах	59	9
Хамрагдаагүй компани	1787	681
Уул уурхайн бус	23	7
Нийт	2091	753

Хүснэгтээс харахад хуулиар заавал тайлан мэдээллээ гаргаж өгөх үүрэг ногдуулаагүй нь ОУИТБС-ын ажлын албанаас олборлох салбарын ААН-д тулгалт хийх боломжгүй, зарим мэдээллийг (жишээ нь: эцсийн өмчлөгч) компаниуд сайн дураараа гаргаж өгөхөөр байгаа юм. Хариуцлагын хэлбэрийг хаана ч суулгаагүй учраас тайлан мэдээллээ гаргаж өгөхгүй, гаргасан ч мэдээллээ бүрэн өгөхгүй байх магадлалыг нэмэгдүүлж, тайлагналын үндсэн зорилго, ач холбогдлыг бууруулж байна. Цаашлаад төрийн байгууллагад ногдуулсан үүрэг, хариуцлага байхгүй учраас төр, хувийн хэвшлийн мэдээллийн зөрүүг тодруулах ажил баталгаатай болж чадахгүй байна.

Өнөөг хүртэл ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд анхаарууштай зарим асуудлыг Хүснэгт 3-т ангилан харуулав.

³⁰ ОУИТБС-ын нэгтгэл тайлан 2017



Хүснэгт 3. Ил тод байдлыг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ, анхаарах асуудлууд

Эцсийн өмчлөгчийн ил тод байдал	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд ³¹ зааснаар газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээтэй хуулийн этгээд нь эцсийн эзэмшигчийн мэдээллээ 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор харьяа татварын албанд нөхөн бүртгүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд ³² зааснаар 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагыг заажээ. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
Гэрээний ил тод байдал	Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (NRGI)-ийн 2018 онд хийсэн гэрээний ил тод байдлын судалгаагаар олборлох салбарт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нийт 14 төрлийн гэрээг төрийн байгууллагуудтай байгуулж болохоор байна гэжээ ³³ . Уул уурхайн яам болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаанд олборлох салбарын хуулийн этгээдийн төрийн байгууллагуудтай байгуулж буй нийт 436 гэрээ ил тод болж ³⁴ , цаашид үлдсэн гэрээг тогтмол ил тод болгохоор төр, иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллаж байна. Гэвч тодорхой эрх зүйн зохицуулалтгүйгээр энэ ажлыг хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үр дүн, ач холбогдол нь ч багасна.

³¹ УИХ, 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан

³² УИХ, 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан

³³ Missing Contract for Mongolia Report, NRGI 2018

³⁴ www.iltodgeree.mn

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглал, тайлагнал, ил тод байдал Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл ил тод, нээлттэй байх нь компанийн засаглалын шууд бүрэлдэхүүн хэсэг биш боловч компанид сайн засаглалын хэмжүүр маш чухал нөхцөл болдог тул энэ хүрээнд багтаан мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тусгайлан авч үздэг.³⁵ Төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх гол харилцаа нь Компанийн тухай болон Мэдээллийн ил тод нээлттэй байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиуд, санхүүгийн мэдээллийн хувьд Шилэн дансны тухай хуулиар зохицуулагддаг. Иймд эдгээр хуулийн холбогдох заалтыг үндэслэн төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг найман асуулгын хүрээнд тодорхойлж авч үзсэн хэд хэдэн судалгааг олон улсын байгууллагуудаас хийсэн бөгөөд төрийн өмчит уул уурхайн компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал авах ёстой онооны талд нь ч хүрэхгүй байна³⁶.

Хэдийгээр Шилэн дансны тухай хууль (2014), Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам³⁷-ын 3.4 дүгээр зүйлд заасан таван багц мэдээллийг байгууллага өөрийн цахим хуудсанд мэдээлэх боловч хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг нарийвчлан хянаж хэвшээгүй, аудитын тайлангаар хяналтыг хязгаарлаж, мөн уг тайлан олон нийтэд ил тод биш байгаа нь учир дутагдалтай. Түүнчлэн гүйлгээний мөнгөн дүнд тодорхой хязгаар тавьснаар 5 сая ба түүнээс дээш хэмжээний мөнгөн дүнтэй гүйлгээг мэдээлэхээр зохицуулж шалгуур, үнэлгээ зэрэг мэдээллийг ил тод болгох зохицуулалт дутмаг байна.

³⁵ IMF Corporate Governance Assessment Tool 2017;

³⁶ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ, Нээлттэй Нийгэм Форум, Уул уурхайн яам, 2014

³⁷ Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолын хавсралт

Хүснэгт 3-ын үргэлжлэл

<p>Байгаль орчин, нийгмийн хариуцлагын мэдээллийн ил тод байдал</p>	<p>Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгжүүд орон нутгийн захиргаатай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, уурхайн ашиглалт, ажил эрхлэлтийн асуудлаар хэрхэн хамтран ажиллахаа тодорхойлж хамтын ажиллагааны гэрээ байгуулдаг. Мөн орон нутгийн захиргаатай бичил уурхай (БҮ), орон нутгийн ажил эрхлэлт, орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулах үүрэгтэй. Дээрх гэрээг ААН-үүд байгуулахгүй байх тохиолдол цөөнгүй байна.</p>
<p>Татвар, төсвийн мэдээллийн задаргаа, баталгаажуулалт</p>	<p>Төсвийн тухай (2011), Төсвийн ил тод байдлын тухай (2012) хуулиуд, Иргэдийн Төсөв,³⁸ төсвийн нээлттэй цахим хуудас³⁹ мөн Төсвийн нээлттэй байдлын индекс⁴⁰-ээр Монгол Улс дэлхийн дунджид хүрэхгүй буюу 100 оноо авахаас 46 оноо авчээ. Ийнхүү үнэлгээ доогуур гарсан нь 100 оноо авахаас 7 оноо авсан Иргэдийн оролцоо хэсгийн үнэлгээ 100 оноо авахаас 7 оноо авсан нь ийнхүү доогуур үнэлэгдэх шалтгаан болжээ. Олон улсын Төсвийн түншлэлээс гаргасан үнэлгээний хүрээнд өгсөн зөвлөмжид Монгол Улс төсвийн төлөвлөлт, батлах үйл явц, зарцуулалт, хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг дурдсан байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 60.2.6 дугаар зүйлд зааснаар орон нутгийн хөгжлийн санг Ашигт малтмалын тухай хуулийн 47.3 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувиар, Төсвийн тухай хуулийн 60.2.7 дугаар зүйлд зааснаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувиар бүрдүүлэхээр тус тус заасан. Эдгээр орлогод орон нутгийн иргэд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байгаа тул дээрх орлогын төлөвлөлт, зарцуулалтын задаргааг орон нутгийн иргэдэд тогтмол, хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх шаардлагатай.</p>

³⁸ <https://mof.gov.mn/article/entry/irgediin-tusuv-2019>

³⁹ www.iltod.gov.mn


⁴⁰ <https://www.internationalbudget.org/budget-work-by-country/findgroup/group-data/?country=mn>

Одоогийн хэрэгжиж буй тайлагналтын хүрээнд ил тод болгох шаардлагатай мэдээллүүдийг Хавсралт (Хавсралт 2)-аар харуулав. Олон улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хэсгийн “ОУИТБС-ын дагуу ил тод болгох мэдээллүүд (Mainstreaming ажлын хүрээнд)” -ээс харна уу).

2.4.2. Шүүхийн практикт үүсэж буй хүндрэл

Өргөдлөөр тусгай зөвшөөрөл олгох хугацаа (2006-2010)-нд мэдээллийн ил тод байдал хангагдаагүй болон нэгдсэн мэдээллийн бааз бүрдээгүй зэргээс үүдэн түрүүлж ирсэн боловч өргөдлийг бүртгэхээс татгалзсан, нэг талбай дээр давхардуулан өргөдлүүдийг бүртгэсэн, бүртгэлээс үндэслэлгүй хасагдсантай холбогдон гарсан нэхэмжлэл шүүхийн шатанд давамгайл байсан. Харин 2016 оноос хойших шүүхийн маргаанд тусгай зөвшөөрлийн хилийн маргаан, талбайн давхцал, мэргэжлийн хяналт, байгаль орчны яамны болон орон нутгийн шийдвэртэй холбоотой гомдол, нэхэмжлэл мөн байгаль орчны нөхөн сэргээлт, хууль зөрчиж тусгай зөвшөөрөл олгосон, захиргааны илт хууль бус актыг хүчингүй болгуулах тухай төрийн бус байгууллага, иргэдийн гомдол, нэхэмжлэл зонхилж байна (Зураг 1-ийг харна уу).

Зураг 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрлэгдсэн нийт захиргааны хэрэг маргаан, 2006-2018 он



2.4.3. Татварын байгууллага, улсын бүртгэл дээр үүсэж буй хүндрэл

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд⁴¹ зааснаар газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээтэй хуулийн этгээд нь эцсийн эзэмшигчийн мэдээллээ 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор харьяа татварын албанд нөхөн бүртгүүлэхээр заасан. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо хуулийн хугацаа буюу 2018 оны 6 дугаар сарын 01-ний байдлаар 3261 байсан байна.⁴² Энэ дүн 2019 оны 12 дугаар сарын байдлаар 2,796 болжээ.⁴³

Хуулийн энэхүү шаардлагын дагуу Татварын албанд 1022 тусгай зөвшөөрөл эзэмшигч эцсийн өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн ба бусад нь мэдээллээ ирүүлээгүй байна. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг мөн хуулийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт

⁴¹ УИХ, 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан

⁴² Статистикийн мэдээ 2018 оны 5 дугаар сар, АМГТГ

⁴³ Эрдэс баялгийн Статистикийн мэдээ 2019 оны 12 дугаар сар, АМГТГ

бүртгүүлэх үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан мэдээллээр хуулийн хугацаанд нийт 436 хуулийн этгээд 749 тусгай зөвшөөрлийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн, 17 хуулийн этгээд 25 тусгай зөвшөөрлийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөж бүртгүүлсэн аж. Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнийг харахад хууль хэрэгжиж эхэлсэн 2018 оны 6 дугаар сараас хойш 2019 оныг дуустал шинээр нийт олгосон 215, хүчингүй болсон 370, дуусгавар болсон 408, шилжүүлсэн 243, нөхөн олгосон 67 тусгай зөвшөөрөл байгаа хэдий ч холбогдох шилжилтийн бүртгэл хэрхэн хийгдсэн нь тодорхойгүй, мэдээллээ нөхөн бүртгүүлсэн тоотой харьцуулахад дутуу байна (Хүснэгт 4-ийг харна уу).

Хүснэгт 4. Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн

	2018 он								2019 он											
	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	
Шинээр олгосон	25	28	39	46	60	69	85	17	23	31	45	58	75	87	102	115	122	125	130	
Цуцалсан/ хүчингүй болсон	91	91	121	133	142	142	181	2	23	46	53	68	92	101	140	152	165	179	189	
Дуусгавар болсон	92	92	116	119	146	182	209	20	52	66	107	120	127	137	155	177	192	196	199	
Шилжүүлсэн	112	117	136	139	139	157	172	7	15	21	23	26	33	41	44	49	67	70	71	
Нөхөн олгосон	31	31	34	37	37	38	40	0	0	2	4	5	6	6	10	12	16	26	27	

Хуулийн дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй аж ахуйн нэгжид Татварын алба болон Улсын бүртгэлийн ерөнхий газар холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцоогүй байна. Түүнчлэн, дээрх байгууллагуудын эцсийн өмчлөгчдийн мэдээллийг өгөх үүрэгтэй хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоон мэдээлэл асар их зөрүүтэй байгаа юм.

2.5. ТУХАЙН АСУУДЛААР ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БУЙ ЭТГЭЭД

Дээр дурдсан асуудлуудыг урьдчилан дүгнэхэд Үндсэн хуульд заасан иргэдийн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх тодорхой хэмжээнд зөрчигдөж байна. Олборлох салбарт үүсээд байгаа өнөөгийн нөхцөл байдлаас харахад жилээс жилд хүрээгээ тэлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нэмэгдэх магадлалтай байгаа учраас дараах бүлгийн эрх ашиг хөндөгдөх болно (Хүснэгт 5-ыг харна уу).

Хүснэгт 5. Хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1 Уул уурхайн бүсэд оршин суугч иргэд	<ul style="list-style-type: none"> - Эрдэс Баялгийн салбартай холбоотой популизмын золиос болж, мэдээлэлгүйн улмаас хариуцлагагүй улс төрч, компаниудын эрх ашигт автаж, эрх ашгаа хамгаалж чадахгүй байна. - Тухайн орон нутгийн ус, газар болон байгалийн ямар баялгийг хэдий хэмжээгээр, ямар хугацаанд эрэл хайгуул хийх, ашиглах, байгаль орчны нөхөн сэргээлтийг тухайн орон нутагт хариуцан хийх аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэл тодорхой бус байх нь Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалт зөрчигдөхөд хүргэж байна. - Төр ямар аж ахуйн нэгжтэй орон нутгийг хөгжүүлэх, ажлын байр бий болгохтой холбоотой ямар амлалт авч, үүрэг хүлээснийг мэдэх иргэдийн эрх нь зөрчигдөж байна.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
2 Тусгай хэрэгцээтэй иргэд	<ul style="list-style-type: none">- Нийгмийн эмзэг бүлэг, эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдээлэл, судалгаа байхгүйн улмаас тэдэнд зориулсан тусгайлсан үйлчилгээ, хэрэгцээ шаардлагыг хангаж, нийгмийн тэгш хөгжлийг хангаж чадахгүйд хүрч байна.
3 Хувийн хэвшил	<ul style="list-style-type: none">- Энэ салбарт эрх тэгш, шударга өрсөлдөх боломж нөхцөл дутмаг, тусгай зөвшөөрөл олгоход хэсэг бүлэг этгээдийн ашиг сонирхлын зөрчил, улс төрч, төрийн байгууллагын хөндлөнгийн нөлөөлөл, давуу байдал бий болгох нөхцөл өндөр байх тул эрх нь зөрчигдөж байна.- Төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын томилгоо, тэдгээрийн чухал шийдвэрүүд улс төрчдийн зохисгүй оролцоотойгоор явагдаж байгаа нь хувийн хэвшлийн хөгжилд сөргөөр нөлөөлж, компанийн засаглалыг хөгжүүлэхэд саад болж байна.- Тухайн шийдвэрт нөлөөлсөн этгээдэд авлига хээл хахууль өгөх, хээл хахуулийг төрийн өмчит компанийн худалдан авалтаар халхавчлах байдал түгээмэл байгаа нь авлига, мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл, хамрах хүрээг тэлж байна.- Төрийн өмчит компани төрөөс татаас авах, хөнгөлөлт эдлэх зэргээр давуу эрхтэй байдгаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгж тэдэнтэй эрх тэгш өрсөлдөх боломжгүй болдог. Энэ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид дарамт болж, улмаар төрөөс хувийн секторыг хөгжүүлэх хөшүүргийг үгүй хийж байна.- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эрдэс баялгийн салбартай холбоотой популизмын золиос болж, компаниудын үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл дутмагаас орон нутгийн иргэд, байгууллагаас хувийн хэвшилд ирэх дарамт, эсэргүүцэл нэмэгдэж байна.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
4 Төр	<ul style="list-style-type: none"> - Олон улсын хэд хэдэн санаачилгад нэгдсэн Монгол Улсын Засгийн газар үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх боломжгүй болж, олон улсын өмнө хариуцлага алдсанд тооцогдохоор байна. - Төсвийн хуваарилалтыг үр дүнтэй хийж чадахгүйд хүрч улмаар орлого төлөвлөлтийг хэт буруу, өөдрөгөөр төсөөлж, алдагдалтай төсөв баталж байна. - Хуулийн этгээдийн оффшор дахь толгой компанийн өмчлөл шилжихэд Улсын төсөвт орох их хэмжээний татварын хураамж, орлогыг мэдээлээгүйн улмаас гадагш нь алдаж байна. - Гэмт хэргийн хүрээг хумих алхмыг хэрэгжүүлэхгүй байгаа учраас улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн албан хаагчдын авлига хээл хахууль цаашлаад мөнгө угаах гэмт хэрэг зогсохгүй тэлж байна. - Хувийн секторын засаглал сайжрахгүй тул эдийн засагт нэмэлт зардлын дарамтыг тогтмол бий болгож байна. - Тогтвортой хөгжлийг хангах зорилго, зорилтыг биелүүлж чадахгүйд хүрч байна. - Олон улсын мэргэшсэн, томоохон хөрөнгө оруулагчдыг үргээж байна. - Эрдэс баялгийн салбартай холбоотой популизмын төлөөсийг эдийн засгийн хөгжлийн боломжоороо төлж байна.
4 Иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд	<ul style="list-style-type: none"> - Судалгаа шинжилгээний ажлыг тогтмол, давтамжтай бөгөөд бодит мэдээлэлд суурилан, төр хувийн хэвшлийн мэдээллийн зөрүүг олж хянах, салбарын хөгжлийг зөв тооцоолсон судалгаа шинжилгээний ажил боловсруулах боломж алдагдаж байна. - Төсвийн орлого, зарлага, төлөвлөлт болон гүйцэтгэлийн мэдээллийг бүрэн хянаж чадахгүй байна. - Судалгаа мэдээлэлд суурилан цаг ямагт хөгжих, боловсрох боломж алдагдаж байна. - Эрдэс баялгийн салбартай холбоотой популизмын золиос болж, мэдээлэлгүйн улмаас тэдэнд ашиглагдаж байна.

2.6. САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ДУНД ХИЙСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОН ТУХАЙН АСУУДАЛД ХАМААРАХ ЭТГЭЭДҮҮДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ТОЙМ⁴⁴

Хуульд тусгах саналын талаар салбар хариуцсан мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачид, олборлох салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн төлөөлөлтэй хийсэн хэлэлцүүлгийн санал, шүүмжийг энэхүү тайланд тусгав.

1. 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын хамтран зохион байгуулсан зөвлөгөөнөөс гарсан санал дүгнэлт:
 - Бие даасан хуультай болох шаардлагатай. Төрийн байгууллагын мэдээллийг системтэйгээр ил тод болгох асуудлыг бие даасан хуулиар зохицуулахгүй бол маш нарийн мэдээлэл багтаж байна. Жишээлбэл, гэрээг авч үзэхэд УУХҮЯ нь дангаараа цуглуулаад ил тод болгох нь учир дутагдалтай. Аймаг сумын засаг дарга нар нь гэрээ байгуулсан даруйдаа системээр ил тод болгох нь зүйтэй. Үүнийг тэдний үүрэгт нь хуульчилж өгөх хэрэгтэй. Үгүй бол чанаргүй мэдээлэл ихсэх аюултай болно.
 - Олон улсын ОУИТБС-ын удирдах хороонд мэдээллийг нэгтгэхтэй холбогдуулан гарч байгаа бэрхшээл, тэдгээрийг даван туулах, шилжилтийн үеийн үйл ажиллагаатай холбоотой дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг албан ёсоор тавих шаардлагатай.
 - Салбарын ил тод байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагааг тусгайлан хариуцах Ажлын албатай байх, Ажлын алба нь Ерөнхий сайдын дэргэд байх;
 - Ажлын албыг идэвхтэй, төсвөөс санхүүждэг, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх мөн хяналт тавих эрх хэмжээтэй болгох;

⁴⁴ Дэлгэрэнгүйг хэлэлцүүлгийн тайлангаас харна уу.

- Төрийн болон аж ахуйн нэгжийн ирүүлсэн тайлангийн зөрүүг гаргахад Нэгтгэгчийн ажлын цар хүрээг багасгах замаар зардлаа хэмнэх гэх зэрэг.
2. Тус хэлэлцүүлэг 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдаж УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Нээлттэй Нийгэм Форум, Транспэрэнси Интернешнл олон улсын байгууллага, Хариуцлагатай уул уурхай ТББ, Монголын уул уурхайн Үндэсний ассоциацийг төлөөлсөн 17 хүн оролцсон бөгөөд хэлэлцсэн асуудлуудыг товчлон дүгнэвэл:
- Тайлан гаргаагүй компанийн тоо олон байна, хариуцлага тооцох боломж байхгүй;
 - Төр, хувийн хэвшлийн нэгтгэлийг бүрэн дүүрэн гэж үзэх боломжгүй, мэдээлэл дутуу байна. Мэдээллийг бүрэн дүүрэн авбал зөрүү нэмэгдэх магадлалтай;
 - Эцсийн өмчлөгчдийн мэдээллийг сайн дураар гаргаж байгаа бөгөөд мэдээлэл ил болохгүй байгаагаас гадна тайлбар тодруулгыг хуулийн хүрээнд авах боломж бололцоо байхгүй;
 - Тайлангийн иж бүрдэл дутуу, компаниуд тайлангийн мэдээллийг санаатай, санамсаргүй дутуу өгдөг;
 - Тайланд тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргаж байгаа компаниудын тоо, батлагдсан журмаас гадуур олгогдсон зөвшөөрлийн мэдээлэл орохгүй мөн ямар явцаар сонгогдсон талаарх мэдээлэл нь дутуу;
 - Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээлэл, гэрээ орохгүй байгаа нь гэрээг ил тод болгох сонирхолгүйтэй холбоотой, нууцлал гэдгийг үндэслэлгүйгээр түрээ барьж байна;
 - Бэлэн мөнгө, мөнгөн бус хандивын мэдээлэл огт тусгагдахгүй байна;
 - Тендэр, худалдан авалтын мэдээлэл дутуу;
 - Нөхөн сэргээлт хийсэн компаниудын мэдээлэл дутуу, БОАЖЯ-тай ажил уялдаагүй;
 - Эдийн засагт гарч буй томоохон өөрчлөлт, түүнтэй холбоотой мэдээлэл, үнийн өсөлтийг тайланд тусгаж, мэдээлэх шаардлагатай байна.

3. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫН ТОМЬЁОЛОЛ

Эрх зүйн зохицуулалтын хувьд зарим үүрэг хэрэгжиж байгаа ч тодорхой зохицуулалтгүйгээс үр дүн хангалтгүй, зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж байна.

3.1. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ТАВИХ ЗОРИЛГО

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль нь салбарын ил тод байдлыг хангах тодорхой стандартыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангах, оролцогч талуудын мэдээллийн ил тод байдал, тайлагнал, мэдээллийг хянан баталгаажуулах механизмыг бүрдүүлж, эдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.2. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ТАВИХ ЗОРИЛТ

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн зорилт нь энэхүү хуулийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд салбарын засаглалыг сайжруулах замаар энэ салбарт хувийн хэвشلээс хариуцлагатай хөрөнгө оруулалтыг татах, гаднын хөрөнгө оруулагчдад ил тод, таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүнээс хамаарах субьектив хамаарлыг бууруулах, салбарын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаарх мэдээллийг нэгтгэн хяналттай, хариуцлагатай бөгөөд үр дүнтэй байхад төрийн бодлогыг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.3. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Зөвхөн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах эсхүл төрийн байгууллагаас журам, заавар батлах замаар Монгол Улс дэлхийн улс орон, олон улсын мэргэжлийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, эрдэс баялгийн салбарын хөгжлийг дэмжихийн зэрэгцээ засаглалыг сайжруулах боломж хязгаарлагдмал юм. Учир нь улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс болж одоогийн тогтолцооноос ашиг хүртэгч жинхэнэ эзэд далд хэлбэрээр оршиж байгаа нь авлигатай тэмцэх, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах олон улсын стандарт шаардлага, хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулсаар байна. Тиймээс ил тод байдлыг хангах, тайлагналтын зарчимд эдийн засаг, нийгэмд өрнөсөн томоохон үйл явдал, авсан сургамж болон “сайн” туршлагыг тусгаж, техник технологийн хөгжилд нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлага байнга тулгарч байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь олон улсын чиг хандлага, тогтсон жишгийг хэрэгжүүлэхэд шаардагдаж буй зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалж, үр нөлөөг урьдчилан тооцож уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг санал болгоход оршино.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоох, эерэг болон сөрөг талыг харьцуулж үзэх ажлын хүрээнд зохицуулалтын дараах хувилбаруудыг авч үзлээ. Үүнд:

- 1) “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- 2) хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

- 3) зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- 4) төрөөс санхүүгийн интервенц хийх;
- 5) төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- 6) захиргааны шийдвэр гаргах;
- 7) хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу хувилбар тус бүрээр зорилгод хүрэх байдал, зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хувилбаруудын дүгнэлт

1. Тэг хувилбар		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзсанаар одоогийн эрх зүйн болоод зохицуулалтын орчныг хэвээр үргэлжлүүлж тулгамдсан асуудлыг үр нөлөөтэй, бодитой шийдвэрлэх боломжгүй болно.	Төр болон иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж буй төсөв санхүүгийн, популизмын шударга бус өрсөлдөөний дарамт нэмэгдсээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, мөн одоо тулгамдсан асуудлын нэг болоод байгаа авлига, хээл хахууль, монопольчлол, санхүүгийн гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээний зардал нэмэгдэж, төсөвт дарамт болох байдлаар сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг

Хүснэгт 6-ын үргэлжлэл

2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Тулгамдаж буй асуудлыг зөвхөн нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс гадна олон нийтийг хамруулсан сонсгол, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, гарын авлага, мэдээллийн хуудас зэргийг ашиглан бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.	Энэ хувилбар нь асуудал үүсгэж байгаа гол шалтгааныг урт хугацаанд бууруулах магадлалтай боловч богино болон дунд хугацаанд төсвөөс ихээхэн хэмжээний зардал шаардана. Тулгамдсан асуудлын нэг болоод байгаа авлига, хээл хахууль, монополизм, санхүүгийн гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээний зардал нэмэгдэж, төсөвт дарамт учруулж, ойрын болон дунд хугацаанд сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ. Нөгөө талаар улс төрийн ашиг хонжоо хайсан бүлэглэл, хүмүүсийн популист сэдэв болох эрсдэлтэй.	Ойрын болон дунд хугацаанд сөрөг үр дагавартай. Урт хугацаанд үр дүнд хүрэх магадлалтай.
3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Татвар, хураамжийн бодлого, эсхүл зөвшөөрөл, лиценз болон квот зэргээр тодорхой хязгаарлалт тогтоох замаар хийгдэх зохицуулалт юм. Энэ хувилбар нь төрөөс салбарын аж ахуйн нэгжүүдэд тавих хяналтыг сайжруулах мөн татвар хураалтыг нэмэгдүүлэх талтай боловч асуудлыг бүрэн шийдвэрлэх чадамжгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудал үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй

Хүснэгт 6-ын үргэлжлэл

4. Төрөөс санхүүгийн интервенц хийх		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг, татаас үзүүлэх аргаар зохицуулалт хийх нь олон удаа авах арга хэмжээ биш. Мөнгөн хэлбэрээр хийх зохицуулалтын арга нь улс төрийн нөлөөлөл орох эрсдэлтэйгээс гадна яг зохицуулах шаардлагатай хэсэгтээ очихгүй байх магадлалтай учраас оновчтой хувилбар биш.	Их хэмжээний зардал гарах магадлалтай. Асуудал үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан. Одоогоор төрийн үйлчилгээг хувийн хэвшлээр хийлгэсэн тохиолдол байхгүй, нөгөө талаар эрдэс баялгийн салбар нь хэмжээ, хамаарлын хувьд олон салбарыг хамардаг учраас зөвхөн төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшил дангаар хийх боломжгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудал үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэх боломжгүй



Хүснэгт 6-ын үргэлжлэл

6. Захиргааны шийдвэр гаргах		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Гол үүсэж буй тулгамдсан асуудлууд нь олон салбар, өргөн хүрээний цогц мэдээлэл, төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын идэвх, оролцоо, хяналт, хариуцлага, тайлагнал зэргийг хамардаг учраас зөвхөн холбогдох журмыг шинэчилснээр асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Төрийн байгууллагуудын одоогийн мөрдөж байгаа дүрэм журмыг шинэчлэх нь зардал багатай хэдий ч энэ хувилбар нь цогц шийдэл биш. Нөгөө талаар хуулийн орчны өөрчлөлтгүйгээр хийх нэмэлт журам, зохицуулалт нь салбарын бизнес эрхлэгчдэд шинэ дарамт, дамжлага үүсгэх эрсдэлтэй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах		
Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Дээр дурдсан хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан судлахад, хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь хамгийн үр дүнтэй, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чадахуйц тогтолцоог бүрдүүлэх хувилбар болох нь харагдаж байна.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудал үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Энэ судалгаанд дурдсанаас гадна одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хэд хэдэн хууль тогтоомжид нэгэн зэрэг өөрчлөлт оруулах нь асуудлыг бүрэн шийдвэрлэж чадах эсэхийг мөн үнэлж үзсэн. Хувилбар 6-д тусгасан үндэслэлийн адил үүсэж буй гол тулгамдсан асуудлууд нь олон салбар, өргөн хүрээний цогц мэдээлэл, төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын идэвх, оролцоо, хяналт, хариуцлага, тайлагнал зэргийг хамардаг учраас хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулах нь үүссэн асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.

Тухайлбал, мэдээллийг хариуцах, уялдаа холбоог хангах, асуудлыг зангидах эрх хэмжээ тодорхойгүй хэвээр үлдэх юм.

Холбогдох хуулиудыг шинэчлэхэд үндэслэл байх шаардлагатай бөгөөд зардал болон хугацааг төдийлөн хэмнэхгүй, төрийн байгууллагуудын чиг үүрэгт өөрчлөлт оруулах нөхцөл бүрдэхээр байгаа тул шийдэх боломж хязгаарлагдмал юм. Нөгөө талаар, хуулийн орчны өөрчлөлтгүйгээр хийх нэмэлт зохицуулалт нь салбарын бизнес эрхлэгчдэд шинэ дарамт, дамжлага үүсгэх, олон байгууллагад тайлагнах ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй учраас үр дүнгүй.

Дээрх хувилбаруудыг нягталж үзэхэд асуудлыг цогц хэлбэрээр, өргөн хүрээнд шийдвэрлэж чадах шийдэл нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах явдал гэж үзлээ. Зорилгод хүрэх байдлыг шалгахын тулд олон улсын туршлага, ил тод байдлын хэрэгжилтийн үр дүн, орон нутгийн иргэдийн эрхийн зөрчил болон компаниудын үйл ажиллагаанд мөрдөгддөг норм, дүрэм, журам, түүний хэрэгжилтийг давхар судалсан болно.

Судалгааны ажлын хүрээнд сонгогдсон хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлж, харьцуулан судлав. Мөн зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг талууд, тухайн асуудлыг шийдвэрлэсэн бусад орны сайн туршлага зэргийг харьцуулан судалж (Хавсралт 7.1. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа) “хуулийн төсөл боловсруулах” зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр анх тавьсан зорилгодоо хүрэх боломжтойг олж тогтоов. Тухайн зохицуулалтын хувилбарыг өөр салбарт хэрэглэсэн адилтгах туршлага байгаа эсэхийг мөн судлахдаа уг асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн саналыг сонсож, өмнө хийсэн судалгааны материалыг ашиглалаа.

4. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНОВЧТОЙ ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

4.1. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛЬ

Хүний эрх, эдийн засаг, байгаль орчин, эрдэс баялгийн салбарын засаглалд үзүүлэх үр нөлөөг тандан судлахад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 6.2-т заасан шалгуур асуултуудыг баримтална. Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл зорилго, зорилтод хүрэх, эерэг нөлөөтэй байх магадлалтай нэг хувилбар байна:

Хувилбар 1: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах асуудлыг цогцоор нь зохицуулах бие даасан хууль боловсруулах.

Аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4.1-т заасны дагуу бие даасан хууль боловсруулах хувилбарыг сонгосон бөгөөд ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛЬ-ийн зохицуулалтын хувилбарыг дараах үндэслэлээр сонгов. Үүнд:

Бие даасан хууль боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай зөрчилдөхөөргүй байна. Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан Анхдагч хуулийн төслийн төрөл байх юм. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай анхдагч хууль батлагдсанаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд авлига, хээл хахууль, мөнгө угаах зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, салбарын монополизмийг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улсын төсвийн хуваарилалтыг хяналттай болгох, хүртээмжтэй өсөлтийг хангах, улмаар орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийг олон улсын жишигт нийцүүлэх, хууль эрх зүйн оновчтой,

тогтвортой орчныг бий болгох ач холбогдолтой. Ядуурал, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд салбарын орлого, улсын төсвийн төлөвлөлтийг тодорхой болгох, нийгэм тогтвортой хөгжих тогтолцоог сайжруулахад ихээхэн ач холбогдолтой байхаас гадна эерэг үр дагаврыг авч ирэх юм.

2014 онд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл, 2017 онд Уул уурхайн тухай хуулийн төсөлд Ил тод байдал гэсэн бие даасан Бүлэг тусгаж олборлох салбарын мэдээллийг хуримтлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байсан. Тухайн үед холбогдох хуулийн төслүүдийн аль нэг нь батлагдсан бол мэдээллийн урсгалыг зохицуулах төрийн байгууллагуудын чадавх, боломж сул байснаас үүдэн төсөвт хэт ачаалал үүсэх магадлалтай байсан. Харин 2019 оны байдлаар төрийн байгууллагууд мэдээлэл, харилцаа холбооны хүчин чадавхаа сайжруулсан, мөн хуулийг хэрэгжүүлэхэд санхүүгийн ачаалал, нэмэлт эх үүсвэр бага шаардагдах байдлаар технологийн хүндрэлийг тодорхой хэмжээнд шийдвэрлэж чадсан давуу тал бүрдсэн байна.

Хууль батлагдан, хэрэгжиж эхэлснээр улсын төсвийн зардалд том нөлөө үзүүлэхгүй бөгөөд олон салбарт ач холбогдолтой эерэг нөлөө үзүүлж, сайн үр дагавар авч ирэхээр байна.

4.2. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудлыг зохицуулах үндсэн хувилбар нь хуулийн төсөл боловсруулж, батлах асуудал болохыг тогтоов. Энэхүү хуулийн зохицуулалтын хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа холбогдох аргачлалд дурдсан суурь ойлголтуудыг харьцуулан дүгнэлт хийв.

Сонгосон хувилбарын үр нөлөөг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралтуудаар харуулав (Хавсралт 7.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Хавсралт 7.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Хавсралт 7.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Хавсралт 7.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө).

4.3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ

Монгол Улсын нэгдсэн орсон, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын II бүлэг. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний 5 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авлигын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан нь иргэний оролцоотой, шударга, ил тод байх үүргийг төрд хүлээлгэсэн чухал заалт юм.

Энэ хүрээнд Монгол Улс Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолын хавсралтаар Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөний Зургаадугаарт Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зорилт тавьжээ. Уг зорилтын хүрээнд эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, Хөрөнгө оруулалтын болон Бүтээгдэхүүн хуваах, Орд ашиглах, Орон нутгийн хамтын ажиллагааны

гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах, ОУИТБС-ын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах ажлыг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шат буюу 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн тус хөтөлбөрийн дараах арга хэмжээ нь Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахтай холбогдож байна. Үүнд:

“Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулахад мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах;

Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах;

Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

4.1.4.5. Санхүүгийн үйл ажиллагааны дахь хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх гэрээний үүргээ

биелүүлээгүй иргэн хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх;

Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр:

4.1.5.9. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор хууль сахиулах байгууллагыг нэгдсэн мэдээллийн сантай болгох;

Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

4.1.6.5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах” зэрэг зохицуулалт орсон байна.

ОУИТБС-ын шаардлагыг бүрэн хангасан улс болохын тулд Олон талт хамтын ажиллагааны Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийг байгуулан байнгын ажиллагаатай болгож, Ашигт малтмалын тухай хууль (2006)-ийн 48.10-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг тусгаж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чиг үүргийг Засгийн газрын тогтоолоор (2012 оны 222 тоот, 2018 оны 289) шинэчлэн тогтоож өгсөн. ОУИТБС-ын Стандарт 2019 онд дахин шинэчлэгдэж заавал биелүүлэх зарим үүргийг гишүүн орнуудад хүлээлгэсэн билээ.

Түүнчлэн төрийн үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдийн мэдээллээр хангагдах, мэдэх эрхийг хэрэгжүүлэх нь Монгол Улсын нэгдэн орсон аль ч олон улсын гэрээний эрхзүйн үндсэн зарчмуудтай харшлахааргүй, харин гишүүн орны хувьд олон улсын гэрээний үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж хүний эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх томоохон алхам болох юм.

Мэдээллийн нууцлал

Олон улсын жишиг, шаардлагаар олборлох салбарын цогц мэдээллийг ил тод болгоход төрийн байгууллагаас хувь хүн, байгууллагын мэдээллийг ил тод болгохоор зохицуулах шаардлагатай. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль бий болгох нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний нууцын зохицуулалтыг зөрчихөөргүй байна (Нэмэлт мэдээллийг шигтгээ хэсгээс харна уу).

Шигтгээ 1. Мэдээллийг ил болгохыг хориглох зохицуулалт

Ашигт малтмалын тухай хууль (2006)-д зааснаар нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх, хуулийн 57.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудад заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглохоор заасан байна. Төрийн болон албаны нууцыг нууцын зэргээс хамаарч нууцална гэж Төрийн болон албаны нууцын тухай хуульд заажээ.

Төрийн нууц. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.1-т “төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлнэ гэж тодорхойлжээ. Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг ЗГ-ын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ба уг жагсаалтын к/Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар хэсэгт эрдэс баялгийн салбарын мэдээллийг ил тод болгохтой холбоотой мэдээлэл багтаагүй байна.

Албаны нууц. Төрийн байгууллагын эзэмшил дэх мэдээллийн ил тод байдлын харилцааг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулдаг. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.2-т “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Шигтгээ 1-ийн үргэлжлэл

Хувь хүний мэдээллийн нууцлал. Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахыг хориглосон зохицуулалтууд байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар төрийн эрх бүхий байгууллага өөрийн эзэмшил дэх хувь хүний талаарх мэдээллээс эцэг/эхийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг болон ажлын утаснаас бусад мэдээллийг тухайн хүний бичгэн зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглохоор заасан байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 21 дүгээр зүйл, Хувь хүний нууцын тухай хууль, 4 дүгээр зүйлд зааснаар хувь хүний захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн болон хуулиар тогтоосон бусад нууцыг задруулахыг хориглосон байна.

Байгууллагын мэдээллийн нууцлал. Байгууллагын нууцын тухай хууль, 3 дугаар зүйлд аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээд, түүнээс эрх олгосон бусад этгээдийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр байгууллагын мэдээллийг бусдад ил болгохыг хориглохоор заажээ.

Шигтгээ 2. Мэдээллийг ил болгож болох зохицуулалт

Хувь хүний мэдээллийн нууцлал. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Хувь хүний нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар хувь хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утсаар бусад мэдээллийг тухайн хүний бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно. Батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно.

Байгууллагын мэдээллийн нууцлал. Байгууллагын нууцын тухай хууль, 3 дугаар зүйл ба 6 дугаар зүйлд тухайн байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно. Гэвч ямар ч тохиолдолд а/

Шигтгээ 2-ын үргэлжлэл

тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл, б/ тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл, в/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг нууцалж болохгүй гэсэн байна.

5. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийнэ. Тухайн асуудлыг зохицуулсан олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалтад Монгол Улсын олон улсын гэрээ, түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, хууль тогтоомж, олон улсын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг (тогтоол, шийдвэр, тунхаглал г.м), зөвлөмж зэрэг хамаарах бөгөөд эдгээр эх сурвалжийн хүрээнд харьцуулан судлав. Тухайн улс орны эрх зүйн соёл, түүх, газар зүйн байршил, эрх зүйн эх сурвалжийн ангилал болон олон улсын туршлагыг амжилттай хэрэгжүүлж байгаа зэргийг харгалзан эрх зүйн харьцуулсан судалгаа хийх улс орныг сонгосон болно.

Эрх зүйн харьцуулсан судалгааны тайланг бие даасан байдлаар боловсруулан Хавсралтаар харуулав (Хавсралт 7.5. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа).

6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

6.1. ДҮГНЭЛТ

Олборлох салбарын эдийн засгийн үр өгөөж олон хэлбэртэй байж болох ч улсын болон орон нутгийн төсөвт орох татварын орлого хамгийн чухал үүрэгтэй тул олон улсад нийтлэг мөрдөгдөж байгаа ил тод байдлын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь олборлох салбарын тулгамдаж буй хүндрэл, эрсдэлтэй үр дүнтэй тэмцэх чухал алхам болно гэж үздэг. Олборлох салбарын үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж улсын төсөвт татварыг зохистой түвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон хариуцан тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тулгарчээ. Ил болсон мэдээллийг ашиглах нь иргэдийг чадавхжуулдаг ба төр засаг болон компаниудаас хариуцлага нэхэж, улмаар үүсэж буй хүндрэл бэрхшээлийг бодитой мэдээлэлд тулгуурлан шийдвэрлэх төрийн бодлогыг бодит мэдээлэлд суурилан гаргах боломжийг бүрдүүлдэг.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдаж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд Татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх үүрэг хүлээсэн ч хариуцлага тооцох хэлбэр нь тодорхойгүй байснаас хууль хэрэгжээгүй байна. ОУИТБС-д тайлангаа гаргаж өгөөгүй эсхүл хуулийн дагуу мэдээллээ бүртгүүлээгүй аж ахуйн нэгжид бүрэн хариуцлага тооцож чадахгүй байгаа нь төрийн байгууллага, хувийн хэвшлийн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлийн эрх үүрэг, хариуцлагыг хуулиар тодорхойлоогүйтэй холбоотой. Мөн эрх шилжүүлснээс төвлөрүүлэх татварыг бүрэн хэмжээгээр хураахад тухайн хэлцлээс ашиг хүртэх

эцсийн, жинхэнэ эздийн тухай болон хэлцлийн бодит үнийн талаар мэдээлэлтэй байх нь татварыг нөхөн авах боломжийг бүрдүүлэх юм. Иймд компанийн цаадах эцсийн өмчлөгчийн мэдээллээс гадна гэрээ хэлцэл, ялангуяа төрийн өмчит компанийн ханган нийлүүлэлт, худалдан авалтын талаарх цогц мэдээллийг бүрдүүлж, шинэчлэх, хянах зайлшгүй шаардлага тулгараад байна. Мэдээлэл ил тод, бүрэн, цогц байх нь төрийн албан хаагч, улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой авлига, мөнгө угаах зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй бодитоор тэмцэх нөхцөл бүрдүүлнэ.

Олборлох салбарын эдийн засгийн үр өгөөжийг иргэдэд хүртээхэд өөр нэг чухал асуудал бол нэгэнт цуглуулсан татварын орлогыг зөв зохистой удирдах явдал юм. Орлогын зөв зохистой удирдлага нь олборлох салбарын орлогын хүртээмжийг сайжруулах, цаашилбал баялгийн сан бий болгох зэргээр нийгэм дэх хүртээмжтэй өсөлтийн түвшнийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Тиймээс эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг дээд зэргээр хангаснаар иргэд төрийн бодлогыг дэмжих, төр, иргэн, аж ахуйн нэгж хоорондын итгэлцэл, харилцан ойлголцол бүрдэх хөрс суурь бий болж, олборлолтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх бололцоо бүрдэнэ.

Монгол Улс олборлох салбарт ил тод байдлыг хангах талаар шат дараалсан арга хэмжээ авч, 2006 онд ОУИТБС-д нэгдэн орж, үндэсний хуульд тогтоомжийг олон улсын шаардлагад нийцүүлэн, уг санаачилгыг хэрэгжүүлэх олон талт бүтэц буюу Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний зөвлөл, салбарын сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг байгуулан ажиллаж иржээ. Үүний үр дүнд салбараас төв, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн бүх төрлийн татварын болон татварын бус орлого, үйлдвэрлэл, борлуулалт, уулын ажил, нөхөн сэргээлт, ажлын байрны мэдээлэл зэргийг агуулсан ОУИТБС-ын нэгтгэл тайланг жил бүр гарган олон нийтийн хүртээл болгож хэвшсэн байна. Гэхдээ ил тод байдлыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх эрх зүйн цогц орчныг хараахан бүрдүүлж чадаагүй байгаагаас ОУИТБС-ын тайланд бүх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудыг бүрэн хамруулж чадахгүй, тайлан гаргах, мэдээ тодруулга өгөх,

тайланг үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглах талаарх төрийн байгууллагуудын идэвх оролцоо сул, тайлан гаргаагүй компаниудад хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдээгүй зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна.

Үүний зэрэгцээ 2018 онд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолд өөрчлөлт оруулснаар ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг байсныг өөрчилж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болгосон нь ОУИТБС-ын статусыг тодорхойгүй болгожээ. Цаашлаад ОУИТБС-ын Ажлын албанд төсвөөс олгодог тодорхой хэмжээний мөнгө нь зөвхөн ОУИТБС-ын тайлангийн хянан нэгтгэлд зарцуулагдах нөхцөлтэй бөгөөд ОУИТБС-ын Ажлын албаны санхүүжилт, бүтэц, хүний нөөц, эрх хэмжээ тодорхойгүй байна. Одоогийн хэрэгжүүлж байгаа ажлын хүртээмж, чанарт тавих хяналт сул, ОУИТБС-д тайлагнах аж ахуйн нэгжийн тоо тогтмол биш, зарим мэдээллийг сайн дураар гаргахаар байгаа тул тус салбарт хамаарах аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулах, хариуцлагажуулах, орон нутаг дахь иргэдийн оролцоо, хувийн хэвшил болон төрийн оролцоог төсөв төлөвлөлт, хуваарилалт, хяналт, баталгаажуулалт зэрэг бүхий л шатанд хангах нөхцөл бүрдүүлээгүйгээс салбарын үр ашгийг бодитоор үнэлэхэд шаардлагатай цогц мэдээлэл бүрдэж чадахгүй хэвээр байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах ажлыг дан ганц дүрэм журам, захиргааны шийдвэрээр хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд ч бүрэн шийдвэрлэгдэх боломжгүй нь судалгаанаас харагдлаа. Учир нь уг салбарын мэдээллийг бүрэн хуримтлуулахад хувийн хэвчлээс гадна маш олон төрийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа чухал юм. Мөн тэдгээр оролцогчдын үүрэг, хариуцлагын асуудлыг цогцоор нь, харилцан уялдаатай тодорхойлж байж мэдээллийн чанар, бүрдэл, боловсруулалт, дүн

шинжилгээ сайжирч, төрийн бодлого, түүний үр нөлөө нэмэгдэж, эдийн засгийг төрөлжүүлэхэд хувь нэмэр оруулж чадна. Тиймээс бие даасан хууль батлан хэрэгжүүлэх замаар салбарын цогц мэдээллийг агуулсан мэдээллийн бааз суурь бий болгох, энэ чиглэлээр оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Цаашлаад олон улсын хөрөнгийн бирж, банк, санхүүгийн байгууллагуудын зээл олгох, нээлттэй зах зээлд хувьцаа гаргах, бондоор санхүүжилт босгох зэрэгт тавьж буй нэг шалгуур нь тухайн улсын зээлжих зэрэглэлийг үнэлэхээс гадна санхүүжилт босгох гэж байгаа олборлох салбарын компанийн мэдээллийн ил тод байдал болжээ. Мөн ОУИТБС зэрэг олон улсын санал, санаачилгыг хэрэгжүүлдэг байх нь энэхүү үнэлгээнд харгалзан үзэх нэг давуу тал хэмээн тооцогдох болжээ. Иймд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн салбарын өсөлт хөгжлийг дэмжихийн тулд уг салбарт ил тод байдлыг, олон улсын санаачилгыг бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаад байна.

Орон нутгийн иргэд олборлох салбарын байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөг илүүтэйгээр үүрч байгаа энэ үед орон нутгийн иргэдийн оролцоог хангаж байгалийн доройтол, нийгмийн сөрөг үр нөлөөнд төлбөр тооцож, түүгээрээ орон нутгийг хөгжүүлэх чиглэлийн төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой болно. Түүнчлэн олборлох салбарын орон нутагт шууд үзүүлж буй ажил эрхлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ ханган нийлүүлэх, гэрээт ажил гүйцэтгэх зэрэг эдийн засгийн эерэг нөлөөг нэмэгдүүлснээр орон нутагт харилцан ойлголцол, хамтын ажиллагаа бий болж, аж ахуйн нэгжүүд тогтвортой үйл ажиллагаагаа явуулах боломж, нөхцөл нь хангагдах боломжтой.

Олборлох салбарын мэдээллийг цогцоор нь ил тод болгоход чиглэгдсэн бие даасан хууль батлах нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, ялангуяа Төрийн болон албаны нууцын тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн

тухай, Хувь хүний нууцын тухай, Байгууллагын нууцын тухай зэрэг хуулиудад заасан хувь хүн болон байгууллагын мэдээллийг нууцлах эсхүл задруулж болох зохицуулалттай зөрчилдөхгүй. Мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний суурь зарчмуудыг хөндөхгүй, харин тэдгээрийг хангахад дэмжлэг болохуйц шийдэлтэй алхам болохыг дурдах нь зүйтэй.

6.2. ЗӨВЛӨМЖ

Дэлхийн улс орнуудын эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт нь ихэвчлэн кодекс буюу суурь хуулийн шинжтэй, үүнийгээ дагасан ашигт малтмал, гүн боловсруулалт, газрын тос, хий болон газар, ус зэрэг байгалийн баялаг ашиглах үйл ажиллагааны мэдээллийг бүхэлд нь хамардаг. Түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн зөвшөөрөл, өмчлөгч, эцсийн эзэмшигч, гэрээ, орлого, татвар төлөлт, хуваарилалт, орон нутгийн харилцаа, нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөлөөллийн талаар маш нарийн зохицуулалттай, харилцан уялдааг хангасан, аливаа төлөвлөлтийн шийдвэрт эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүх талуудын оролцоог хангах, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан бодлогын оновчтой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Иймд Монгол Улсын хувьд эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай бие даасан хууль боловсруулж, батлуулах шаардлагатай байна. Тус хууль нь дараах зохицуулалттай байвал зохино. Үүнд:

1. Хуулийн зорилго

- Хуулийн зорилго нь олборлох салбарт авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, мөнгө угаах зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох мэдээллийг тодорхойлох, цуглуулах, тайлагнах, олон нийтэд хүргэж мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн, энэ салбарын

дэлхийн чиг хандлага, хөгжлийн бодлоготой уялдсан байх шаардлагатай.

2. Хууль тогтоомжийн хамрах хүрээ

- Тус хууль нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх баримт бичиг болох учиртай.

3. Хуулийн үйлчлэх хүрээ

- Мэдээлэл гаргах төрийн байгууллагуудыг тодорхойлохдоо олборлох салбарын болон тус салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн үйл ажиллагаа, төсөв, санхүү, байгаль орчны мэдээллийг хуримтлуулах, нэгтгэх болон дүн шинжилгээ хийх үүрэгтэй, мөн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих эрхтэй, стандарт болон маягт батлах эрх бүхий төв захиргааны байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагыг хамруулж цогц мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Олон улсын жишгийн дагуу ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах болон бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн цогц мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Төрийн өмчит үйлдвэрийн газар ба төрийн өмчит компанийн цогц мэдээллийн ил тод байдлыг хангах.

4. Нэр томъёо

- Мэдээлэл, тайлан, нэгтгэсэн тайлан, тайлагнал, эцсийн өмчлөгч, холбоотой этгээд, хамаарал бүхий этгээд, толгой компани, төлбөр төлөгч, тайлан гаргагч, төлбөр, хураамж, татвар, ашиг, үр өгөөж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, төсөл, үйл ажиллагаа, тайлагнах хэрэгсэл, хугацаа, мэдээллийг баталгаажуулах, зөрчил зэрэг тодорхойлолтуудыг тодорхой тайлбарласан байх.

5. Тайлагнах, мэдээлэх мэдээлэл

- Эрх зүйн орчин болон санхүүгийн горимын талаар
 - i. Олборлох салбарыг зохицуулж байгаа эрх зүйн хүрээ, мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын шинэчлэл болон холбогдох төрийн байгууллагуудын хариуцаж буй чиг үүрэг, тэдгээрийн өөрчлөлт;
 - ii. Салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөөц боломж, татвар, хураамж, төлбөр, үйлдвэрлэл, төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэх;
 - iii. Төсвийн бодлого, төсвийн хуваарилалтын түвшин, орон нутгийн шилжүүлэгтэй (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжин, эсвэл шууд аймгууд руу шилждэг) хамаарах мэдээлэл;
 - iv. Тусгай зөвшөөрлүүдийн төрлийн талаарх тайлбар, ашигт малтмал, түгээмэл тархацтай болон цацраг идэвхт ашигт малтмалын болон газрын тос, байгалийн хий хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох, БХГ байгуулах журам, түүний техникийн болон санхүүгийн шалгуурын тухай, мөн тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явцын тухай иж бүрэн мэдээлэл;
 - v. Олборлох салбарын үйл ажиллагаа явуулж болох газрын кадастрын мэдээлэл, задаргаа тайлбар, өөрчлөлт, талбайн солбицол;
 - vi. Төрөөс олборлох салбарт хэрэгжүүлсэн ажлыг баримтжуулан, мэдээлэх.
- Тусгай зөвшөөрөл
 - i. Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул ба олборлолтын хүчинтэй, шинээр олгосон, цуцалсан, маргаантай тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, нээлттэй шалгуур, сонгон шалгаруулалтад оролцсон ААН-ийн жагсаалт,

шалгараагүй үндэслэл тайлбар, өөрчлөлтийн мэдээлэл, магадлан баталгаажуулалтын мэдээллийг төрийн байгууллага ил тод болгох;

- ii. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл, өөрчлөлтийн мэдээлэл, шалгуур болон магадлан баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг ААН ил тод болгох;
 - iii. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, дуусах огноо, тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ.
- Гэрээ
- i. Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул ба олборлолттой холбоотой төрийн байгууллагуудын хувийн хэвшлийн ААН-тэй байгуулсан гэрээний бүх нөхцөл ба хавсралт, нэмэлт өөрчлөлтийг бүрэн эхээр нь ил болгох;
 - ii. Орон нутагт ААН-үүдийн байгуулсан гэрээ, нэмэлт өөрчлөлт, хавсралтуудыг бүрэн эхээр нь ил болгох;
 - iii. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах төлөвлөгөө;
 - iv. Тусгай зөвшөөрлийг түрээслэх, барьцаалахтай холбоотой гэрээ, түүний мэдээлэл, нэмэлт, өөрчлөлт;
- Эцсийн өмчлөгч
- i. ААН-ийг эцсийн өмчлөгчөө бүртгэж, тогтмол мэдээлэхийг шаардах ба мэдээлэх хэлбэр нь өөрийн мэдээллийн хэрэгсэл болон төрийн байгууллагын ннэгдсэн мэдээллийн сан байх;
 - ii. Эцсийн өмчлөгч хувь хүний нэр, иргэншил, оршин суух улс, өмчлөлийн түвшин, удирдлага, эрх мэдэл хэрэгжүүлэх хэлбэр, иргэний баримт бичгийн дугаар, төрсөн огноо, оршин суух ба ажлын газрын хаяг, холбогдох утас гэх мэт шаардлагатай бүх мэдээллийг төрийн байгууллага авах;

- iii. Мэдээллийн аль хэсгийг нийтэд ил тод болгохыг зохицуулах эрх хэмжээг Олон талт хамтын ажиллагааны бүлэгт олгох;
 - iv. ААН-ийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүрдүүлж буй төрийн бодлого ба ил тод болгож буй байдлыг баримтжуулан мэдээлэх;
 - v. ААН-үүдийн эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээллийн зураглал хөтөлж нийтэд ил тод болгох;
 - vi. Эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тодорхойлж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.
- Бүтээгдэхүүн, үйлдвэрлэл
 - i. Үйлдвэрлэлийн мэдээлэл, хэмжээ, өртгийг түүхий эд бүрээр гаргаж мэдээлэх, мэдээллийг бүс нутаг, компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилсан мэдээллийг тухай бүр гаргаж ил тод мэдээлэх.
 - Экспорт
 - i. Экспортын хэмжээ, нийт үнэ, худалдан авагчийн мэдээллийг түүхий эд, бүс нутаг, компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилсан мэдээллийг тухай бүр гаргаж ил тод мэдээлэх.
 - Татвар, төлбөр, хураамж
 - i. Уул уурхай, газрын тос, хийн компанийн бүхий л томоохон төлбөрийг тогтмол, нээлттэй байдлаар төр болон ААН-ээс авч ил тод болгон зөрүүг тодорхойлох боломжтой болгох;
 - ii. Олборлох салбарын татвар, хураамж, ногдол ашиг тусгай зориулалтын сангуудад хэрхэн, ямар байдлаар хуваарилагдаж байгааг ил тод болгох;

- iii. Засгийн газрын хувьд ногдох ашиг (жишээ нь газрын тосны ашиг);
- iv. ААНОАТ болон бусад холбогдох татварын орлого;
- v. Нөөцийн төлбөр;
- vi. Ногдол ашиг;
- vii. Шагнал урамшуулал, жишээ нь гарын үсгийн, хайгуулын ажлын, үйлдвэрлэлийн гэх мэт;
- viii. Тусгай зөвшөөрлийн төлбөр, түрээсийн төлбөр, лиценз болон концесстой хамаарах бусад төлбөр;
- ix. ЗГ-ын хүртэж буй бусад томоохон хэмжээний орлого болон материаллаг үр шим;
- x. Аливаа төлбөр болон бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцоогоор ханган нийлүүлэх, (зээл, тусламж олгох, дэд бүтэц барих гэх мэт) үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр байгаа эсэхийг авч үзэж хоёр талаас зэрэг ил болгох нөхцөлийг бүрдүүлэх;
- xi. Усны төлбөр төлсөн мэдээлэл;
- xii. Газрын төлбөрийн мэдээлэл.
- Мөнгөн бус орлогын мэдээлэл гаргах,
- Тээвэрлэлт
 - i. Тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл: Тээвэрлэж буй бүтээгдэхүүн, маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани, төрийн байгууллага;
 - ii. Тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар;
 - iii. Тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
 - iv. Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлого.

- ТӨК
 - i. Татвар, төлбөр, хураамж хэсэгт заасан мэдээлэл;
 - ii. Үндэсний төрийн өмчит компанийн үйлдвэрлэлийн эрх;
 - iii. Үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах, эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого;
 - iv. Хэрэв зээл, зээлийн баталгаа гаргасан бол холбоотой мэдээллийг ил болгох;
 - v. Арилжааны зээлийн нөхцөлтэй харьцуулалт хийж мэдээлэх;
 - vi. Аудитын тайлан эсхүл санхүүгийн үндсэн баримтыг нийтэд ил болгох;
 - vii. Ханган нийлүүлэлт, засаглал, үйл ажиллагааны зардал, ТУЗ бүрэлдэхүүн, томилгоо, эрх, үүрэг, шийдвэр, шагнал урамшуулал, ёс зүйн дүрэм журмыг ил болгох;
 - viii. Борлуулалтын орлогыг борлуулагч тус бүрээр, мөнгөн хэлбэр эсхүл своп гэрээ, нөөцөөр баталгаажсан зээл зэрэг бусад хэлбэрийг тодорхойлох;
 - ix. Худалдан авагчийг сонгон шалгаруулсан нөхцөлийн тайлбар, хууль тогтоомжоос зөрсөн аливаа томоохон зөрүү, худалдах, худалдан авах гэрээ, техникийн болон санхүүгийн шалгуурыг нийтэд ил тод болгох, тухайн худалдан авагч компани хүлээн авсан хэмжээ, төлсөн дүнг мөнгөн ба бусад хэлбэрээр, гэрээний хамт ил тод болгох;
 - x. Төрийн өмчит аж ахуйн нэгж хооронд болон бусад төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй материаллаг төлбөр.
- Орон нутгийн төлбөр, нийгмийн хариуцлага, хандив, тусламж
 - i. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд төрийн болон төрийн иргэн, хуулийн этгээдэд өгсөн

хандив, тусламж зэрэг татварын бус төлбөрийн талаарх мэдээлэл, хэмжээ, зориулалтыг тусгах;

- ii. Төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд өгсөн ажил, үйлчилгээний төрөл, төлбөрийн дүн;
- iii. Нөхөн сэргээлт, нөхөн сэргээлтэд төлсөн төлбөр, төлөвлөгөө, түүний хэрэгжилт;
- iv. Орон нутгийн гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилт.

- Олборлох салбарын орлогын хуваарилалт, зарцуулалтын мэдээг төрийн байгууллагаас тогтмол гаргах.
- Хөдөлмөр эрхлэлт, жендэрийн мэдээллийг төрийн байгууллагаас салбар, аймаг, сум зэргээр, ААН-ээс ерөнхий байдлаар.

6. Тайлагнах, мэдээлэх аргачлал

- Тайланг ямар хэлбэрээр гаргахыг хэлэлцэн шийдвэрлэх эрх, үүргийг тодорхойлох;
- Мэдээллийг байршуулах хэлбэр;
- Тайланг байршуулах, мэдээлэх хэлбэр;
- Мэдээллийг олон нийт ашиглахад хялбар байх нөхцөл;
- Толгой компани, хамаарал бүхий этгээд, холбоотой этгээдийн тайлан гаргах зарчим зэргийг тодорхойлох;
- Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдэд бүртгэлтэй биржээс хувьцааны ханшид нөлөөлөх мэдээллийг тодорхой зорилгоор, тодорхой хугацаанд хаах зэрэг зохицуулалтын шаардлага тавьдгийг анхаарч, холбогдох этгээдийг олон улсын хөрөнгийн биржийн шаардлагыг зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

7. Нэгтгэлийн тайлан

- Төрийн байгууллага болон ААН-ийн гаргасан мэдээллийг ААН, орд, төсөл, бүтээгдэхүүн, боловсруулалт, хэмжээ зэргээр гаргаж, тулган баталгаажуулах;

- Төрийн байгууллага болон ААН-ийн гаргасан мэдээллийн зөрүүг гаргах;
 - Зарчмын зөрүүтэй асуудлыг тодорхойлох;
 - Хараат бус аудиторт газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтийн төлбөр, үүнд хамаарах материаллаг болон мөнгөн бус төлбөр зэргийг нэгтгэлд хамруулж байх үүрэг ноогдуулах талаарх мэдээллийг ил тод болгох;
 - Ил тод байдлыг нэмэгдүүлэх, салбарын бодлого зохицуулалт, засаглалыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөх.
8. Тайлагнах хугацаа ба журам
- ААН-үүд нэгтгэлийн тайлан, тогтмол тайлан болон тодорхой хугацаанд гаргах тайлан, мэдээллийн хугацааг ялгамжтайгаар тодорхойлох;
 - Төрийн байгууллагаас мэдээллээ хүргүүлэх, тайланг нийтэд ил тод болгох хугацаа, журмыг тодорхойлох;
 - Мэдээллийг хэрэглэгч, олон нийт ашиглахад хялбар байдлаар боловсруулалт хийх, ил болгох зэрэг зарчмыг тодорхойлох.
9. Мэдээллийг хадгалах ба мэдээллийн аюулгүй байдал
- Оюуны өмч, хувийн нууц, байгууллагын нууцад тооцогдох мэдээлэл, мэдээллийн нууцлалыг хамгаалах;
 - Мэдээлэл технологийн аюулгүй ажиллагаа;
 - Хуримтлагдсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зохицуулалт;
 - Мэдээллийг хадгалах хугацаа, хэлбэр.
10. Мэдээлэл авах, мэдээллээр хангах
- Мэдээлэл авах, мэдээллээр хангах журмын зохицуулалт, мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг;
 - ААН-ийн эцсийн өмчлөгчдийн мэдээллийн баазыг ашиглах зохицуулалт;

- Бусад хуримтлагдсан мэдээллийг баазаас авч ашиглах;
- Нууцад хамаарах мэдээллийг ашиглах зохицуулалт, эрх, үүрэг. Мэдээллийн нууцын зарчим, бусад хууль тогтоомжид нийцүүлэн зарим мэдээллийг задаргаагүй, ерөнхий байдлаар нийтэд мэдээлэх, дэлгэрэнгүй мэдээллийг хүсэлтэд үндэслэн гаргаж өгөх зэргээр зарчмын ялгаатай зохицуулалт бий болгож болох;
- Гомдол гаргах, гомдол шийдвэрлэх зохицуулалт.

11. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- Зөрчлийг арилгахад өгөх хугацаа, сануулга өгөх хэлбэрийг тодорхойлох;
- Олборлох салбарын компани, толгой компани, холбоотой этгээд хууль тогтоомж зөрчсөнд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай тодорхойлох;
- Төлбөр төлөгчийн албан тушаалтан, эрчим хүч ба нүүрсний салбарт зориулсан нийтийн бодлого бий болгох эрх бүхий төрийн төв байгууллага, геологийн судалгаа, газрын гүний нөөц ашиглах талаарх бодлого боловсруулж мөрдүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад хууль тогтоомж зөрчсөнд хүлээлгэх хариуцлага, торгуулийн хэмжээ;
- Үйлдэл, эс үйлдэхүй, хариуцах этгээд тус бүрт хариуцлага ногдох эсэхийг тодорхойлох..

12. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих

- Төрийн байгууллагын эрх хэмжээ
 - i. Хуулийн хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулах, холбогдох дүрэм, журам боловсруулж мөрдүүлэх, тайлагналтын стандартыг тогтмол сайжруулах чиг үүрэг бүхий төр, иргэний нийгэм, хуулийн этгээдийн гурван талт, хамтын ажиллагааны бүтцийг байнгын ажиллагаатай болгож баталгаажуулах;

- ii. Гурван талт бүтцийн төлөөллийг нээлттэйгээр сонгон шалгаруулах, төлөөллөөр томилох, чөлөөлөх, хасах зохицуулалт бий болгох, мэргэжлийн зөвлөл, судлаачдын төлөөллийг уг бүтцэд заавал хамруулах, ;
- iii. Мэдээллийг хэрхэн задлах түвшин, мэдээлэх хугацааг нарийвчлах зэрэг асуудлыг тодорхойлох;
- iv. Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- v. Мэдээлэл харилцан солилцох эрх хэмжээ, үүрэг, хариуцлагыг тодорхойлох,
- vi. Холбогдох эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээ, үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- vii. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- viii. Мэдээллийн ангиллыг хийх;
- ix. Төрийн байгууллага болон ААН-ийн үүрэг хариуцлагыг хянах зохицуулалт.

13. Шилжилтийн нөхцөл

- Хуульд заасан үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа зэрэг шилжилтийн зохицуулалтыг тодорхойлох.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Олон улсын стандарт, судалгааны материал

- EITI Standard, 2019
- EITI guide on beneficial ownership <https://eiti.org/document/guidance-beneficial-ownership>
- EITI factsheet on beneficial ownership <https://eiti.org/document/beneficial-ownership-fact-sheet> .
- Transparency International, Policy Briefing 02/2014
- Mongolia Country Strategy Note, Natural Resource Governance Center, 2015
- Transparency International, Technical Guide, Implementing the G20 Beneficial Ownership Principles, 2015
- Owning Up: Options for Disclosing the Identities of Beneficial Owners of Extractive Companies <http://www.resourcegovernance.org/analysis-tools/publications/owning-options-disclosing-identities-beneficial-owners-extractive>
- <https://www.gov.uk/government/publications/anti-corruption-summit-country-statements>
- FATF recommendations on combating money laundering and terrorism financing, 2017
- FATF, APG Follow Up Report Mongolia, 2019
- Олборлох салбарын ашиг хүртэгч эцсийн эздийн ил тод байдал, Нээлттэй Нийгэм Форум, 2017
- ЕСБХБ-ны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилтийг дэмжих төслийн хүрээнд Адам Смит Интернэшнл байгууллагаас хийсэн “Эрх зүйн хувилбаруудын дүн шинжилгээ, зөвлөмж”, 2013 он
- Бусад

Үндэсний хууль тогтоомж, бусад материал

- Үндсэн хууль, 1992 он
- Авлигын эсрэг хууль, 2006 он
- Компанийн тухай хууль, 2011 он
- МУТСТ тухай хууль, 2013 он

- НАНБХАСЗАСЗУС тухай хууль, 2012 он
- Татварын холбогдох хууль тогтоомж,
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 он
- Банкны тухай хууль, 2010 он
- Ашигт малтмалын тухай хууль, 2006 он
- Газрын тосны тухай хууль, 1991 он
- Цөмийн энергийн тухай хууль, 2009 он
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014 он
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2018 он
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он
- Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016 он
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2011 он
- Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он
- Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он
- Төрийн байгууллагууд /СЗХ, МХБ, АМГ г.м/-ын тайлагналтын стандарт, холбогдох журмууд,
- Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, эрх хэмжээ,
- УИХ-ын тогтоолууд, 2006 – 2019 он
- Засгийн газрын тогтоолууд, 2006- 2019 он
- Ерөнхий сайдын захирамж, 2006- 2019 он
- Сайдын тушаалууд, 2006- 2019 он
- Ашигт малтмалын газраас баталсан дүрэм, журам, 2006- 2019 он
- Бусад материал

ОУИТБС-ын шаардлага, холбогдох дүрэм, журам

- www.eitimongolia.mn
- Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангууд 2010-2018
- Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалтын тайлангууд 2010-2018
- EITI recommendations on mainstreaming
- Бусад

7. ХАВСРАЛТУУД

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХҮНИЙ ЭРХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

7.1. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Хүний эрхийн суурь зарчмуудыг баталгаажуулна. Тэгш эрхийн зарчмыг хангана.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Зохицуулалтын хувилбар нь ялгаварлан гадуурхсан байдал үүсгэхгүй.
	1.2. Оролцоог хангах		
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй

	<p>1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон. Орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн мэдээлэл авах, тэгш эрхийг хангана.</p>
	<p>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага</p>			
	<p>1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Харилцаанд оролцож байгаа талууд, иргэдийн эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.</p>
	<p>1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмдын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Хуулийн зохицуулалт нь шударга ёс, хариуцлагатай байдал сайн засаглалыг бүрдүүлэхэд үр нөлөөтэй бөгөөд ингэснээр иргэдийн тэгш эрхийг хангаж, салбарын үр өгөөжийг зохистой хүртэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх үр дүнтэй байх болно.</p>
	<p>1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулна.</p>
<p>2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх</p>	<p>2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Нийтлэг нийтийн эрх ашиг, шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр зарим тодорхой хязгаарлалт тогтооно.</p>

	<p>2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.</p> <ul style="list-style-type: none"> • Иргэд • Онцлог хэрэгцээтэй иргэд • Хувийн хэвшил • Төр • Иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд гэсэн бүлүүдийн эрх үүрэг тодорхойлогдоно
<p>3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх</p>	Тийм	Үгүй		<p>Нийтийн эрх ашгийн асуудал хөндөгдөж байгаа тул бүх талын оролцоог бодитой хангах зорилгоор ялгаж тодорхойлно.</p>
<p>3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх</p>	Тийм	Үгүй		<p>Энэхүү асуудал нь нийт иргэдийн эрх ашгийг хөндөх тул эмзэг бүлгийн иргэдэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх зохицуулалтыг тусгана.</p>
<p>3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх</p>	Тийм	Үгүй		<p>Нийгмийн эмзэг бүлэг, эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн судалгаа, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийг ангиллах зохицуулалтыг тодорхойлно.</p>
<p>3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)</p>	Тийм	Үгүй		

4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн үүрэг хүлээнэ. Эрдэс баялгийн салбарын оролцогчдыг тодорхой ангилж, үүрэг хариуцлагыг тодорхой тусгана.
	5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх 5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй

7.2. ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх Үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын ААН болон гадаадын хөрөнгө оруулалттай ААН хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Шударга өрсөлдөөн бий болгохыг дэмжинэ.

	<p>1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)</p>	Тийм	Үгүй	<p>Олон улстай татварын болон эцсийн өмчлөгчийн мэдээлэл солилцоход ахиц дэвшил гарна. Татвараас зайлсхийх, зугтах нөхцөлд хяналт сайжирч, хариуцлагыг тодорхойлсноор улсын төсөв бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ.</p>
	<p>1.3. Дэлхийн зах зээл дээрх гаагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Дэлхийн зах зээл дээрх бохир мөнгөний урсгалыг хянах, нэвтрүүлэхгүй байхад цогц мэдээлэлд хяналт тавих нь ач холбогдолтой. Бусад улстай нарийвчилсан, тодорхой мэдээллийг солилцох, иргэний нийгэм, судлаачдын чадавхыг бэхжүүлснээр Монголын зах зээлд бохир мөнгө орж ирэхээс хамгаалах нөхцөл бүрдэнэ.</p>
<p>2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал</p>	<p>2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх</p> <p>2.3. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх</p> <p>2.4. Зах зээлд шинээр орж ирж байгаа ААН-д бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх</p> <p>2.5. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх</p>	Тийм	Үгүй	<p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p>

<p>3. ААН-ийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал</p>	<p>3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр ААН-д шинээр зардал үүсэх эсэх</p> <p>3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх</p> <p>3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх</p> <p>3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх</p> <p>3.5. ААН-ийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх</p>	<p>Тийм</p> <p>Тийм</p> <p>Тийм</p> <p>Тийм</p> <p>Тийм</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	<p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ил тод байдлыг хангах нь олон улсын санхүүгийн байгууллагуудын санхүүжилт олгох шалуур болсон тул дотоодын аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахад санхүүжилт босгоход дэмжлэг болох эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p> <p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p>
<p>4. Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал</p>	<p>4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх</p>	<p>Тийм</p> <p>Тийм</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p>	<p>Зардал нэмэгдэх хэмжээний процесс хийгдэхгүй. Ил тод байдал, мэдээлэхтэй холбоотой хуулийн этгээдийн ажилтныг томилох, мэдээллийг баталгаажуулах ажилтанд эрх олгох шаардлагатай.</p>

5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Эцсийн өмчлөгчтэй холбоотой зохицуулалт бий болох ч өмчлөх эрхийг хөндөхгүй.
5. Өмчлөх эрх	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн хязгаарлалт хийгдэхгүй
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн тусгайлсан бүлгийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын төсвийн төлөвлөлт ба зарцуулалтыг судлах, боловсруулахад дэмжлэг үзүүлэх цогц мэдээллийн бааз үүснэ.
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Эрдэс баялгийн салбарын шударга өрсөлдөөн, аж ахуйн нэгжүүдийн засаглал, хариуцлагыг сайжруулснаар хариуцлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, хэрэглээний үнийн түвшинд эерэг нөлөө үзүүлэх магадлалтай.

	<p>7.3. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутгийн гэрээ байгуулсан эсэхийг хянах, үүргээ хэрэгжүүлэхийг шаардах боломжтой болно. Орон нутгийн гэрээнд орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл тусгагддаг учраас дотоодын зах зээлийн цар хүрээ нэмэгдэх боломжтой.</p>
	<p>7.4. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p>
	<p>7.5. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутгийн гэрээ байгуулсан эсэхийг хянах, үүргээ хэрэгжүүлэхийг шаардах боломжтой болно. Орон нутгийн гэрээнд орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл тусгагддаг учраас хувь хүн, гэр бүлийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.</p>



<p>8. Тодорхой бүс нутаг, салбарууд</p>	<p>8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутгийн гэрээ байгуулсан эсэхийг хянах, Үүргээ хэрэгжүүлэхийг шаардах боломжтой болно. Орон нутгийн гэрээнд орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл тусгагддаг учраас ажлын байр нэмэгдэнэ.</p>
	<p>8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй</p>
	<p>8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Жижиг дунд үйлдвэр эрхлэх асуудалд эерэг нөлөө үзүүлнэ. Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутгийн гэрээ байгуулсан эсэхийг хянах, үүргээ хэрэгжүүлэхийг шаардах боломжтой болно. Орон нутгийн гэрээний дагуу орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих боломж нэмэгдэх учраас орон нутгийн бизнест эерэг нөлөө үзүүлнэ.</p>

<p>9. Төрийн захиргааны байгууллага</p>	<p>9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Улсын төсөвт эрдэс баялгийн салбараас орж ирэх орлогыг тодорхой болгох, нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй бөгөөд төсвийн төлөвлөлтийг тодорхой болгох боломж бүрдэнэ. Саарал эдийн засаг буюу авлига, хээл хахууль, сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бууруулж төр, иргэн, иргэний нийгмийн хяналт сайжирснаар эдийн засгийн ил тод байдал сайжирч, улсын төсөвт зэрэг нөлөө үзүүлнэ.</p>
	<p>9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>ОУИТБС-ын төслийн нэгжийн бүтцийг бэхжүүлэх, бие даасан статус бүхий институт байх талаас дэмжинэ.</p>
	<p>9.3. Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Зарим холбогдох төрийн байгууллагуудын чиг үүрэгт эрдэс баялгийн салбарын мэдээллийг тогтмол болон тодорхой хугацаанд цуглуулах, нэгтгэх, тайлагнах, дүн шинжилгээний нарийвчлалыг боловсруулах, мэдээлэх, иргэдэд холбогдох тодруулга өгөх зэрэг чиг үүргийн нарийвчлал тусгагдана.</p>

<p>10. Макро эдийн засгийн хүрээнд</p>	<p>10.1. Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Улсын төсвийн хуримтлалыг бүрэн төвлөрүүлэх, төсвийн төлөвлөлтийг тодорхой болгох боломж бүрдэнэ. Саарал эдийн засаг буюу авлига, хээл хахууль, сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бууруулж төр, иргэн, иргэний нийгмийн хяналт сайжирснаар эдийн засгийн ил тод байдал сайжирч, улсын төсөв болон эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор хувийн хэвшлийн байгууллагуудад ажлын байр нэмэгдэх эерэг нөлөө үзүүлнэ.</p>
	<p>10.2. Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Олон улсын стандартын дагуу ил тод байдлыг хангах нь олон улсын санхүүгийн байгууллагуудын санхүүжилт олгох шалгуур болсон тул дотоодын аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулах санхүүжилт босгоход эрсдэлийг хянах боломж бүрдэж, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эерэг нөлөө үзүүлнэ. Эрсдэл буурахад хөрөнгө оруулалтын хүү буурч хөрөнгө оруулалтын нөхцөл сайжирна. Мөн хариуцлагатай хөрөнгө оруулалт нэмэгдэх давуу талтай.</p>
<p>11. Олон улсын харилцаа</p>	<p>10.3. Инфляц нэмэгдэх эсэх 11.1. Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Сөрөг нөлөө байхгүй. Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.</p>

7.3. НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх Үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутагтай гэрээ хийсэн эсэхийг хянах, үүрэг хэрэгжилтийг шаардах боломжтой болно. Уг гэрээнд орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл тусгагддаг учраас ажлын байр нэмэгдэнэ.
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутагтай гэрээ хийсэн эсэхийг хянах, үүрэг хэрэгжилтийг шаардах боломжтой болно. Уг гэрээнд орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл тусгагддаг учраас орон нутгаас худагдан авалт хийх зэрэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд эерэг нөлөөтэй.

	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хяналт сайжирснаар гаргаж буй алдаа дутагдлыг илрүүлж, одоогийн хэрэгжих стандартад ялангуяа байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын чанарыг сайжруулахад эергээр нөлөөлнө.
	2.1. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	2.2. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	2.3. Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	ААН-үүдэд мэдээллийн ил тод байдлыг хангах, ил тод мэдээлэх үүргээ биелүүлэхэд баримтлах стандартыг бий болгоно.
	2.4. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.

3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны хүрээнд төр, олон нийт, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжрах, төрийн байгууллагын аливаа шийдвэрийг иргэд мэдэх эрх хэрэгжиж, бодит баримтад суурилан төр болон ААН-үүдээс харууцлага шаардах нөхцөл бүрдэх эерэг нөлөөтэй.

	<p>4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Зарим холбогдох төрийн байгууллагуудын чиг үүрэгт эрдэс баялгийн салбарын мэдээллийг тогтмол болон тодорхой хутагаанд цуглуулах, нэгтгэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх, иргэдэд холбогдох тодруулгыг өгөх зэрэг чиг үүргийн нарийвчлал тусгагдана. Төрийн байгууллагуудад дата мэдээлэлд суурилсан дүн шинжилгээ хийх мэргэжлийн боловсон хүчин ажиллуулахыг шаардах зэргээр нөлөөлж болно.</p>
<p>4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Хариуцлагыг сайжруулна.</p>	
<p>4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Иргэд эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрх нээлттэй.</p>	
<p>4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх</p>	<p>Тийм</p>	<p>Үгүй</p>	<p>Олборлох салбарын шударга бус өрсөлдөөнийг бууруулах, харуцлага тооцох, улс төрийн нөлөөллийг бууруулах асуудлыг улс төрийн намууд, улс төрчид мөрийн хөтөлбөртөө тусгаж, хуулийн хэрэгжилтийг шаардах боломжтой.</p>	

5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдэд мэдээлэл авах боломж бүрдэх, орон нутгийн гэрээний дагуу ажлын байр нэмэгдсэнээр амьдралын хэв маягт эергээр нөлөөлөх боломжтой.
6. Нийтийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд орон нутагтай гэрээ хийсэн эсэхийг хянах, үүрэг хэрэгжилтийг шаардах боломжтой болно. Уг гэрээний дагуу орон нутагт хамтын ажиллагаа, ажлын байр, үйлдвэрлэлтийг дэмжихдээ нийгмийн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэн, чанар, хүртээмжийг сайжруулахыг орон нутгийн засаг захиргаа бодлогоор дэмжих боломжтой.
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Орон нутагт ажлын байр нэмэгдсэнээр орон нутаг руу чиглэх шилжилт хөдөлгөөн нэмэгдэх магадлалтай.

7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	6.3. Иргэдийн боловсрол (гөрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй. Орон нутгийн иргэдийн мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийх чадавх сайжирна.
	6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүргэмжийг нэмэгдүүлэхэд орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН-үүд нутгийн захиргаагай зайлшгүй байгуулах гэрээний хүрээнд хувь нэмэр оруулах боломжтой.
	6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.

8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө байхгүй.
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулах ААН, нутгийн захиргаагай байгуулах гэрээ, шийдвэрийн талаар мэдээлэл нь иргэдийн тухайн орон нутаг дахь түүх, соёлоо хамгаалах эрхээ хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

7.4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх Үр Нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм Үгүй	Байгаль орчин, нийгмийн хариуцлагыг сайжруулсанаар бохирдол буурах боломжтой.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх	Тийм Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Урт хугацаанд хөрөнгө оруулалт, орон нутагт үйл ажиллагаа явуулах уул уурхайн компаниудын үйл ажиллагаа нэмэгдэх, улмаар том оврын тээврийн хэрэгслийн тоо, түлшний хэрэглээ нэмэгдэх магадлалтай.

	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Бусад хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийг дэд бүтэцжүүлэхтэй холбоотойгоор эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх магадлалтай.
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Бусад хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийг дэд бүтэцжүүлэхтэй холбоотойгоор эрчим хүчний эрэлг өсөж, үйлдвэрлэл нэмэгдэх боломжтой.
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Урт хугацаанд хөрөнгө оруулалт, орон нутагт үйл ажиллагаа явуулах уул уурхайн компаниудын үйл ажиллагаа нэмэгдэх, улмаар том оврын тээврийн хэрэгслийн тоо, түлшний хэрэглээ нэмэгдэх магадлалтай. Үүнтэй холбоотойгоор агаарын бохирдол нэмэгдэх магадлалтай. Байгаль орчин, нийгмийн хариуцлагыг сайжруулж бохирдлыг бууруулах арга хэмжээг орон нутгийн гэрээнд тусгасан байна.
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.

	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хамгаалалт, хязгаарлалтын бүсийг нэмэгдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, хамгаалалтад эерэг нөлөө үзүүлнэ.
	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
4. Усны нөөц	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй. Харин усны бохирдлыг бууруулах зохицуулалтыг орон нутгийн гэрээнд тусгах боломжтой.
	4.3. Үндны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	5.1. Хөрсний бохирдолгод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
5. Хөрсний бохирдол	5.2. Хөрснийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Урт хугацаанд хөрөнгө оруулалт, орон нутагт үйл ажиллагаа явуулах уул уурхайн компаниудын үйл ажиллагаа нэмэгдэх, улмаар хөрсний эвдрэл, ашиглах талбайн хэмжээ нэмэгдэх магадлалтай. Байгаль орчин, нийгмийн хариуцлагыг сайжруулах замаар хөрсний эвдрэл, гэмтлийг нөхөн сэргээхэд орон нутгаас хяналт тавих, орон нутгийн засаг захиргаатай ААН-үүд гэрээ байгуулж ажиллах нөхцөлийг дэмжинэ.

6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Тийм Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Бусад хууль тогтоомжийн хүрээнд орон нутагт ашиглагдаагүй байсан газрыг ААН-үүд ашиглах магадлалтай. Иймд орон нутгаас хяналт тавих, орон нутгийн засаг захиргаатай ААН-үүд гэрээ байгуулж ажиллах нөхцөлийг дэмжинэ.
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Хамгаалалтын зориулалт өөрчлөхгүй.
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө үзүүлэхгүй. Урт хугацаанд хөрөнгө оруулалт, орон нутагт үйл ажиллагаа явуулах уул уурхайн компаниудын үйл ажиллагаа нэмэгдэх, улмаар байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх магадлалтай.

7.5. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэ судалгаагаар дараах улсын хууль тогтоомжийг судалсан болно. Үүнд:

1. Канад: Олборлох салбарын ил тод байдлыг хангах хууль (Extractive Sector Transparency Measures Act 2014 (EST-MA)),
2. Европын холбоо: Ил тод байдлын тухай хууль (Transparency Directive (2004/109/EC) of the European Parliament and of the Council 2004)
3. Украин: Украины Олборлох салбарын ил тод байдлыг хангах тухай хууль (2545-VIII Law of Ukraine on ensuring transparency in extractive industries 2018)
4. Либер болон Нигер улсуудын хууль тогтоомжийн судалгааг Нээлттэй Нийгэм Форумын боловсруулснаар хавсаргав.
5. Олон улсад үр дүнтэйд тооцогдож буй ОУИТБС-ын Стандартаар ил тод болгох мэдээллийн жагсаалтыг боловсруулав.

7.5.1. Ерөнхий мэдээлэл

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын эрх зүйг Ашигт малтмалын эрх зүйтэй адилтган ойлгох боломжгүй. Тухайлбал, уг эрх зүйн зохицуулалтад дан ганц ашигт малтмалыг эрэх хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцаа хамаараад зогсохгүй холбогдох мэдээллийн бүртгэл, мэдээллийн удирдлага, менежмент, санхүүгийн сахилга бат, хариуцлага, олон нийтийн оролцоо зэргийг олон улсын худалдааны өрсөлдөөний заншилд тулгуурлан зохицуулдаг. Иймээс дэлхийн улс орнууд бие даасан Ил тод байдлын тухай хууль баталж мөрдөх жишиг тогтож байна. Хуульд

олон улсад хамгийн сайн жишээ, стандартад тооцогдох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартыг удиртгал болгох нь түгээмэл байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын судалгааны нэг хэсэг болох олон улсын холбогдох хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, санал, санаачилгын зөвлөмж, дэлхий улс орнуудын хөгжлийн чиг хандлага, туршлага зэрэгт үндэслэн боловсруулав. Хэдийгээр улс орнуудын хууль тогтоомжийг сонгон судлахдаа Монгол Улстай эрх зүйн салбарын хувьд ижил төстэй байх нөхцөлийг харгалзан үздэг ч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нийгэм болон эдийн засагт эерэг үр дүнг бүрдүүлэх эрх зүйн шийдлүүдийг судлан, хэрэгжүүлэх тохиолдол ч түгээмэл байдаг.

Энэхүү олон улсын харьцуулсан судалгааны арга зүйг дэлхий нийтийн чиг хандлага, улс орнуудын хөгжлийн арга зүй, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа нөхцөл шалтгааны хүрээнд тодорхойлон Хүний хөгжлийн индексээр тэргүүлэх 30 байранд багтах улс орнуудыг хамрах Европын холбоо, 12 дугаар байранд орсон Канад Улс, мөн Монгол Улстай ойролцоо түвшинд жагсаж⁴⁵ байгаа пост-социалист тогтолцоо, эх газрын эрхзүйтэй Украин зэрэг орнуудын хууль тогтоомжийг судалсан дүгнэлтийг нэгтгэж гаргалаа.

⁴⁵ Монгол Улс 92, Украин улс 88 дугаар байр, ХХИ 2018: http://hdr.undp.org/sites/default/files/2018_human_development_statistical_update.pdf

7.5.2. Олон улсын олборлох салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж

7.5.2.1. Канад Улсын Олборлох салбарын ил тод байдлыг хангах хууль⁴⁶

(Extractive Sector Transparency Measures Act 2014 (ESTMA S.C. 2014, с. 39, s. 376))

Хуулийн бүтэц	Нийт 29 зүйлгэй: 1 - Гарчиг 2 – Тайлбар ба Ерөнхий нөхцөл 5 – Эрх олгох 6 – Хуулийн зорилго 7 – Эрхэм дээдэс 8 – Хууль хэрэглээ 9 – Үүрэг хариуцлага a. 9 – Тайлагнах төлбөр b. 13 – Мэдээллийг хадгалах 14 – Удирдлага ба Хэрэгжилтийг хангах c. 14 – Мэдээлэл ба Бие даасан, хөндлөнгийн аудит d. 15 – Эрх олгох e. 16 – Эрх олгогдсон эггээдийн эрх хэмжээ f. 19 – Тушаал, шийдвэр — Зөрчлийг арилгах 20 – Сайдын эрх хэмжээ 23 – Зохицуулалт, журам 24 – Зөрчил ба Хүлээлгэх хариуцлага 29 – Шилжилтийн нөхцөл
---------------	--

⁴⁶ <https://www.mcjill.ca/mjsdl/files/mjsdl/bildfell.pdf>

Зорилго	<p>Тус хуулийн 6 дугаар зүйлд хуулийн зорилгыг томъёолохдоо “Канад Улс олборлох салбарын стандарт зарчмыг хэрэгжүүлэн аж ахуйн нэгжийн төлсөн төлбөртэй холбоотой тайлан, тайлагналтын ил тод байдлыг хангах арга хэмжээг сайжруулж, олон улсын авлигын эсрэг тэмцэлд нэгдэх зорилгоор хуулийг хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээ нь авлигыг олж илрүүлэх, тогтоох, түүнчлэн Эрүүгийн хуулийн 119–121 болон 341 дүгээр зүйл, мөн Гадаадын төрийн албан хаагчид авлига хээл хахууль өгөхтэй тэмцэх хуулийн 3 болон 4 дүгээр хэсэгт заасан авлигын аливаа хэлбэрийг таслан зогсоох зорилготой байхаар боловсруулав” гэсэн байна.</p>
Удирдлага	<p>Уг хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих эрх бүхий этгээд нь сайдын томилсон албан тушаалтнууд эсхүл нэгж байхаар заажээ.</p>
Мэдээлэх мэдээлэл	<p>Газрын тос, хий, ашигт малтмалыг боловсруулах, эрэх, хайхтай холбоотой дараах төлбөрийг мөнгөн дүнгээр эсхүл бусад хэлбэрээр төлснийг олон нийтэд ил тод болгодог:</p> <ul style="list-style-type: none"> (a) ААН-ийн үйл ажиллагаа, орлогын болон бусад татвар; (b) АМНАТ; (c) түрээс, төлбөр, шимтгэл, хураамж зэрэг лиценз, тусгай зөвшөөрөл эсхүл концесс, хөнгөлөлт өдлөхтэй холбоотой төлсөн төлбөрүүд; (d) үйлдвэрлэлтэй холбоотой гарсан төлбөр, зардал; (e) гарын үсэг зурах, нөөц илрүүлэх, үйлдвэрлэх зэрэгт олгосон урамшуулал; (f) энгийн хувьцаа эзэмшигчийн хувиар бус бусад хэлбэрээр хүртсэн ногдол ашиг; (g) дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх төлбөр; (h) бусад аливаа төлбөр; (i) Канадын ЗГ, бусад улсын ЗГ, төрийн байгууллага, хоёр ба түүнээс дээш ЗГ-ын хамтран байгуулсан субъект, траст, Удирдах зөвлөл, комисс, корпорац эсхүл байгууллага, удирдлага, аль нэг төрийн эрх бүхий этгээдэд төлсөн аливаа төлбөр, хураамж, шимтгэл, урамшуулал; (j) Бусад этгээдээр дамжуулан төлбөр төлөгчид төлөх төлбөр, төлөвлөгөөт төлбөр; (k) Хөрөнгийн биржид бүртгэлтэйгээс бусад этгээдээс хийгдсэн төлбөр; (l) Хөрөнгийн биржид бүртгэлтэйгээс бусад этгээдэд төлсөн төлбөр; (m) Төлбөрийн дүн, хэрэв дүнг тодорхойлох боломжгүй бол үзүүлсэн, нийлүүлсэн, хүлээн авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн шударга үнийг гаргаж өгнө.

	<p>(п) Түүнчлэн сайд нь мэдээлэх этгээдийн аль нэг эсхүл нийт мэдээллийг төсөл, төрөл, хэлбэр тус бүрээр задлан харуулахтай холбоотой журам, журмын хэрэгжилтийг хангах эрх бүхий этгээдийн эрх үүрэг, ажиллагаа, дагалдах техникийн баримт бичиг, мэдээлэл өгөх шугам зэргийн талаарх зохицуулалтыг баталж мөрдүүлж болно гэж заажээ. Гадаад улсын хууль тогтоомжоор задлан харуулж буй байдал нь шаардлага хангаж байна гэж үзвэл тухайн задаргааг хүлээн зөвшөөрөх боломжтой.</p> <p>(о) Амбан захирагч өөрийн эрх мэдлийн хэмжээнд холбогдох журмыг сайдын баталсан журамд нийцүүлэн дөнгөжүүлэн гаргаж болно.</p> <p>(р) Мөн нэг компанид төлсөн төлбөрийг ангилж тайлагнана.</p> <p>Харин Канадын Уугуул иргэдийн ЗГ болон Уугуул иргэдийн граст, Удирдах зөвлөл, комисс, корпорац эсхүл байгууллагад төлсөн төлбөрийг тайлагнах шаардлагагүйгээр зохицуулсан байна.</p>
<p>Мэдээлэх этгээд</p>	<p>а/ Уул уурхай, газрын тос, хийн хайгуул эсхүл олборлолт эрхлэх компани; б/ Уул уурхай, газрын тос, хийн хайгуул эсхүл олборлолт эрхлэх компанийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, түрээс эсхүл бусад аливаа хэлбэрийн эрхийг олж авсан эсхүл эзэмшдэг компани; в/ газрын тос, хий, уул уурхайн аливаа бусад холбогдолтой үйл ажиллагаа явуулж буй компаниуд, дампуурсан компаниуд нь \$20 саяын хөрөнгөтэй, эсхүл \$40 саяын орлого олсон бол эсхүл 250 ба түүнээс дээш ажилтантай бол хуульд заасан мэдээллийг санхүүгийн жил дууссанаас хойш 150 хоногийн дотор мэдээллийг гаргаж өгөхөөр заажээ.</p>
<p>Мэдээллийг баталгаажуулах, хариуцлага</p>	<p>Энэ хэсэгт компанийн гаргаж өгөх мэдээллийг гүйцэтгэх удирдлага болон албан тушаалтан эсхүл хараат бус аудитор, нягтлан бодогч үнэн, зөв гэдгийг баталгаажуулж хүргүүлэхээр заасан. Ингэснээр тухайн мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага хянаж баталгаажуулсны дараа буруу болох нь тогтоогдсон бол баталгаа гаргагчид энэ хууль, Эрүүгийн хууль эсхүл Гадаад төрийн албан хаагчид авлига хээл хахууль өгөхтэй тэмцэх хуульд зааснаар хариуцлага ногдуулах үндэслэл болно. Тайлагнах компанийн өмчлөлийн шатлалтай холбоотойгоор тайланг нэгтгэж гаргах шаардлагатай бөгөөд бүх мэдээллийг хамгийн багадаа 7 жилийн хугацаанд хадгалах шаардлага тавьсан нь авлига, санхүүгийн гэмт хэргийг хянаж шалгах үйл ажиллагааны цаг хугацааг харгалзан тогтоожээ.</p>

Түүнчлэн хугацаа, нөгтгэлийн тайлан гаргах, олон нийтэд ил тод болгох, хадгалах, мэдээллийг задлах, гаргаж өгөх журмын зохицуулалтыг зөрчигчдөд \$250,000 хүртэл канад долларын торгууль, худал мэдээлэл өгсөн нь тогтоогдвол \$250,000 хүртэл канад долларын торгууль, бэлэг, дурсгал зэрэг мөнгөн эсхүл мөнгөн бус хэлбэрийн төлбөрийн талаар нуусан нь тогтоогдвол \$250,000 хүртэл канад долларын торгууль ногдуулахаар зааж, дээрх торгуулийн журмыг зөрчих нь тусдаа, бие даасан хариуцлагатай байхаар зохицуулжээ. Тухайн торгуулийг компанид ногдуулахаас гадна баталгаа гаргасан албан тушаалтанд бие даасан хариуцлага тооцдог байна. Хээн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар зохицуулахдаа зөрчил илэрснээс хойш тооцохоор байна.

7.5.2.2. **Европын холбооны ил тод байдлын тухай хууль**⁴⁷

(Transparency Directive (2004/109/EC) of the European Parliament and of the Council 2004)

Бүтэц

Нийт 7 Бүлэг, 35 зүйл заалттай:

- I. Ерөнхий зүйл
- II. Заасан хугацаанд мэдээлэх
- III. Үргэлжлүүлэн тайлагнах мэдээлэл
- IV. Ерөнхий үүрэг хариуцлага
- V. Эрх бүхий байгууллага
- VI. Хэрэгжүүлэх арга хэмжээ
- VII. Шилжилтийн болон сүүлийн нөхцөл

⁴⁷ <https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2004:390:0038:0057:EN:PDF>

Зорилго	<p>Энэхүү хуулийн зорилго нь гишүүн орны зохицуулалттай хөрөнгийн биржид үнэт цаасны бүртгэлтэй компаниуд тогтмол хугацаанд болон тогтоосон хугацаанд тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна гэж заажээ. Санхүүгийн хэрэгслийн зах зээлийн тухай хууль (MiFID 2004/39/ЕС-н 4(1))-д зааснаар үнэт цаас гэдгийг дараах байдлаар тодорхойлжээ.</p> <p>“үнэт цаас” гэж (а) компанийн хувьцаа болон хувьцаанд тооцогдох компани, нөхөрлөл, бусад этгээдийн бусад үнэт цаас, хувьцааны хүлээн авсан депозит төлбөр; (b) бонд болон тухайн үнэт цаасны депозит төлбөр зэрэг баталгаа гаргасан өр төлбөр; (с) шилжих боломжтой үнэт цаасыг худалдан авах эсхүл худалдах эрх бүхий, мөн бэлэн мөнгө төлж авах үнэт цаас, валют, хүү эсхүл хүүгийн орлого, түүхий эд эсхүл бусад индекс зэрэг аливаа бусад үнэт цаасыг хөрөнгийн зах зээл дээрх төлбөрийн нөхцөлөөс бусад хэлбэрээр зөвшилцөн авсан ангилалд багтах, шилжих боломжтой үнэт цаасыг хэлнэ.</p> <p>Энэ нь уг хууль зөвхөн зохицуулалттай этгээдэд хамаарах бус хувьцаа, бонд гаргах, төлбөр, депозит, хүү, өгөөж хүртэх зэргээр нийт аж ахуйн нэгжид хамаарахаар байна.</p>
Удирдлага	<p>Гишүүн улс бүр хамгийн багадаа нэг албан ёсны эрх бүхий төв байгууллагыг байгуулж, уг мэдээллийг хянах үүргийг хэрэгжүүлнэ. Гишүүн улсаас бүрдсэн Комисс нийтлэг журам, мэдээллийн задаргааг тодорхойлох зохицуулалтыг бий болгож мөрдүүлнэ. Мэдээлэлд гарсан зөрүүт гишүүн орнууд харилцан танилцуулж, холбогдох мэдээллийг харилцан гаргаж өгнө.</p>
Мэдээлэх мэдээлэл	<p>Мэдээлэх үүрэгтэй этгээд гэдэгт хуулийн этгээд болон тухайн хуулийн этгээдийн хувь эзэмшигч, эцсийн өмчлөгч аль аль нь хамаарах ба хариуцлагыг аль алинд нь ногдуулахаар томъёолжээ.</p> <p>Тогтмол хугацаатай мэдээлэлд:</p> <ul style="list-style-type: none"> - Жилийн санхүүгийн тайланг 4 сарын дотор тайлагнан 5 жилийн хугацаанд ил тод байлгах; - Нэгтгэлийн тайлан; - Толгой компанийн санхүүгийн тайлан; - Аудитын тайлан; - Удирдлагын түр болон батлагдсан тайлан, мэдэгдэл; - Хагас жилийн санхүүгийн тайлан.

	<p>Тогтмол тайлан:</p> <ul style="list-style-type: none"> - Хамгийн том дүнтэй хувьцаа эзэмшлийн талаарх мэдээллийг 5%, 10%, 15%, 20%, 25%, 30%, 50% болон 75 хувийн эзэмшлээр гаргах, өмчлөлийг шууд болон шууд бусаар эзэмшиж байгааг гаргах. Үүнээс доош хувь эзэмшлийн мэдээллийг гаргах шаардлагагүй; - Саналын эрхийн талаарх мэдээлэл; - Мөн саналын эрх, хувьцаа эзэмшлээ худалдах, бусдад шилжүүлэх зорилготой байгаа хувь хүн, хуулийн этгээд уг мэдээллээ урьдчилан, мөн хувьцааны арилжаа явагдах 4 өдрийн дотор зохицуулалттай этгээдэд мэдээнэ. Харин компани 3 өдрийн дотор олон нийтэд мэдээнэ. Уг мэдээллийг гаргаж өгөхөө хувьцаа эзэмшигч, толгой компани нь гаргаж өгөхөө баталж, баталгаа гаргасан ж өгсөн байна. Уг баталгааг эрх нь үүсэх үед гаргуулсан байна. - Дээрх мэдээллийг тайлагнахдаа саналын эрх, хувь эзэмшил, эцсийн өмчлөлийг шилжүүлэх болсон шалтгаан, саналын эрхэд нь өөрчлөлт орох толгой компани, удирдлага болон хэлхээ компанийн талаарх мэдээлэл. <p>Комисс нь мэдээллийн задаргааг гаргаж мөрдүүлнэ. Ингэхдээ хувьцааны ангилал тус бүрээр зохицуулалтыг өөрөөр хийж болно.</p>
Мэдээлэх этгээд	<p>Гишүүн улсын төр, бүс нутаг эсхүл орон нутгийн удирдлага болон нэг тал нь гишүүн улсад багтдаг олон улсын байгууллага, нийт олгосон зээл нь EUR100,000,000-оос бага дүнтэй бол зээл олгох байгууллага, гишүүн улсад үйл ажиллагаа явуулах хөрөнгийн биржид бүртгэлтэй бөгөөд EUR50,000-оос доош хөрөнгөтэй этгээд тайлан гаргахгүй байж болно.</p>
Мэдээллийг баталгаажуулах, хариуцлага	<p>Гишүүн улс бүр хамгийн багадаа нэг албан ёсны эрх бүхий төв байгууллагыг байгуулж, уг мэдээллийг хянах үүргийг хэрэгжүүлнэ. Мөн гишүүн улс хооронд мэдээлэл солилцох, тохиргоо хийх ажлыг хариуцна гэж тусгажээ.</p> <p>Гишүүн улс бүр өөрийн хариуцлагыг дотоодын нөхцөлд, зохицуулалтад тохируулан давхар хариуцлага тооцох эрхэд халдахгүй бөгөөд үр дүнтэй, зөрчилд тохирохуйц, таслан зогсоох агуулгатай арга хэмжээг авсан байна. Түүнчлэн гишүүн улс авсан арга хэмжээний талаар олон нийтэд заавал мэдээлэх үүрэгтэй. Харин санхүүгийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлэхүйц ноцтой эсхүл талуудыг эрсдэлд оруулах хэмжээний мэдээллийг олон нийтэд дэлгэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>

7.5.2.3. **Украины Олборлох салбарын ил тод байдлыг хангах тухай хууль**⁴⁸ (2545-VIII Law of Ukraine on ensuring transparency in extractive industries 2018)

<p>Нийт 4 хэсэгтэй, 16 зүйл заалттай.</p> <p>Хэсэг I. Ерөнхий нөхцөл</p> <ol style="list-style-type: none">1. Нэр томъёоны тодорхойлолт2. Хамрах хүрээ <p>Хэсэг II. Тайлагнах, мэдээлэх үүрэг хариуцлага</p> <ol style="list-style-type: none">3. Зорилго ба мэдээллийг ил тод болгох4. Тайлагнах үүрэгтэй этгээд5. Тайлагнах мэдээллийн аргачлал6. ЗГ-т төлсөн төлбөрийн тайлан7. Хүлээн авсан төлбөрийн тайлан8. ОУИТБС-ын Олон талт бүлгийг бий болгох шаардлага9. ЗГ-т төлсөн төлбөрийн нэгтгэлийн тайлан10. ОУИТБС-ын тайлан11. Газрын хэвлий ашиглалтын тусгай зөвшөөрөл, гэрээний гол нөхцөлийн талаарх мэдээлэл12. Тайлагнах хугацаа ба журам13. Мэдээллийн үнэ төлбөргүй хүргээмж <p>Хэсэг III. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p> <ol style="list-style-type: none">14. Олборлох салбарын компани, толгой компанид хууль тогтоомж зөрчсөнд хүлээлгэх хариуцлага15. Төлбөр төлөгчийн албан тушаалтан, эрчим хүч ба нүүрсний салбарт зориулсан нийтийн бодлого бий болгох эрх бүхий төрийн төв байгууллага, геологийн судалгаа, газрын гүний нөөц ашиглах талаарх бодлого боловсруулж мөрдүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад хууль тогтоомж зөрчсөнд хүлээлгэх хариуцлага16. Төрийн байгууллагын шийдвэрийг давж заалдах <p>Хэсэг IV. Төгсгөлийн болон шилжилтийн нөхцөл</p>	<p>Бүтэц</p>
--	--------------

⁴⁸ <https://eiti.org/document/law-of-ukraine-2545viii-on-ensuring-transparency-in-extractive-industries-translation>

Зорилго	<p>Энэ хууль нь Украин Улсын олон улсын өмнө хүлээсэн ОУИТБС-ын үүрэг хариуцлагыг биелүүлэх, Европын холбооны олборлох салбарын компаниудын ил тод байдлыг хангах 2004/109/ЕС хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Европын парламент болон Зөвлөлийн жилийн санхүүгийн тайлан, нэгтгэлийн тайлан болон бусад тайлагналын дагуу баталгаа гаргах хэрэгжилтийг хангах, Европын парламент болон Зөвлөлийн 2006/43/, 2013/50/EU, 2004/109/ЕС, 2003/71/ЕС, 2007/14/ЕС зэрэг ил тод байдлыг хангахад чиглэгдсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, 2004/109/ЕС хуулийн дагуу дэлгэрэнгүй зохицуулалтын журмыг тодорхойлох зорилготой.</p>
Удирдлага	<p>Энэ хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ОУИТБС-ын Олон талт хамтын ажиллагааны бүлгийг байгуулж, гишүүдийг эрчим хүч, нүүрсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага томилно. Эрчим хүч, нүүрсний салбар хариуцсан сайд ОУИТБС-ыг тэргүүлнэ.</p>
Мэдээлэх мэдээлэл, аргачлал	<p>ОУИТБС-ын Олон талт хамтын ажиллагааны бүлэг (ОГХАВ) нь мэдээллийн задаргаа, мэдээлэх мөнгөн дүнгийн хязгаар зэрэг тайлагналын журмыг батална. Хэрэв тайлан, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах бол ОГХАВ нь төлөвлөгөө, журмыг баталж, дараа нь салбарын Сайд нараар батлуулсан байна.</p> <p>1. Олборлох салбарын компани болон толгой компани дараах мэдээллийг цахимаар илгээж, мөн өөрийн цахим хуудсаар ил тод болгоно:</p> <ul style="list-style-type: none"> - ЗГ-т төлсөн төлбөр, нэгтгэлийн тайлан. Үүнд: нийт төлсөн төлбөр, төлбөр тус бүрийн төрөл, хамаарал, түрээс, газар, ус, байгаль орчин зэрэг ашиглалтын төлбөрүүдийг төсөл тус бүрээр, татвар, төлбөр төлсөн мөнгөн тэмдэгт, тайланд хамаарах хугацаа, төлбөртэй холбоотой үйл ажиллагааны тайлбар, шууд болон шууд бус гүйцэтгэсэн ажил, үйлдвэрлэлийн холбогдох мэдээллүүд, төсөл тус бүр дээр ажил гүйцэтгэсэн ажилтны тоон мэдээлэл, төрөөс хүлээн авсан тусламж, дэмжлэг тэдгээрийн тайлбар, компанийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, аудитын тайлан; - Гэрээний үндсэн болон гол нөхцөлүүд, холбогдох мэдээлэл <p>2. Төлбөр хүлээн авагч:</p> <ul style="list-style-type: none"> - ЗГ хүлээн авсан төлбөр, нэгтгэлийн тайлан; - Холбогдох дүн шинжилгээ, тооцоолол, судалгаа; - Тусгай зөвшөөрөл хүссэн талаарх мэдээлэл;

- Сонгон шалгаруулалтын мэдээлэл;
 - Тусгай зөвшөөрлөл худалдсан мэдээлэл;
 - Байгуулсан гэрээ, холбогдох хавсралт, гэрээг ажлын төлөвлөгөө;
 - Компанийн гаргасан бүх мэдээллийг нэгтгэн, компани, төсөл, толгой компани тус бүрээр гаргана.
3. Гэрээний мэдээллийг ил тод болгохдоо:
- Нэр, дугаар, огноо, талуудын нэр
 - Юуны тухай, ямар ажил үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүн хамарсан талаарх тайлбар;
 - Хүчин төгөлдөр болох хугацаа, хүчинтэй байх хугацаа;
 - Талуудын эрх ба үүрэг, хариуцлага;
 - Аливаа баталгаа;
 - Төлбөр хүлээн авахад тавигдах нөхцөл, онцгой нөхцөл;
 - Ажлын онцлог нөхцөл, үүрэг;
 - Байгаль орчин, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээлэл, тайлбар, төлөвлөгөө г.м;
 - Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх мэдээлэл;
 - Нийгмийн хариуцлага, орон нутгийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцох байдлын мэдээлэл, орон нутгийн байгууллага, хувь хүнтэй холбоотой хийгдсэн ажил, ажлын байр бий болгосон, бараа, үйлчилгээ, ханган нийлүүлэлт, худалдан авалт зэрэг мэдээлэл;
 - Хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангасан талаарх мэдээлэл.
4. Бусад
- Хамтарсан төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг журмын дагуу тайлагнана;
 - Хэрэв бэлэн бус, мөнгөн бус хэлбэрээр төлбөрийг төлсөн бол зах зээлийн ханшаар тооцож мөнгөөр давхар илэрхийлнэ.

<p>Мэдээлэх этгээд</p>	<p>Энэ хууль нь эрх зүйн хэлбэр, өмчлөлийн төрлөөс үл хамааран олборлох салбарын бүх компани болон тэдгээрийн толгой компани, эрчим хүч ба нүүрсний салбарт зориулсан нийтийн бодлого бий болгох эрх бүхий төрийн төв байгууллага, геологийн судалгаа, газрын гүний нөөц ашиглах талаарх бодлого боловсруулж мөрдүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага болон төлбөр төлөгчид хамаарна.</p> <ul style="list-style-type: none"> - Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компани; - Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компанийн толгой компани; - Төлбөр төлөгч; - Эрчим хүч ба нүүрсний салбарын зохицуулалтыг бий болгох үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага; - Геологийн салбар, үндэсний газрын гүний нөөцийн асуудлаарх зохицуулалтыг бий болгох үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага.
<p>Мэдээллийг баталгаажуулах, хариуцлага</p>	<p>Төлбөрийн талаарх нэгтгэлийн тайланг компани нь төлбөр төлснөөс хойш дараагийн жилийн 9 дүгээр сарын 1-ний дотор гаргана. Тайланг 3 жилээс багагүй хугацаанд нээлттэй байлгана. Төр нь нэгтгэлийн тайланг компаниас хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор олон нийтэд ил тод тайлагнана. Мөн тайланг ОУИТБС-ын цахим хуудсанд нийтэд мэдээлнэ.</p> <p>Компанид аливаа зөрчлийг арилгах ажлын 10 хоногийн сануулга өгнө.</p> <p>Торгуулийг тухайн компани болон толгой компанид ногдуулах бөгөөд зөрчил үүссэнийг мэдсэнээс хойш 6 сарын дотор, зөрчлийг бий болгосон өдрөөс 1 жилийн дотор ногдуулна. Торгуулийн хэмжээг Олон талт хамтын ажиллагааны зөвлөл тогтооно.</p>

7.5.3. ДҮГНЭЛТ

Хуулийн зорилго:

- Ил тод байдлыг хангах тухай хуулийг авлига, хээл хахууль, мөнгө угаах зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, тухайн улсын болон гадаад улсын төрийн албан хаагчид авлига, хээл хахууль өгөхөөс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл, зорилготойгоор боловсруулжээ.
- Хууль тогтоомж нь авлигатай тэмцэх болон гэмт хэрэгтэй тэмцэх бусад хууль тогтоомжтой уялдахаар зохицуулсан байна.

Хууль тогтоомжийн шаардлага, хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд:

- Канад болон Украин улсууд эрдэс баялгийн салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах, харин ЕХ нь нийт хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах бие даасан хууль баталсан.
- Хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий, бие даасан, хараат бус этгээдийг шинээр бий болгосон бөгөөд зөвлөл, хороо, бүлэг зэрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.
- Салбарын сайд нь тухайн зөвлөл, бүлгийн даргаар томилогдож, гишүүдийг томилсон байна.

Тайлагнах, мэдээлэх этгээд:

- а/ уул уурхай, газрын тос, хийн хайгуул эсхүл олборлолт эрхлэх компани
- б/ тэдгээрийн толгой, холбоотой компани
- в/ төрийн холбогдох байгууллага аль аль нь мэдээллээ ижил байдлаар тайлагнаж байна.

Ил тод болгох мэдээлэл:

- Мэдээллийн хувьд а/ тогтмол мэдээлэх болон б/ тодорхой хугацаанд мэдээлэх гэсэн хоёр төрлийн мэдээлэл байна.

- Мөнгөн дүн эсхүл бусад хэлбэрээр төлсөн төлбөр, ажил, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүний мэдээллийг аль алиныг мэдээлнэ.
- Тодорхой хугацаанд мэдээлэх мэдээлэлд хөндлөнгийн этгээдээр хянуулах тайлан, санхүүгийн мэдээллүүд, тусгай зөвшөөрөл, бусад холбогдох мэдээлэл, нийгэм, эдийн засгийн төлөв байдал, байгаль орчны холбогдох мэдээлэл зэрэг багтаж байна.
- Тогтмол мэдээлэх мэдээлэлд өмчлөл, эзэмшил, эцсийн өмчлөгч, гэрээ, үйлдвэрлэл, орон нутгийн шилжүүлэгтэй холбоотой мэдээлэл зэргийг ил тод болгож, мэдээлэхээр байна.

Ил тод болгох хэлбэр:

- Мэдээллийг тухайн мэдээлэл гаргах байгууллагын цахим хуудас, зөвлөл, хороо, бүлэг зэрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн нэгжийн цахим хуудас болон төрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулж мэдээлэхээр заасан.

Баталгаажуулалт, хариуцлага:

- Мэдээллийг зөвлөл, хороо, бүлэг зэрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн эрх бүхий нэгж хүлээн авч, хянах, баталгаажуулах, зөрүүг илрүүлэх, тодруулах, залруулга хийх эрх олгох эсхүл хариуцлага тооцох нийтлэг зарчмыг тодорхойлжээ.
- Хариуцлагын хэлбэр нь ихэвчлэн торгууль ногдуулахаар байгаа бөгөөд эхний ээлжид зөрчийг арилгах сануулгыг хугацаатай өгч байна. Түүний дараа зөрчил тус бүрт, хуулийн этгээд тус бүрт, харилцан хамааралтай эсхүл олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг эсэхээс үл хамаарч торгууль ногдуулсан байна. Торгуулийн хэмжээ харилцан адилгүй байх бөгөөд Канадын жишээгээр ахуйн нэгж үйлдэл тус бүрт \$250,000 хүртэл торгууль төлөхөөр байна.
- Компанийн гаргаж өгөх мэдээллийг гүйцэтгэх удирдлага болон албан тушаалтан эсхүл хараат бус аудитор, нягтлан

бодогч үнэн, зөв гэдгийг баталгаажуулж хүргүүлэхээр заасан нь тухайн мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага хянаж баталгаажуулсны дараа буруу болох нь тогтоогдвол баталгаа гаргагчид тухайн хууль эсхүл бусад хуульд зааснаар хариуцлага ногдуулах үндэслэл болохоор томъёолсон байна.

Бусад:

- Зөвлөл, хороо, бүлэг зэрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн нэгж нь тусгай зохицуулалт, аргачлал, журам зэрэг бусад асуудлын нарийвчилсан зохицуулалтыг боловсруулж, хэрэгжилтийг хангах эрхтэй.

Дэлхийн улс орнуудын эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт нь кодекс буюу суурь хуулийн шинж чанартай байгаа нь ажиглагдав. Суурь хуульд ашигт малтмал, гүн боловсруулалт, газрын тос, хий болон газар, ус зэрэг байгалийн баялгийн хайгуул, ашиглалтын цогц мэдээлэл, энэ салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн зөвшөөрөл, өмчлөгч, эцсийн эзэмшигч, төр болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хэлцэл, орлого, татвар төлөлт, орон нутгийн харилцаа, хамтын ажиллагаа болон орон нутгийн ажил үйлчилгээ, хандив, нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөлөөлөл тусгагджээ. Түүнчлэн мэдээлэх болон мэдээллийг хянах этгээдийн үүрэг, хариуцлага зэрэг маш нарийн чиг үүргийн зохицуулалт, харилцан уялдааг хангах, аливаа төлөвлөлтийн шийдвэрт сонирхол нь хөндөгдөж буй бүх талын оролцогчдын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг хуульд тусгасан байв.

Цаашлаад холбогдох хуулиудын уялдаа, агуулгыг зэрэгцүүлэн нийцүүлэх асуудлыг шат дараатай авч хэрэгжүүлэх чухал алхмуудыг хууль эрхзүйн хамрах хүрээнд хийсэн байв. Иймд, эдгээр нөхцөлийг тодорхойлсон бие даасан хууль тогтоомж чухал шаардлагатай гэж үзэхээр байна.

7.5.4. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулиар ОУИТБС-ын дагуу ил тод болгох мэдээлэл, баримтлах зарчим

#	ОУИТБС-ын стандарт	Хариуцах байгууллага	Ил тод болгох мэдээлэл
1		Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Вэб хуудсанд олборлох салбарыг зохицуулж байгаа эрх зүйн хүрээ, мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам болон холбогдох төрийн байгууллагуудын хариуцаж буй чиг үүргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулж, өөрчлөлт орох бүрд бүр шинэчилж байх
2		Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Олборлох салбарт бодлогын шинэчлэл хийж буй бол энэ тухай мэдээлэх
3		Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөөц боломж, тагвар, хураамж, төлбөр, үйлдвэрлэл, төсөл, хөгөлбөрийн талаар мэдээлэх
4	2.1 Эрх зүйн орчин болон санхүүгийн горим	Сангийн яам	Вэб хуудас болон төсвийн порталгаар дамжуулан төсвийн бодлого, төсвийн хуваарилалтын түвшин, орон нутгийн шилжүүлэгтэй (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжин эсвэл шууд аймгууд руу шилждэг) хамаарах мэдээлэл
5		Сангийн яам	Шилэн дансны вэб хуудсанд төсөв болон гүйцэтгэл, төрийн байгууллага, ТӨК хоорондын шилжүүлгийн тухай мэдээлэл, төсвийн зарцуулалтын мэдээллийг нийтэлж байх
6		Татварын ерөнхий газар	Вэб хуудсандаа татварын хувь хэмжээ, орон нутагт заавал хийгдэж буй төлбөрийн эрх зүйн орчны талаар дэлгэрэнгүй мэдээлж байх
7		Ашигт малтмал, газрын тосны газар	Газрын тос, хий болон ашигт малтмалын хайгуул ба олборлолтой холбоотой гэрээ ба лицензийн төрлийн талаарх тайлбар, тусгай зөвшөөрөл олгох ба шилжүүлэх ажиллагааны тайлбарыг гаргаж мэдээлэх

8	Ашигт малтмал, газрын тосны газар	Уул уурхайн олон нийтийн боловсролын төвийн, (http://edu.mgram.gov.mn) вэб хуудсаар дамжуулан салбарын зохицуулалтын талаар, Хөрөнгө оруулалтын хөгөч вэб хуудсаар (http://invest.mgram.gov.mn) зохицуулалтын орчинд гарч буй шинэчлэлийн тухай мэдээлэх
9	Ашигт малтмал, газрын тосны газар	Вэб хуудсаараа ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын болон хий, газрын тосны тусгай зөвшөөрөл олгох, БХГ байгуулах журам, түүний техникийн болон санхүүгийн шалгуурын тухай, мөн тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явцын тухай иж бүрэн мэдээлэл өгөх
10	Ашигт малтмал, газрын тосны газар	Вэб хуудсандаа сонгон шалгаруулалтад ороод шалгарч чадаагүй талуудын жагсаалт болон сонгон шалгаруулалтад авсан оноо зэргийг тухай бүр мэдээлэх
11	Ашигт малтмал, газрын тосны газар	Шинээр олгосон, цуцалсан болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг сар бүр мэдээлэх
12	Ашигт малтмал, газрын тосны газар	Кадастрын системийг улам боловсронгуй болгож тусгай зөвшөөрөл тус бүрийг олгосон үйл явцыг нээлттэй харуулах боломжийг бүрдүүлэх
13	Ашигт малтмал, газрын тосны газар	Кадастрын системээ улам боловсронгуй болгож, бүх төрлийн ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй талбайн тухай дараах мэдээллүүдийг нээлттэй мэдээлж байх, төрийн байгууллага хооронд ХҮР системээр дамжуулан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон БХГ бүхий аж ахуйн нэгжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл - Талбайн солбилцол - Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, дуусах огноо - Талбайн хэмжээ

14	Ажлын алба	Кадастрын системд шинэчлэл хийгдэх хүртэл ОУИТБС-ын Дата порталд тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог түр хугацаанд оруулах
15	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Гэрээний ил тод байдлын чиглэлээр баримтлах бодлогыг албажуулан батлах. Вэб хуудсандаа гэрээний ил тод байдал гэсэн хэсэг нэмж оруулан үүнд гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлоготой холбоотой баримт бичгүүд, үйл ажиллагааны мэдээлэл зэргийг оруулах шаардлагагай. Үүнд: - Холбогдох хууль тогтоомжийн заалт - Ил тод болгож буй практик
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	www.iltodgeree.mn порталд байгуулагдсан бүх гэрээг оруулах. Үүнд: - Аливаа гэрээг бүрэн эхээр нь - Хавсралт, нэмэлт өөрчлөлт, нөхцөлийн бүрэн мэдээлэл - Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт эх хувь - Газрын тосны бүтээгдэхүүн хуваах төлөвлөгөө - АМТЗ түрээсэлсэн, барьцаанд тавьсантай холбоотой гэрээ, мэдээлэл - Хэрэглэгч ашиглах, дүн шинжилгээ хийхэд хялбар байдлаар
17	Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Тухайн орон нутагтаа байгуулсан гэрээг www.iltodgeree.mn порталд оруулах
18	2.5 Эцсийн өмчлөгч	Аж ахуйн нэгжүүдийн эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээллийг цахимаар цуглуулж сан үүсгэх, Ашигт малтмал газрын тосны газар, Татварын ерөнхий газартай мэдээлэл харилцан солилцож, шинэчилж, эдгээр байгууллага мэдээллийг харилцан баталгаажуулж байх. Улсын бүртгэлийн ерөнхий газар нийтэд ил тод мэдээлэх системийг бий болгох. Үүнд: - Ашиг хүртэгч хувь хүний нэр

19	Ашигт малтмал, газрын тосны газар	<ul style="list-style-type: none"> - Үндэс угсаа - Оршин суух улс - Улс төрд нөлөө бүхий эгтгээд мөн эсэх - Олон талт ажлын хэсгээс зөвшилцөн багалсан бусад мэдээлэл <p>Эцсийн өмчлөгчдийн мэдээлэл, өмчлөлийн түвшин, удирдлага, эрх мэдэл хэрэгжүүлэх хэлбэр зэргийг ил болгоход гарч буй бэрхшээлийг талаарх мэдээлэл</p>
20	Үндэсний аудитын газар	Вэб хуудсандаа бүх төрийн өмчит аж ахуйн нэгжийн аудитаар багалажсан санхүүгийн тайланг олон нийтэд нийтэлж байх
21	Төрийн өмчит компаниуд	Вэб хуудсандаа аудитаар багалаажсан болон Татварын албанд хүргүүлсэн санхүүгийн тайлан, дүгнэлтийг ил тод болгон мэдээлэх
22	Төрийн өмчит компаниуд	ТӨК, ТӨҮГ-ын төрийн өмчийн оролцоо, оролцооны түвшнийг давхаргаар гаргасан байхыг шаардах, хувь эзэмшилд дагалдах аливаа эрх хэмжээг гаргах
23	Төрийн өмчит компаниуд	Ханган нийлүүлэлт, засаглал, үйл ажиллагааны зардал, ТУЗ, ТУЗ-ын үүрэг, ёс зүйн дүрэм журмыг ил болгох
24	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Вэб хуудсаараа ТӨК, ТӨҮГ-ын үүрэг хариуцлага, журам, төрийн өмчтэй холбоотой бүх хууль тогтоомжийг байрлуулах, өөрчлөгдсөн тухай бүрд нь шинэчлэх. Үүнд хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт, гуравдагч талын санхүүжилт, зээл зэрэгт хамаарах заавал даган мөрдөх бүхий л дүрэм журмыг хамруулах
25	Сангийн яам	Олборлох салбарт ажиллаж буй төрийн өмчит компаниудтай холбоотой зээл, зээлийн баталгааны тухайн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлж байх
26	Сангийн яам	Төрийн өмчит компани болон засгийн газрын санхүүгийн харилцааны талаар мэдээлж байх

27	3.1 Хайгуул	Ашигт малтмал, газрын тосны газар	МонGeoKaг (http://mgram.gov.mn/mgram/webgis/) системээр дамжуулан ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын геологи, хайгуулын мэдээлэл; хөрөнгө оруулалтын хөтөч вэб хуудсаар хайгуулын тухай мэдээ, мөн хагас жил тутамд ашигт малтмалын нөөцийн мэдээллийн тайланг вэб хуудсаар дамжуулан ил тодоор нийтэлж байх.
28	3.2 Үйлдвэрлэл	Ашигт малтмал, газрын тосны газар	Вэб хуудсандаа үйлдвэрлэлийн хэмжээ болон дундаж үнийн талаарх хагас жил, жилийн статистикийг, нийт борлуулалт зэргийг сараар нь задлан харуулах, энэ мэдээллийг хэрэгжиж буй уул уурхайн төсөл тус бүрээр задлан харах боломжийг бүрдүүлэх
29		Үндэсний статистикийн хороо	Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг тогтмол мэдээлэх
30		Ашигт малтмал, газрын тосны газар	Хөрөнгө оруулалтын хөтөч вэб хуудсаараа жил тутмын үйлдвэрлэлийн мэдээлэл түгээх
31	3.3 Экспорт	Монгол Банк	Вэб хуудсандаа сар тутмын экспортын биет хэмжээ болон бүтээгдэхүүн нэг бүрийн үнэ, цаашдын төлвийг мэдээлэх
32		Гаалийн ерөнхий газар	Вэб хуудсаар сар тутмын экспортын хэмжээ, үнэ болон экспортолж буй улс зэргийг тухай бүр мэдээлж байх
33		Үндэсний статистикийн хороо	Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний экспортын мэдээллийг тухай бүр мэдээлэх

34		Компаниуд	Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ, төлсөн татвар, төлбөр, хураамж, урамшуулал, ногдол ашиг, шимтгэл, торгууль, хандив дэмжлэг, нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг багтагдсан маягтын дагуу тайлагнах, энэхүү тайландаа удирдлагын зүгээс тухайн мэдээллийг баталгаажуулсан мэдэгдлийг энгийн цахим гарын үсэгтэйгээр ирүүлж байх, цаашид жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитдаа ОУИТБС-ын тайланг хамруулж байх
35	4.1 Татвар, орлогыг иж бүрнээр ил тод болгох/ 4.9 Мэдээллийн чанар, баталгаажуулалт	Төрийн байгууллагууд болон Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Олборлох салбарт ажиллаж буй компаниудаас хүлээн авсан орлогоо жил бүрийн 6 дугаар сард багтаан тайлагнаж, энэхүү тайлан нь үнэн зөв, иж бүрэн болохыг удирдах албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байх
36		Хараат бус нэгтгэгч	Төлбөр болон орлогын анхдагч нэгтгэн тулгалтыг хийж, зөрүүг тохируулан эцсийн нэгтгэлийг гаргах
37		Ажлын алба	Татварын ерөнхий газартай сар тутам автоматаар мэдээлэл солилцох боломжийг ОУИТБС-ын цахим тайлагналын системд хийх
38		Үндэсний аудитын газар	Засгийн газрын зүгээс гаргаж буй хүлээн авсан орлогын мэдээлэлд баталгаажуулалт гаргах
39		Олон талт ажлын хэсэг	Монгол Улс нь ОУИТБС-ын тайланд нэгтгэл хийхдээ баримталж буй материаллаг босгын талаарх өмнө гаргасан шийдвэрээ эргэн харж, нэгтгэлд хамрагдаж буй төлбөрүүдийн тоог бууруулахын зэрэгцээ жил тутмын ОУИТБС-ын нэгтгэлийн иж бүрэн, найдвартай байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх

40	4.2 Мөнгөн бус орлого	Төрийн өмчит болон бусад Компаниуд	<p>Мөнгөн бус орлого байхгүй гэдэг нь баталгаажуулалтаар нотлогдсон (2016, 2018) хэдий ч своп гэрээ, нөөцөөр баталгаажсан зээл, томоохон зөрүү, худалдах, худалдан авах гэрээ, техникийн болон санхүүгийн шалгуурыг нийтэд ил тод болгох, гэрээ хэлцлээр бүтээгдэхүүн худалдан авагч компанийн хүлээн авсан хэмжээ, төлсөн дүнг мөнгөн ба бусад хэлбэрээр, гэрээний хамт ил тод болгох</p>
41	4.3 Дэд бүтэц болон баргерын солилцоо	Төрийн өмчит болон бусад Компаниуд	<p>Одоогоор Монгол Улсад хамааралгүй болох нь баталгаажуулалтаар нотлогдсон (2016, 2018) хэдий ч бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцоогоор ханган нийлүүлэх /зээл, тусламж олгох, дэд бүтэц барих гэх мэт/ үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр, ашигт малтмалыг дэд бүтцээр солих/байгуулах төрлийн гэрээ зэргийг бусад төрлийн гэрээний нэгэн адил ил тод болгож, тухайн гэрээний талууд, Монгол Улсын зүгээс санал болгосон нөөц эх үүсвэр, үр шимийн үнэ цэнэ (жишээ нь дэд бүтцийн ажил), тухайн гэрээний материаллаг байдал зэргийг нийтэд ил болгох арга хэмжээг авах шаардлагатай.</p>
42	4.4 Тээвэрлэлтийн орлого	Улаанбаатар төмөр зам ХНН	<p>Ашигт малтмалын бүтээгдэхүүн тээвэрлэснээс олсон орлогоо маягтын дагуу тайлагнах</p>
43		Төрийн өмчит болон бусад Компаниуд	<p>Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэсний улмаас олсон орлого, мэдээлэл. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> i. тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл: тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани, төрийн байгууллага (ТӨ); ii. тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар; iii. тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ; iv. газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлого;

			Боломжтой бол Олон талт оролцогчдын бүлэг нь Хараат бус аудиторт газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлийн төлбөр, үүнд хамаарах материаллаг болон мөнгөн бус төлбөр зэргийг нэгтгэлд хамруулж байх үүрэг ноогдуулах талаарх мэдээллийг ил тод болгох
44	4.5 ТӨК-ийдтай холбоотой шилжүүлгүүд	Олон талт ажлын хэсэг	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд зориулсан тусдаа маягт бий болгож цахим тайлагналын системд оруулах, үүнд хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт зэрэг мэдээллийг тусгах
45	4.6 Орон нутгийн төлбөр	Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудаас хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, урамшуулал болон хандив дэмжлэгийн мэдээллээ Цахим тайлагналын системээр жил бүр тогтоосон хугацаанд багтаан мэдээлэх
46		Сангийн яам	Шилэн дансны вэб хуудсаар төсвийн орлого, зарлагын талаар мэдээлж байх
47	5.1 Олборлох салбарын орлогын хуваарилалт	Сангийн яам	Төсвийн гүйцэтгэлийн (http://www.iltod.gov.mn) болон орон нутгийн шилжүүлгийн (http://tusuv-oronnutag.mof.gov.mn/) сайтуудаар, төсвийн орлого түүний хуваарилалтыг мэдээлэх
48		Сангийн яам	Дээрх мэдээллүүдийг харилцан уялдуулах чиглэлд ажиллахаас гадна төсвийн бус хэлбэрээр удирдаж буй олборлох салбарын орлогыг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авах нь зүйтэй.
49	5.2 Орон нутгийн шилжүүлэг	Сангийн яам	Олборлох салбарын орлогоос орон нутаг аймгуудад шилжүүлэх тооцоололд ашигладаг томъёо болон хувьсагчуудыг ил тод болгох, орон нутагт хийгдэх төлбөрийн тооцооллын тухай мэдээллийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн вэб хуудсаар дамжуулан түгээж буй төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд нэгтгэн уялдуулах
50	5.3 Орлогын удирдлага болон зарцуулалт	Үндэсний аудитын газар	Олборлох салбараас олсон орлогыг төвлөрүүлж буй сангуудын орлого, зардал, үйл ажиллагааны тухай мэдээллийг ил тод болгон мэдээлэх Сангуудын үйл ажиллагаанд УАГ-аас хийсэн шалгалтын тайланг мэдээлэх

51	6.1 Нийгмийн зарцуулалтууд	Олон талт ажлын хэсэг	ОУИТБС-ын тайлангийн маягтын сайн дурын хандив дэмжлэг, төрийн байгууллагад өгсөн хандив дэмжлэгийн мэдээлэл авах маягтыг боловсронгуй болгож, шаардлагатай мэдээллийг бүрэн авах. Нийгмийн зарцуулалтыг хууль, эсвэл гэрээний дагуу гүйцэтгэж буй бол заавал тайлагнах, гэрээний талаар мэдээлэл оруулах
52	6.2 Төсвийн шинжтэй зарцуулалт	Төрийн өмчит компаниуд	Төсвийн шинжтэй зарцуулалтаа багтагдсан маягтын дагуу тайлагнах, энэхүү үйл явцад төрийн өмчит компаниудын хамаарал бүхий компаниудыг мөн хамруулах
53	6.3 Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	Ашигт малтмал, газрын тосны газар	Хөрөнгө оруулалтын хөтөч вэб хуудсанд уул уурхайн салбарын зүгээс ДНБ-д оруулж буй хувь нэмрийг харьцангуй болон абсолют тоон мэдээллээр мөн Засгийн газрын орлого, экспортын мэдээллийг нийтлэх
54		Үндэсний статистикийн хороо	Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг хүйс, байршил, ажил мэргэжлээр задлан нийтлэх
55	Бусад	Ажлын алба	Цахим хуудсандаа ил тод болж буй Стандартаар шаардсан мэдээллүүдийн холбоосыг нэгдсэн байдлаар нийтлэх
56		Ажлын алба	Холбогдох байгууллага, субъектүүдэд, төр засгийн өөрчлөлт тус бүрийн үед ОУИТБС-ын тухай ойлголт танин мэдэхүйн сургалт явуулдаг байх

7.6. ОУИТБС-ЫН СТАНДАРТЫН ШААРДЛАГА ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ (2014 ОН) БОЛОН УУЛ УУРХАЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ (2017 ОН)-Д ТУСГАГДСАН БАЙДАЛ

ОУИТБС-ын стандарт	2014 оны ЭБСИТБТХ-ийн төсөл	2017 оны УУТХ-ийн төсөл
<p>Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн зүгээс тавих хяналт. ОУИТБС нь Засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн бие даасан, харааг бус, идэвхтэй, үр дүнтэй оролцоог хангасан, олон талт оролцогчдын бүлгийг ажиллуулахыг шаарддаг. Олон талт оролцогчдын бүлэг (ОТОб)-ийн зүгээс тавих хяналттай холбоотой гол шаардлагад:</p> <p>(1.1) Засгийн газрын үүрэг амлалт: ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээ олон нийтэд мэдэгдэх, удирдан хэрэгжүүлэх өндөр албан тушаалтныг томилох, ажлын уялдааг хангах болон санхүүгийн эх үүсвэрийг дайчлах эрх хэмжээтэй байх, ОТОб-т төрийн өндөр албан тушаалтнуудыг оруулсан байх</p>	<p>6.7.1-д төрийн байгууллагын төлөөллийн 8 гишүүнтэй Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөлтэй байх. 15 дугаар зүйл. Зөвлөлийн төсвийг Ерөнхий сайдын багцад тусган төсвөөс санхүүжүүлэх, Ажлын албатай байх, анхан шатны тайлан гаргах үүрэггүй хуулийн этгээд, иргэнээс хандив, тусламж авч болох Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>69.5.1. төрийн байгууллагын төлөөлөл орсон байх Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(1.2) Компаниудын оролцоо: ОУИТБС-т бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцох, ОТОб-д багтсан байх, ЗГ нь оролцоо, хэрэгжилтийг хангах мөн оролцоог хязгаарлахгүй байх холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг бий болгох</p>	<p>6.7.2-т тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллийн 9 гишүүнтэй Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөлтэй байх Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>69.5.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл орсон байх Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>(1.3) Иргэний нийгмийн оролцоо: ОУИТБС-д бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцох, ОТОБ-т багтсан байх, ЗГ нь оролцоо, хэрэгжилтийг хангах мөн оролцоог хязгаарлахгүй байх холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг бий болгох, ОУИТБС-ын бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй, үр нөлөөтэй оролцох, өөр хоорондоо хамтрах</p>	<p>6.7.3-т иргэний нийгмийн эвслийн 9 гишүүнтэй Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөлтэй байх</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>69.5.1. иргэний нийгмийн эвслийн төлөөлөл орсон байх</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(1.4) Олон талт оролцогчдын бүлэг (ОТОБ)-ийг байгуулах, үйл ажиллагаа явуулах: ЗГ-аас ЗГ-иргэний нийгэм (ялангуяа хараат бус), -компаниуд багтсан ОТОБ-ийг ОУИТБС-ын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор байгуулах, урилгыг нээлттэй байлгах, албадлагаар ОТОБ-т гишүүн оруулахгүй байх, тооны харьцаа ижил байх шаардлагагүй, оролцогч талын бүлэг өөрийн төлөөллийг сонгох, үйл ажиллагаа, бодлогыг төрөөс хараат бус байлгах, ОТОБ-ийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгох, үйл ажиллагааг нээлттэй, хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн олон нийтийн ажил зохион байгуулах, ОТОБ-т төлөөлөн сонгогдсон бүлэгтэйгээ нягт хамтран ажиллах.</p>	<p>6 ба 7 дугаар зүйл. Хараат бус Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөл байгуулах, зөвлөлийн шийдвэр гаргах, ЭБИТБТХ-ийн хэрэгжилтийг хянах, ил тод байдлыг сурталчлах, судалгаа хийх, ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн байгууллагад санал хүргүүлэх, заавар, зөвлөмж, маяг, журам батлах</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>69.5 МУ-ын Ерөнхий сайдаар даргалуулсан Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын Үндэсний зөвлөлтэй байх, 69.6. Ажлын албатай байх, 69.7. жил бүр тайлан гарган УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-т хүргүүлэх, ил тод мэдээлэх, 62.8. шийдвэр гаргаж тайлангийн мэдээллийг өргөжүүлэх</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>ОУИТБС-ын жилийн тайлангийн явцыг хянах, Баталгаажуулахад оролцох, харааг бус хянан нэгтгэчийг сонгох, ажлын хүрээг тодорхойлох, ОУИТБС-ын тайлан, төлөвлөгөөг хэлэлцэн батлах. Дотоод засаглалын дүрэм журам багалсан байх.</p>	<p>(1.5) ОУИТБС-ыг хэрэгжүүлэх тодорхой зорилго бүхий хэлэлцэн зөвшөөрсөн ажлын төлөвлөгөө болон ОУИТБС-ын Удирдах хорооноос тогтоосон хугацаатай нийцсэн ажлын хуваарь: ОУИТБС-ын тайлангийн цар хүрээг өргөжүүлэхэд чиглэгдсэн ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хугацааг ажлын жил тутмын төлөвлөгөөтэй байх.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>Шаардлага 2. Гэрээ байгуулах, лиценз олгох зэрэг эрх зүйн болон институцын хамрах хүрээ. ОУИТБС нь олборлох салбарыг хэрхэн удирдан зохицуулж байгааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгахыг шаардана. Улмаар хайгуулын болон үйлдвэрлэлийн эрх олгох, гэрээнд хамаарах асуудал зэрэг олборлох салбарт хамаарах хууль эрх зүй, зохицуулалт болон Засгийн газрын байгууллагын үүрэг хариуцлагатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг ойлгоход дэмжлэг үзүүлэхийг шаарддаг. Ил тод эрх зүйн хамрах хүрээ болон олборлох үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой</p>	<p>(2.1) Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого: Хууль тогтоомж болон төсвийн холбогдох бодлогын тайлбарыг ил болгох, төсвийн хуваарилалт, газрын тос, хий болон ашигт малтмалын хайгуул ба олборлолттой холбоотой гэрээ ба лицензийн төрлийн талаарх тайлбар, холбогдох төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийг ил тод болгох, төрөөс хэрэгжүүлсэн ажлыг баримтжуулах</p>	<p>3.2-т зааснаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тос, хий болон ашигт малтмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, олборлолт, хайгуул хийх эрх бүхий этгээд, эрх авсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэлж байгаа нөхөрлөл анхан шагны тайлан гаргана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>3.1-т зааснаар газрын хэвлийгээс ус, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох, баяжуулах, боловсруулах уурхайн, уулын үйлдвэр эрхлэгч анхан шагны тайлан гаргана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>(2.2) Гэрээ болон лиценз олголт: Газрын тос, хий болон ашигт малтмалын гэрээ, лиценз олгосон болон шилжүүлсэн талаарх бүх мэдээллийг мөнгөн дүнгээр хязгаарлахгүй ил тод болгох, лиценз олгох ба шилжүүлэх ажиллагааны тайлбар, техникийн ба санхүүгийн шалгуур, ААН-ийн мэдээлэл, материаллаг нөхцөл, сонгон шалгаруулалт хийгдсэн бол оролцогчдын жагсаалт, шалгуурыг ил тод мэдээлсэн байх шаардлагатай.</p> <p>Гэрээ, лицензийг шинэчилсэн, түтгэлзүүлсэн, хүчингүй болгосон талаарх мэдээллийг ил болгож болно.</p>	<p>12.6.3. Төрийн байгууллагын анхан шатны тайланд олгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг; 12.6.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс тэдгээртэй байгуулсан гэрээний талаарх мэдээлэл гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>Төрийн байгууллагын анхан шатны тайланд: 62.6.3. олгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл гаргана. 62.6.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс тэдгээртэй байгуулсан гэрээний талаарх мэдээлэл гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(2.3) Лицензийн бүртгэл: Газрын тос, хий, ашигт малтмалын кадастрын системийг ил тод болгох. Үүнд лиценз эзэмшигч, тусгай зөвшөөрөл бүхий газар нутгийн координат, хүчин төгөлдөр хугацаа, олгосон огнооны мэдээллийг төлбөргүйгээр ил тод болгох. Үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол боловсруулах, боловсруулсан түүхий эдийн талаарх мэдээллийг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргана.</p>	<p>11.5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл гаргах.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.3. Хуулийн этгээд нь анхан шагны тайланд ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>(2.4) Гэрээ: 2021 оны 1-р сарын 1-нээс хойш байгуулагдсан газрын тос, хий, ашигт малтмалын болон концесс, бүтээгдэхүүн хуваах аливаа гэрээг бүхлээр нь, гэрээний хавсралт, нэмэлт өөрчлөлт болон газрын тос, хий, ашигт малтмалын лиценз, түрээсэлсэн, эрх олгосон, зөвшөөрөл олгосон бүх эрх болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг ил тод мэдээлэх үүрэгтэй. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах ТБХ төлөвлөгөө боловсруулсан байх.</p>	<p>11.5.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагатай байгуулсан гэрээний талаарх мэдээлэл гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.6. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагатай байгуулсан гэрээний талаарх мэдээлэл гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(2.5) Эцсийн өмчлөгч: Газрын тос, хий болон ашигт малтмалын олборлолт эсхүл үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээнд оролцогч ААН-ийн эцсийн өмчлөгчийн олон нийгэд нээлттэй, нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай болох, төрийн бодлого ба ил тод болгож буй байдлыг баримтжуулах, 2020 оны 1-р сарын 1-нээс ААН-д өөрсдийн эцсийн өмчлөгчдийн мэдээлэл, өмчлөлийн түвшин, удирдлага, өмчлөл, өмчлөгчийн олон нийгэд нээлттэй, нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай болох, төрийн бодлого ба ил тод болгож буй байдлыг баримтжуулах, 2020 оны 1-р сарын 1-нээс ААН-д эцсийн өмчлөгчдийнхөө гэрлийн хаяг, холбогдох утас г.м. мэдээллийг эцсийн өмчлөгчийг тодорхойлоход авсан байх, маягтыг удирдах албан тушаалтан, хуулийн зөвлөхөөр баталгаажуулах зэргээр мэдээллийг нягтлах, үнэн зөв эсэхийг баталгаажуулах, холбогдох баримтыг хавсаргах зэрэг арга хэмжээ авсан байх, мэдээллийг ил тод болгох.</p>	<p>11.5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд ҮЦЗЗтХ-ийн 4.1.29-т заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээг тусгана.</p> <p>Эцсийн өмчлөгчийн мэдээлэл гаргах, авах зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.4. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд ҮЦЗЗтХ-ийн 4.1.29-т заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээг тусгана.</p> <p>Эцсийн өмчлөгчийн мэдээлэл гаргах, авах зохицуулалт байхгүй.</p>

<p>(2.6) Олборлох салбар дахь төрийн оролцоо: ТӨК, ТӨҮГ-ын үүрэг хариуцлага, журам, төр болон ААН хоорондын гүйлгээ, хөрөнгө оруулалтыг удирдах зохицуулалтыг тодорхойлох, ТӨК, ТӨҮГ-ын тодорхойлолтыг хуульд нийцүүлэн гаргах, төрийн өмчийн оролцоо, оролцооны түвшнийг давхаргаар гаргасан байхыг шаардах, хувь эзэмшилд дагалдах аливаа эрх хэмжээг гаргах, гүйлгээ, гүйлгээний нөхцөл, үнэлгээ болон орлогын бүх мэдээллийг ил тод болгох. Хэрэв зээл, зээлийн баталгаа гаргасан бол холбоотой мэдээллийг ил болгох. Арилжааны зээлийн нөхцөлтэй харьцуулалт хийж мэдээлж болно. Аудитын тайлан эсхүл санхүүгийн үндсэн баримтыг нийтэд ил болгох ёстой. Ханган нийлүүлэлт, засаглал, үйл ажиллагааны зардал, ТУЗ, ТУЗ-ийн үүрэг, ёс зүйн дүрэм журмыг ил болгохыг дэмжих.</p>	<p>11.5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд төрийн эзэмшил дэх хувьцаа, түүнтэй адилтгах үнэг цаасны хувь хэмжээг мэдээлэх.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.2. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд төрийн эзэмшил дэх хувьцаа, түүнтэй адилтгах үнэг цаасны хувь хэмжээг тусгахаар заасан.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүний үйлдвэрлэл. ОУИТБС нь оролцогчдод тухайн салбарын боломжийн талаарх ойлголтыг өгөх үүднээс хайгуул болон бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг ил тод болгохыг шаарддаг. Хайгуулын болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааны ил тод байдалтай холбоотой ОУИТБС-ын шаардлагад дараах зүйлс орно:</p>		

<p>(3.1) Хайгуулын ажиллагааны талаарх мэдээлэл: Хэрэгжүүлэх улс нь олборлох салбарын ерөнхий мэдээлэл, томоохон олборлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох.</p>	<p>12.6.11. Төрийн байгууллагын анхан шатны тайланд эрдэс баялгийн салбараас Монгол Улсын эдийн засагт оруулж буй хувь нөмөр; 13.6.1. Нэгдсэн тайланд улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ; 13.6.2. эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>63.5.1. Нэгдсэн тайланд улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ; 63.5.2. эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(3.2) Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээлэл: Хэрэгжүүлэх улс нь үйлдвэрлэлийн мэдээлэл, хэмжээ, өртгийг түүхий эд бүрээр гаргаж мэдээлэх, мэдээллийг бүс нутаг, компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилсан мэдээллийг тухай бүр гаргаж ил тод мэдээлэх.</p>	<p>11.5.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн анхан шатны тайланд олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, борлуулалтын үнийг мэдээлнэ.</p> <p>12.6.5. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч, тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг мэдээлнэ.</p>	<p>61.4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн анхан шатны тайланд олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, борлуулалтын үнэ, орлогын хэмжээг мэдээлнэ.</p>

	<p>13.6.3. Нэгдсэн тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>62.6.5. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч, тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг мэдээлнэ</p> <p>63.5.3. Нэгдсэн тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(3.3) Экспортын мэдээлэл: Хэрэгжүүлэх улс нь экспортын хэмжээ, нийт үнийг түүхий эд тус бүрээр гаргах, мэдээллийг бүс нутаг, компани эсхүл төсөл тус бүрээр гаргах, тооцооллын эх сурвалж, аргачлал, үнэ зэргээр ангилсан мэдээллийг тухай бүр гаргаж ил тод мэдээлэх.</p>	<p>Зохицуулалт байхгүй.</p>	<p>49.1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрдэс баялгийн биржийн тухай тусгай хуулиар зохицуулж болно.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>Шаардлага 4. Орлого төвлөрөлт. Компанийн төлсөн төлбөр болон Засгийн газрын хүлээн авсан орлогын талаарх ойлголт нь олон нийтийн хэлэлцүүлэгт олборлох үйлдвэрлэлийн засаглалын тухай мэдээлэл болох учиргай. ОУИТБС нь компанийн төлсөн төлбөр болон олборлох үйлдвэрлэлээс засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхийг шаарддаг. Орлогын төвлөрөлтэй холбоотой ОУИТБС-ын шаардлагад:</p>	<p>(4.1) Татвар болон орлогыг цогцоор нь ил тод болгох: Ууул уурхай, газрын тос, хийн компанийн бүхий л томоохон төлбөрийг тогтмол,нээлтгэй байдлаар төр болон ААН-ээс авч ил тод болгон зөрүүг тодорхойлох боломжтой болгох. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> i. Засгийн газрын хувьд ногдох ашиг (жишээ нь газрын тосны ашиг); ii. үндэсний төрийн өмчит компанийн үйлдвэрлэлийн эрх; iii. ашгийн татвар; iv. нөөцийн төлбөр; v. ногдол ашиг; vi. шагнал урамшуулал, жишээ нь гарын үсгийн, хайгуулын ажлын, үйлдвэрлэлийн гэх мэт; vii. лицензийн төлбөр, түрээсийн төлбөр, лиценз болон концесстой хамаарах бусад төлбөр; viii. засгийн газрын хүртэж буй бусад томоохон хэмжээний орлого болон материаллаг үр шим. 	<p>11.5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд татвар болон татварын бус төлбөрийн талаарх мэдээллийг мэдээлнэ.</p> <p>12.6.1. Төрийн байгууллагын анхан шатны тайланд орлогын дүн, хуваарилалт, орлогын тогтвортой байдлын мэдээллийг мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.1. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд татвар болон татварын бус төлбөрийн талаарх мэдээллийг мэдээлнэ.</p> <p>62.6.1. Төрийн байгууллагын анхан шатны тайланд орлогын дүн, хуваарилалт, орлогын тогтвортой байдлын талаарх мэдээллийг мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
---	---	--	--

<p>(4.2) Үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого: Орлого их хэмжээний бол төрийн /ТӨҮГ, ТӨК/ хүлээн авсан эсхүл борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого, мөнгөн хэлбэрээр эсхүл своп гэрээ, нөөцөөр баталгаажсан зээл зэрэг бусад хэлбэрийг тодорхойлох. Борлуулалтыг худалдан авагч тус бүрээр 4.7-д заасантай нийцүүлэх, ОТОБ нь худалдан авагч ААН-тэй зөвшилцөн борлуулалт тус бүрээр, төрлөөр ба үнээр задалж ил тод болгох эсэхийг шийдвэрлэнэ. Борлуулсан бүтээгдэхүүн, холбогдох гэрээний төрөл (нөхцөл), худалдан авагчийг сонгон шалгаруулсан нөхцөлийн тайлбар, хууль тогтоомжоос зөрсөн аливаа томоохон зөрүү, худалдах, худалдан авах гэрээ, техникийн болон санхүүгийн шалгуурыг нийтэд ил тод болгох, тухайн худалдан авагч компани хүлээн авсан хэмжээ, төлсөн дүнг мөнгөн ба бусад хэлбэрээр, гэрээний хамт ил тод болгох.</p>	<p>11.5.5. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, борлуулалтын үнэ; 12.6.5. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч, тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ; 13.6.3. Нэгдсэн тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тайлагнана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.5. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, орлогын хэмжээ; 62.6.5. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч, тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ; 63.5.3. Нэгдсэн тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тайлагнана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
--	---	--

<p>(4.3) Дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бартерын солилцоо: 4.9-д заасанд нийцүүлэн газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл, концесс олгон үүний төлбөр болгон бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцоогоор ханган нийлүүлэх (зээл, тусламж олгох, дэд бүтэц барих гэх мэт) үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр байгаа эсэхийг авч үзэж хоёр талаас зэрэг ил болгох нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>11.5.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, уг хөрөнгө оруулалтын хэмжээ; 11.5.8. нөхөн сэргээлтийн зардал, түүний зарцуулалт, барьцааны талаарх мэдээлэл, хэмжээг тусгана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>62.6.7. тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалтын хэмжээ; 62.6.8. уурхай тус бүрээр нөхөн сэргээлтийн зардал, түүний зарцуулалт, барьцааны талаарх мэдээллийг тусгана. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(4.4) Тээвэрлэлтийн орлого: 4.7-д заасанд нийцүүлэн газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэсний улмаас олсон орлого, мэдээлэл нь өөр бусад орлогын урсгал, төлбөрийн нэгэн адил хэмжээнд задаргаатай байх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> v. тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл: тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани, төрийн байгууллага (ТӨ); vi. тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар; vii. тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ; 	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>

<p>viii.газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын гээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлого; ix. боломжтой бол Олон талт оролцогчдын бүлэг нь Хараат бус аудиторт газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын гээвэрлэлтийн төлбөр, үүнд хамаарах материаллаг болон мөнгөн бус төлбөр зэргийг нэгтгэлд хамруулж байх үүрэг ноогдуулах талаарх мэдээллийг ил тод болгох</p>		
<p>(4.5) Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ: Төрийн өмчит ААН-ийн үүргийг тодорхой гарган бүрэн хамруулах, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох компаниудын зүгээс төрийн өмчит ААН-д, мөн төрийн өмчит ААН нь бусад ААН-д хийсэн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж хооронд болон бусад төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй материаллаг төлбөрийг хамруулна</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>

<p>(4.6) Орон нутгийн төлбөр: 4.9-д нийцүүлэн мэдээллийн чанарыг хангах, мэдээллийг багалаажуулах зохицуулалт бий болгох, орлогын урсгалын цар хүрээнд багтаан компаниудаас орон нутгийн засаг захиргаанд төлсөн төлбөр нь материаллаг эсэхийн тогтоон ил тод болгох.</p>	<p>11.5.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тайланд төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн хандив, тусламж зэрэг тагварын бус төлбөрийн талаарх мэдээлэл, хэмжээг тусгана.</p> <p>11.6. Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь анхан шатны тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувиар гаргана.</p> <p>12.6.10. Төрийн байгууллагын анхан шатны тайланд төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүнг, 13.6.9. Нэгдсэн тайланд төрийн байгууллагаас төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүнг тайлагнана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>61.4.10. Төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн хандив, тусламж зэрэг тагварын бус төлбөрийн талаарх мэдээлэл, хэмжээг тусгана.</p> <p>61.5. Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уурхай болон уулын үйлдвэр эрхлэгч хуулийн этгээд нь анхан шатны тайланг дээрхийн адил гаргана.</p> <p>62.6.10. Төрийн байгууллагын анхан шатны тайланд төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн; 63.5.9. Нэгдсэн тайланд төрийн байгууллагаас төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүнг тайлагнана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
---	---	---

<p>(4.7) Мэдээллийг задлах түвшин: Төсөл, компани, төрийн өмчит ААН, орлого тус бүрээр мэдээллийг задлах, хэрэв төлбөрийг чөлөөлж, хөнгөлсөн бол мэдээллийг ил болгож тухайн хөнгөлөлт, чөлөөлөлтийг ААН тус бүрээр тайлагнана.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>(4.8) Мэдээллийн хамрах хугацаа: Хэрэгжүүлэгч улс нь Ажлын төлөвлөгөөний дагуу тухай бүр тайланг хэвлэн санхүүгийн 2 жилд багтаан нийтэлнэ.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>62.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 62.4-т заасан төрийн байгууллагын анхан шатны тайлангийн нэгтгэлийг хянаж баталгаажуулсны үндсэн дээр зургадугаар сарын 15-ны дотор Ажлын албанд хүргүүлнэ.</p>
<p>(4.9) Ил болгосон мэдээллийн чанар: Хэрэгжүүлэгч улс нь төлбөр ба орлогыг хөндлөнгийн аудитаар хянуулах, холбогдох мэдээлэл, тайлбарыг аудитын тайланд тусгах, мэдээллийг баталгаажуулах зохицуулалтыг бий болгосон байх.</p>	<p>11.7. Ашигт малмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан журмын дагуу эрх авсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх бүхий нөхөрлөлөөс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь анхан шатны тайланг аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн гаргана.</p>	<p>62.7. Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.</p>

	<p>12.7. Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>Шаардлага 5. Орлогын хуваарилалт. ОУИТБС нь оролцогчдод орлогыг улсын болон шаардлагатай бол орон нутгийн төсөвт хэрхэн бүртгэгдэж байгааг харуулах, мөн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээн дэх зарцуулалтыг хэрхэн хөглөх орлогын хуваарилалттай холбоотой мэдээллийг ил тод болгохыг шаарддаг. Орлогын хуваарилалттай холбоотой ОУИТБС-ын шаардлагад:</p>	<p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
<p>(5.1) Орлогын хуваарилалт: Хэрэгжүүлэгч улс нь олборлох салбараас олж буй орлогын хуваарилалт, бэлэн болон бэлэн бус орлогын аль нь улсын төсөвт бүртгэгдэж буй талаар, бүртгээгүй тохиолдолд энэхүү орлогын зарцуулалтын тухай тайлбарлах, Баялгийн сан, Ххөгжлийн сан, орон нутгийн засаг захиргаа, төрийн өмчит компани, төсвөөс гадуурх бусад аж ахуйн нэгж гэх мэт тэдгээрийн санхүүгийн тайлантай холбогдох замыг мэдээлэх.</p>	<p>13.6.2. Нэгдсэн тайланд эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай тусгана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>63.5.2. Нэгдсэн тайланд эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай мэдээлнэ.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>

<p>(5.2) Орон нутаг дахь шилжүүлэг. Оолборлох салбараас орсон орлогыг төв болон орон нутгийн төрийн байгууллага хоорондоо шилжүүлвэл тайланд тусгах, орлого хуваах тогтолцоо, томъёо, түүнчлэн төв засгийн газар, агентлагууд болон орон нутгийн хамаарах нэгжүүдийн хоорондын төлбөрийн шилжүүлгийг тухайн томъёог ашиглан тооцсон орлого болон бодит шилжүүлсэн орлогын зөрүү, шилжүүлгийг ил тод болгосон болон боломжтой бол нэгтгэсэн эсэхийг баталгаажуулахыг дэмжих.</p> <p>Орон нутгийн тусгай хөтөлбөрт зарцуулсан салбарын орлого, хөрөнгө оруулалтын зохицуулалт, бодит хуваарилалтын талаар мэдээлж болно.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>(5.3) Орлогын менежмент болон зарцуулалт: Салбараас олсон орлогыг ямар нэг тусгай хөтөлбөр, эсвэл бүс нутагт хуваарилснаа тайлбарлах, аудитын тайланг харах эх үүсвэрийг дурдах, холбогдох мэдээллийг тогтмол өгч байх</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>Шардлага 6. Нийгэм, эдийн засгийн зарцуулалт. ОУИГБС нь олборлох салбар нийгмийн болон эдийн засгийн хүссэн үр дүнд хүргэж, нөлөө үзүүлж байгаа эсэхийг үнэлэхэд оролцогчдод дэмжлэг үзүүлэх зорилгоор орлогын менежмент болон зарцуулалттай холбоотой мэдээллийг ил тод болгохыг хөхиүлэн дэмждэг. Орлогын хуваарилалттай холбоотой ОУИГБС-ын шаардлагад:</p>		

<p>(6.1) Компаниудын нийгмийн болон байгаль орчны зарцуулалт: Нийгмийн хариуцлагын зарцуулалт, тэдгээр мэдээллийг хянан багалаажуулах зохицуулалтыг 4.9-д заасанд нийцүүлэн бий болгох, мөнгөн бус хэлбэрээр олгосон бол хэмжээ, зорилго, хүлээн авагчийг зарлах, хэрэв хуулиар шаарддаг бол тухайн зохицуулалт, гэрээг ил тод болгох</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>61.4.8. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд нөхөн сэргээлт болон хаалтын санд төвлөрүүлж байгаа зардал, түүний зарцуулалт, барьцааны талаарх мэдээлэл, хэмжээ; 62.6.8. Төрийн байгууллагын анхан шатны тайланд уурхай тус бүрээр нөхөн сэргээлтийн зардал, түүний зарцуулалт, барьцааны талаарх мэдээллийг тусгана.</p>
<p>(6.2) Төрийн өмчит аж ахуйн нэгжийн төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр: Төрийн өмчит ААН, тэдгээрийн охин болон хамтарсан компаниас хүлээн авсан адил төстэй төлбөрийн мэдээллийг ил тод болгох, нийгмийн үйлчилгээ, түлшний татаас, нийтийн дэд бүтэц зэрэг улсын төсвөөс санхүүжих хэсгийг ил тод болгох</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>



<p>(6.3) Олборлох салбарын эдийн засагт оруулж буй орлогын дүгнэлт: Дараах мэдээллийг ил болгох:</p> <p>а) олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээг үнэмлэхүй дүнгээр болон түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр илэрхийлэх ба салбарын үйл ажиллагааны албан бус тооцоог багтаасан байх. Бичил болон жижиг уурхай орно, гэвч эдгээрээр хязгаарлагдахгүй.</p> <p>б) олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын (татвар, уурхай олборлосоны төлбөр, шагнал урамшуулал, хураамж болон бусад төлбөрүүд оролцуулан)</p> <p>хэмжээг үнэмлэхүй дүнгээр ба улсын төсөвт эзлэх хувь хэмжээгээр;</p> <p>с) олборлох салбарын хийж буй экспортын хэмжээг үнэмлэхүй дүнгээр болон нийт экспортод эзлэх хувь хэмжээгээр;</p> <p>д) олборлох салбарт бий болгосон ажлын байрны нийт тоог үнэмлэхүй дүнгээр болон нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь хэмжээгээр. Мэдээллийг хүйсээр ангилах, боломжтой бол ААН болон мөргөжлийн түвшнээр ангилах.</p> <p>е) олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа төвлөрөн явагдаж буй гол бүс нутгийн тухай.</p>	<p>13.6.1. Нэгдсэн тайланд улсын эдийн засагт эрдэс салбарын эзлэх хувь хэмжээ;</p> <p>13.6.2. эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай тусгана.</p> <p>11.5.9. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээлэл;</p> <p>12.6.9. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээллийг тусгана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>63.5.1. Нэгдсэн тайланд улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ; 63.5.2. эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай тусгана.</p> <p>61.4.9. Хуулийн этгээд нь анхан шатны тайланд ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээлэл; 62.6.9. Төрийн байгууллагын анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр ажиллах хүч, ажлын байрны талаарх мэдээллийг тусгана.</p> <p>Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>
--	---	--

	Зохицуулалт байхгүй	Зохицуулалт байхгүй
<p>(6.4) Олборлох үйл ажиллагааны байгаль орчны нөлөөлөл: байгаль орчны нөлөөлийн үйл ажиллагаа, хяналтын талаар:</p> <p>а) холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ, холбогдох тайлангийн мэдээлэл;</p> <p>б) байгаль орчны тогтмол хяналтын зохицуулалт, хариуцлагын журам, нөхөн төлбөр, нөхөн сэргээлт, доройтлыг сэргээх хөгөлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгоно.</p> <p>Шаардлага 7. Үр дүн ба үр нөлөөлөл. Олборлох үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг тогтмол ил тод болгосон ч энэ талаарх олон нийтийн мэдлэг, тайлангийн тоо баримт юуг илэрхийлэх талаарх ойлголт, ашигт малтмалын орлогыг хэрхэн үр дүнтэй зарцуулах тухай мэдлэг бага байх нөхцөлд олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулахгүйгээр ач холбогдол багатай. ОУИТБС нь оролцогчдыг байгалийн баялгаас олсон орлогын менежментийн талаарх хэлэлцүүлэгт оролцон, ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн болон үр нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэдэнэ. ОУИТБС-ын тайлан нь өргөн хүрээний олон нийтийн хэлэлцүүлгийг бий болгон, үүнд хувь нэмрээ оруулах замаар ОУИТБС-ын зарчмуудыг биелүүлэхэд түлхэц болно гэж үздэг. Иймд санаачилгын хэрэгжилтийн үеэр авсан сургамжуудад үндэслэн үйл ажиллагаа явуулж, ОУИТБС-ын тайлангаар илэрсэн зөрүүг тайлбарлаж, шаардлагатай бол зөрүүг бууруулах, арилгах арга хэмжээ авч ОУИТБС-ын хэрэгжилтийг тогтвортой, туултай үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэдэнэ.</p>		



<p>(7.1) Олон нийтийн хэлэлцүүлэг: Гол оролцогч тал нь ЗГ, парламент, иргэний нийгэм, ААН ба хэвлэл мэдээлэл байна. ОТОБ нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сэдэвчилсэн судалгаа хийлгэх, олон нийтийн соён гэгээрүүлэх ажлыг орон даяар хийх шаардлагатай. ОТОБ нь мэдээлэл, тайлан, санхүүгийн мэдээллийн дүгнэлт зэргийг тэнцвэртэй мэдээлэлд үндэслэн боловсруулж, эх сурвалжийг тодорхой байдлаар мэдээлж байхыг дэмжинэ. Мэдээллийг ашиглах чадавх бэхжүүлэх.</p>	<p>7.1.3. Үндэсний зөвлөл нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх; 7.1.7. эрдэс баялгийн салбарын ил тод байдлын талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах эрхтэй байна. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>(7.2) Мэдээллийн хүргэмж ба нээлттэй өгөгдөл: Мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байлгахын тулд ОТОБ нь: а) мэдээллийг авч ашиглах, мэдээлэх, дахин ашиглахад хориглолтгүй байх тодорхой зохицуулалт бий болгох; б) мэдээллийг нээлттэй байдлаар CSV эсхүл Excel форматаар цахим хэлбэрээр бүх бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл, тайлангийн хамт хүргэх; в) санхүүгийн жил тус бүрээр мэдээллийг нэгтгэн гаргах; г) автоматаар уншигдах, харилцан мэдээлэл солилцох боломжтой, бусад эх сурвалжтай тулгаж болох хэлбэрээр мэдээллийн системийг бүрдүүлэх.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>

<p>(7.3) ОУИТБС-ын хэрэгжилтээс боловруулсан Зөвлөмж: Нөлөөллийг бэхжүүлэх зорилготойгоор ОТОБ нь авсан сургамжуудаа суурилан үйл ажиллагаа явуулж, тайланд гарч буй зөрүүний учир шалтгааныг тогтоон арга хэмжээ авах, зөвлөмжийг төрийн тогтолцоо, байгалийн Баялгийн засаглалыг сайжруулахад чиглүүлэх, боломжтой бол зөвлөмжийн хэрэгжилтийг хянах.</p>	<p>7.1.9. Үндэсний зөвлөл нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар, маягт, зөвлөмж баглах. Бусад асуудлаар зохицуулалт байхгүй.</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>
<p>(7.4) ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн болон үр нөлөө: ОТОБ нь байгалийн баялгийн засаглалд тайлагналын үр нөлөөг хэмжин:</p> <ul style="list-style-type: none"> i. Өмнөх жилд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнг баримтжуулах; ii. ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшлийн үнэлгээг хийх; iii. 7.3 дахь шаардлагын дагуу ОТОБ нь аудитын нэгтгэл болон баталгаажуулалтын үйл ажиллагаанаас гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаарх тойм, өмнө өгсөн бүх зөвлөмжийг жагсаан, тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ нэг бүрийг дурдана; 	<p>Зохицуулалт байхгүй</p>	<p>Зохицуулалт байхгүй</p>

<p>iv. Ажлын төлөвлөгөөнд дурдсан зорилтуудыг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, Үр дүнгийн үнэлгээ (Шаардлага 1.5), Үүнд тухайн дурдсан зорилтуудын үзүүлсэн Үр дүн болон нөлөөлөл;</p> <p>v. ОУИТБС-ын хэрэгжилтийг бэхжүүлэх чиглэлээр авч буй хүчин чармайлтын тухай тайлан мэдээ, ОУИТБС-ын тайлангийн цар хүрээг өргөжүүлэх, хамтран ажиллах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ. Бүх төлөөлөл нь ОУИТБС-ын Үр нөлөөг үнэлэх үнэлгээнд оролцоно.</p>		
--	--	--

